| ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага | 9.1                          |  | ХДХВ-ийн халдварын талаарх цогц мэдлэг   |                     |           |
|                                       |                              |  | Эмэгтэй (15-49 нас)  | 28.5 хувь           |           |
|                                       |                              |  |  | Эрэгтэй (15-54 нас) | 26.3 хувь |
|                                       | CS.10                        |  | ХДХВ, ДОХ-ын талаар сонсож байсан  |                     |           |
|                                       |                              |  | Эмэгтэй (15-49 нас)  | 92.6 хувь           |           |
|                                       |                              |  |  | Эрэгтэй (15-54 нас) | 88.3 хувь |
|                                       | 9.2                          | 6.3  | ХДХВ-ийн халдварын талаарх цогц мэдлэгтэй залуучууд (15-24 нас)                                |                     |           |
|                                       |                              |  | Эмэгтэй  | 31.6 хувь           |           |
|                                       |                              |  |  | Эрэгтэй             | 29.3 хувь |
|                                       | 9.3                          |  | ХДХВ-ийн халдвар эхээс ураг эсвэл нярайд дамжих 3 замыг мэддэг                                 |                     |           |
|                                       |                              |  | Эмэгтэй (15-49 нас)  | 39.8 хувь           |           |
|                                       |                              |  |  | Эрэгтэй (15-54 нас) | 24.8 хувь |
|                                       | 9.4                          |  | ХДХВ-ийн халдвартай хүнд хандах эерэг хандлага   |                     |           |
|                                       |                              |  | Эмэгтэй (15-49 нас)  | 3.6 хувь            |           |
|                                       |                              |  |  | Эрэгтэй (15-54 нас) | 5.2 хувь  |
|                                       | 9.5                          |  | ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хаана өгөхийг мэддэг                                       |                     |           |
|                                       |                              |  | Эмэгтэй (15-49 нас)  | 69.6 хувь           |           |
|                                       |                              |  |  | Эрэгтэй (15-54 нас) | 62.0 хувь |
| 9.6                                   |                              | ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан  |  |                     |           |
|                                       |                              | Эмэгтэй (15-49 нас)  | 18.9 хувь  |                     |           |
|                                       |                              |  | Эрэгтэй (15-54 нас)  | 11.8 хувь           |           |
| 9.7                                   |                              | Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон бөгөөд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан залуучууд (15-24 нас) |  |                     |           |
|                                       |                              | Эмэгтэй  | 30.7 хувь  |                     |           |
|                                       |                              |  | Эрэгтэй  | 20.7 хувь           |           |
| 9.8                                   |                              |  | Жирэмсний хяналтын хүрээнд ХДХВ-ийн халдварын талаар зөвлөгөө авсан эмэгтэйчүүд                | 39.9 хувь           |           |
| 9.9                                   |                              |  | Жирэмсний хяналтын хүрээнд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан эмэгтэйчүүд | 60.7 хувь           |           |

| Сэдэв  | ХХС-ны үзүүлэлт <sup>1</sup> | МХЗ-ын үзүүлэлт  | Үзүүлэлтийн нэр  | Утга                |      |      |
|--|------------------------------|--|--|---------------------|------|------|
| Бэлгийн зан үйл  | 9.10                         |  | Гэрлэж байгаагүй эсвэл хамтран амьдрагчгүй бөгөөд бэлгийн хавьталд орж байгаагүй залуучууд (15-24 нас)   |                     |      |      |
|  |                              |  | Эмэгтэй  | 68.0                | хувь |      |
|  |                              |  |  | Эрэгтэй             | 46.8 | хувь |
|  | 9.11                         |  | 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон залуучууд (15-24 нас)  |                     |      |      |
|  |                              |  | Эмэгтэй  | 0.2                 | хувь |      |
|  |                              |  |  | Эрэгтэй             | 2.7  | хувь |
|  | 9.12                         |  | Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон бөгөөд өөрөөсөө 10 ба түүнээс дээш насаар ах/эгч хүнтэй бэлгийн хавьталд орсон залуучууд (15-24 нас) |                     |      |      |
|  |                              |  | Эмэгтэй  | 2.0                 | хувь |      |
|  |                              |  |  | Эрэгтэй             | 0.0  | хувь |
|  | 9.13                         |  | Сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон   |                     |      |      |
|  |                              |  | Эмэгтэй (15-49 нас)  | 1.0                 | хувь |      |
|  |                              |  |  | Эрэгтэй (15-54 нас) | 8.0  | хувь |
|  | 9.14                         |  | Сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон бөгөөд хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн                  |                     |      |      |
|  |                              |  | Эмэгтэй (15-49 нас)  | 43.5                | хувь |      |
|  |                              |  |  | Эрэгтэй (15-54 нас) | 47.3 | хувь |
|  | 9.15                         |  | Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон бөгөөд тохиолдлын бэлгийн хавьталд орсон залуучууд (15-24 нас)                                       |                     |      |      |
| Эмэгтэй  |                              |  | 42.7   | хувь                |      |      |
|  |                              |  | Эрэгтэй  | 73.5                | хувь |      |
| 9.16   | 6.2                          | Сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон бөгөөд хамгийн сүүлд тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн залуучууд (15-24 нас) |  |                     |      |      |
|  |                              | Эмэгтэй  | 53.8   | хувь                |      |      |
|  |                              |  | Эрэгтэй  | 75.4                | хувь |      |
| <b>ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ ТЕХНОЛОГИ</b> |                              |  |  |                     |      |      |
| Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл   | МТ.1                         |  | Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ  |                     |      |      |
|  |                              |  | Эмэгтэй (15-49 нас)  | 23.4                | хувь |      |
|  |                              |  | Эрэгтэй (15-54 нас)  | 23.6                | хувь |      |
| Мэдээлэл, харилцааны технологи   | МТ.2                         |  | Сүүлийн 12 сарын хугацаанд компьютер хэрэглэсэн залуучууд (15-24 нас)  |                     |      |      |
|  |                              |  | Эмэгтэй  | 72.0                | хувь |      |
|  |                              |  |  | Эрэгтэй             | 72.1 | хувь |
|  | МТ.3                         |  | Сүүлийн 12 сарын хугацаанд интернэт хэрэглэсэн залуучууд (15-24 нас)   |                     |      |      |
|  |                              |  | Эмэгтэй  | 59.2                | хувь |      |
|  |                              |  | Эрэгтэй  | 59.6                | хувь |      |

| Сэдэв                                  | ХХС-ны үзүүлэлт <sup>1</sup> | МХЗ-ын үзүүлэлт  | Үзүүлэлтийн нэр | Утга |
|--|------------------------------|--|-----------------|------|
| <b>АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ</b>         |                              |  |                 |      |
| Амьдралын сэтгэл ханамж                | SW.1                         | Амьдралдаа сэтгэл хангалуун залуучууд (15-24 нас)  |                 |      |
|  |                              | Эмэгтэй  | 64.3            | хувь |
|  | SW.2                         | Өөрийгөө жаргалтай гэж боддог залуучууд (15-24 нас)  |                 |      |
|  |                              | Эмэгтэй  | 85.9            | хувь |
|  | SW.3                         | Сүүлийн 1 жилд амьдралаа сайжирсан гэж үзсэн бөгөөд ирэх 1 жилд амьдралаа сайжирна гэж үзсэн залуучууд (15-24 нас) |                 |      |
|  |                              | Эмэгтэй  | 52.8            | хувь |
|  |                              | Эрэгтэй  | 51.5            | хувь |
| <b>ТАМХИ, АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДАА</b> |                              |  |                 |      |
| Тамхины хэрэглээ                       | 12.1                         | Сүүлийн 1 сарын хугацаанд тамхи татсан   |                 |      |
|  |                              | Эмэгтэй (15-49 нас)  | 6.4             | хувь |
|  | 12.2                         | 15 нас хүрэхээсээ өмнө тамхи татаж үзсэн   |                 |      |
|  |                              | Эмэгтэй (15-49 нас)  | 0.6             | хувь |
|  |                              | Эрэгтэй (15-54 нас)  | 15.9            | хувь |
| Архи, согтууруулах ундааны хэрэглээ    | 12.3                         | Сүүлийн 1 сарын хугацаанд архи, согтууруулах ундаа уусан   |                 |      |
|  |                              | Эмэгтэй (15-49 нас)  | 22.2            | хувь |
|  | 12.4                         | 15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үзсэн  |                 |      |
|  |                              | Эмэгтэй (15-49 нас)  | 0.2             | хувь |
|  |                              | Эрэгтэй (15-54 нас)  | 2.7             | хувь |

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

---

Монгол Улсын "Хүүхэд хөгжил-2010" судалгаа нь өрх, 15-49 насны эмэгтэйчүүд, 15-54 насны эрэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдийн үндэсний төлөөлөл бүхий түүвэр судалгаа юм. "Хүүхэд хөгжил-2010" судалгааг Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь НҮБ-ын Хүүхдийн Сан (НҮБХС)-гийн санхүү, техникийн тусламжтайгаар зохион байгуулж явууллаа. Судалгааны үр дүн нь мэдээлэл цуглуулсан хугацаа болох 2010 оны 9-12 сард хамаарч байгаа юм. Судалгааны үндсэн үр дүнг нэгтгэн танилцуулья.

### Хүүхдийн эндэгдэл

- Монгол Улсад нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 36, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 45 байна. Хүүхдийн эндэгдэл хөдөөд хотоос бараг 2 дахин өндөр байна. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл хотод 24 байхад хөдөөд 48, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл хотод 29 байхад хөдөөд 62 байна.

### Хоол тэжээлийн байдал

- Тав хүртэлх насны хүүхдийн 3 хувь нь тураалтай, 15 хувь нь өсөлт хоцролттой, 2 хувь нь туранхай байна.
- Баруун болон Хангайн бүсийн 5 хүртэлх насны хүүхдийн дунд өсөлт хоцролт хамгийн их (18-25 хувь) байхад Улаанбаатар хот болон Төвийн бүсэд хамгийн бага (11-13 хувь) байна.
- Дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдийн 1 хувь нь тураалтай, 7 хувь нь өсөлт хоцролттой байхад доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдийн хувьд 5 ба 25 хувь байна.

### Эхийн сүүгээр хооллолт

- Хүүхдийг 6 сар хүртэл нь дан эхийн сүүгээр хооллохыг зөвлөдөг боловч энэ насны хүүхдийн 66 хувь нь судалгаанаас өмнөх 1 хоногт дан эхийн сүүгээр хооллож байна.
- Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 10 эмэгтэй тутмын 7 нь төрсний дараах 1 цагийн дотор хүүхэддээ ангир уургаа амлуулжээ.
- 12-15 сартай хүүхдийн 82 хувь, 20-23 сартай хүүхдийн 65 хувь нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байв.
- Судалгаанаас өмнөх 1 хоногт 6-23 сартай хүүхдийн 30 хувь нь нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж байна.

### Бага жинтэй төрөлт

- 0-23 сартай нийт хүүхдийн 98 хувийг төрөхөд нь жинлэсэн бөгөөд тэдний 5 хувь нь 2500 граммаас бага жинтэй төржээ.

### Дархлаажуулалт

- 12-23 сартай хүүхдүүдийн 98 хувь нь 12 сар хүрэхээсээ өмнө сүрьеэгийн вакцинг хийлгэсэн байна. Саагийн эсрэг вакцины төрөх үеийн тунд хамрагдалт 98 хувь, 1-р тунд хамрагдалт 98 хувь, 2-р тунд хамрагдалт 96 хувь, 3-р тунд хамрагдалт 93 хувь болж буурчээ. Гуравт болон тавт вакцины 1-р тунд хамрагдалт 96 хувь, 2-р тунд хамрагдалт 94 хувь, 3-р тунд хамрагдалт 92 хувьтай байлаа.
- 12-23 сартай хүүхдүүдийн 97 хувь нь 1 нас хүрэхээсээ өмнө гепатит Б-гийн эсрэг төрөх үеийн тунг хийлгэжээ. Улаанбурхан, улаанууд, гахайн хавдрын эсрэг вакцины 1-р тунд 12 сар хүрэхээсээ өмнө хамрагдсан хүүхдийн хувь бусад вакцинуудтай харьцуулахад

бага байв. 1 нас хүрэхээсээ өмнө хийлгэвэл зохих бүх вакциныг хийлгэсэн хүүхдийн хувь 76 хувьтай байна.

### **Шингэн сэлбэх эмчилгээ**

- Судалгаанаас өмнөх 14 хоногийн хугацаанд 5 хүртэлх насны хүүхдийн 10 хувь нь суулгалт өвчнөөр өвдсөн байна.
- Суулгалт өвчнөөр өвдсөн хүүхдүүдийн 56 хувьд нь шингэн сэлбэх эмчилгээ хийхийн зэрэгцээ үргэлжлүүлэн хооллосон байна.
- Суулгалт өвчнөөр өвдсөн хүүхдүүдийн 43 хувь нь ердийнхөөс илүү их шингэн уусан ба 56 хувь нь ердийнхтэй адил эсвэл бага хэмжээгээр шингэн уусан байна. Харин хүүхдүүдийн 90 хувь нь бага эсвэл ердийнхтэй адил эсвэл ердийнхөөс их хэмжээгээр хооллож, 4 хувь нь маш бага буюу бараг хоол идээгүй гэсэн байна.

### **Хатгалгааны үед антибиотик хэрэглэх ба тусламж хайх**

- Судалгааны өмнөх 14 хоногт 5 хүртэлх насны нийт хүүхдийн 2 хувьд нь хатгалгааны шинж тэмдэг илэрсэн байв. Тэдний 87 хувь нь зохих тусламж авчээ. Түүнчлэн, уушгины хатгалгаа өвчний шинж тэмдэг илэрсэн байж болзошгүй нийт хүүхдийн 73 хувь нь антибиотик эмчилгээ хийлгэсэн байна.
- Нийт эхчүүдийн ердөө 1 хувь нь хатгалгааны үеийн аюултай 2 шинж болох амьсгал олшрох, амьсгал саадтай болохыг мэдэж байлаа. Хүүхдийг эмнэлэгт яаралтай үзүүлдэг хамгийн түгээмэл шинж тэмдэг нь халууралт (74 хувь) байв. Эхчүүдийн 4 хувь нь амьсгал олширвол, 3 хувь нь амьсгал саадтай болбол яаралтай эмнэлэгт ханддаг гэж хариулжээ.

### **Хатуу түлшний хэрэглээ**

- Монголын айл өрхийн 68 хувь нь хоол, ундаа болгохдоо хатуу түлш хэрэглэж байна. Хотын өрхүүдийн 54 хувь нь хатуу түлш хэрэглэж байхад хөдөөд хатуу түлшний хэрэглээ маш өндөр (90 хувь) байгаа юм.

### **Ус, ариун цэврийн байгууламж**

- Монгол Улсын нийт хүн амын 65 хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэр ашиглаж байгаа бөгөөд хөдөөд (59 хувь) ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээ хотынхоос (69 хувь) доогуур түвшинд байна.
- Хангайн бүсийн хувьд бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур түвшинд буюу хүн амын тал хүрэхгүй (48 хувь) хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэр ашиглаж байна.
- Монгол Улсын нийт хүн амын 54 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг байна. Хотын хүн амын 66 хувь, хөдөөгийн хүн амын 36 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж байна.

### **Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ**

- Гэр бүлтэй, хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 97 хувь нь жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл (ЖСАХ) мэддэг байна.
- Гэр бүлтэй, хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 55 хувь нь одоогийн байдлаар жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл (ЖСАХ) хэрэглэж байгаа гэжээ. Монголд хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга нь ерөндөг бөгөөд гэр бүлтэй, хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 23 хувь нь хэрэглэж байна. Үүний дараагаар эм уух бөгөөд гэр бүлтэй, хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 12 хувь нь хэрэглэдэг байна.
- ЖСАХ-ийн хэрэглээ Зүүн бүсэд хамгийн өндөр (64 хувь) байна. Улаанбаатарт ЖСАХ-ийн хэрэглээ бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур буюу 52 хувь байлаа.

- Судалгааны дүнгээс харахад гэр бүлтэй, хамтран амьдрагчтай нийт эмэгтэйчүүдийн 22 хувийнх нь ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдаагүй байна.

### **Жирэмсэн үеийн хяналт**

- Жирэмсний хяналтын хүрээнд мэргэжлийн эмчид (эмч, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, сувилагч) үзүүлэх нь Монголд харьцангуй өндөр бөгөөд эмэгтэйчүүдийн 99 хувь нь наад зах нь нэг удаа мэргэжлийн эмчид, 4 ба түүнээс олон удаа 81 хувь нь (жирэмсний хяналтад) хамрагдсан байна.

### **Төрөх үеийн тусламж**

- Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн 99 хувь нь мэргэжлийн эмчийн хяналтад хүүхдээ төрүүлжээ. Нийт төрөлтийн 69 хувь нь эх баригч их эмчийн, 26 хувь нь эх баригчийн, 3 хувь нь өрх/ сумын их эмчийн хяналтад явагдсан байна.
- Хотын эмэгтэйчүүдийн 73 хувь нь эх баригч их эмчийн хяналтад хүүхдээ төрүүлсэн байхад хөдөөгийн эмэгтэйчүүдийн 64 хувь нь эх баригч их эмчийн хяналтад хүүхдээ төрүүлжээ.
- Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн 21 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна. Мэс заслын аргаар хүүхдээ төрүүлэх нь хотын эмэгтэйчүүдийн дунд хөдөөгийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү түгээмэл (23 ба 17 хувь) байна.
- Нас ахих тусам мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 20 хүртэлх насны 10 эмэгтэй тутмын 1 нь, 20-34 насны 5 эмэгтэй тутмын 1 нь, 35-49 насны 3 эмэгтэй тутмын 1 нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлжээ.

### **Хүүхдийн хөгжил**

- Судалгаанаас өмнөх 3 хоногийн хугацаанд судалгаанд хамрагдсан 3-4 насны хүүхдүүдийн 57 хувьд нь өрхийн насанд хүрсэн гишүүд аливаа зүйлийг танин мэдэх, сурахад нь 4 ба түүнээс олон удаа дэмжлэг үзүүлсэн байна. Гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдүүдэд анхаарал тавьж дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны дундаж тоо 3.7 байна.
- Харин аавуудын 39 хувь нь хүүхдээ аливаа зүйлийг танин мэдэх, сурахад нь 1 ба түүнээс олон удаа тусалж, дэмжлэг үзүүлжээ. Мөн 3-4 насны нийт хүүхдийн 18 хувийнх нь эцэг хамт амьдардаггүй байна.
- 0-59 сартай хүүхдүүдийн 23 хувь нь гэртээ 3 ба түүнээс олон хүүхдийн номтой, 7 хувь нь 10 ба түүнээс олон хүүхдийн номтой байна. 3 ба түүнээс олон хүүхдийн номтой 5 хүртэлх насны хүүхэд Улаанбаатар хотод хамгийн их (33 хувь) байхад Хангайн бүсэд хамгийн бага буюу 12 хувь байна.

### **Бага насны хүүхдийн хөгжлийн индекс (БНХХИ)**

- Монгол Улсын 3-4 насны хүүхдийн хөгжлийн индекс 85 хувь байна. Энэ индекс охид (90 хувь)-ын хувьд хөвгүүд (81 хувь)-ийнхээс 9 пунктээр дээгүүр байна.
- БНХХИ-ийг нарийвчлан авч үзвэл бие бялдрын хөгжил болон сурах чадвар нь зохих хэмжээнд байгаа хүүхдийн хувь хамгийн их (97 ба 96 хувь), нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа хүүхдийн хувь 84, харин унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа хүүхдийн хувь 15 байна.



## Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт ба сургуульд бэлтгэгдсэн байдал

- Улсын хэмжээнд 36-59 сартай нийт хүүхдийн 58 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна. Хамрагдалт хотод 68 хувь, хөдөөд 45 хувьтай байлаа.
- СӨБ-д хамрагдалт дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн хувьд 80 хувьтай байхад доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн хувьд ердөө 25 хувьтай байна. Уг үзүүлэлтийг бүсээр авч үзвэл Баруун болон Хангайн бүсэд (50 хувь) бусад бүстэй (61-65 хувь) харьцуулахад доогуур байна.
- Судалгааны үед 1-р ангид сурч байсан хүүхдүүдийн 91 хувь нь өмнөх хичээлийн жилд цэцэрлэг эсвэл хувилбарт сургалтад хамрагдаж байсан байна.
- Сургуульд бэлтгэгдсэн байдал нь хүйс болон хот, хөдөөгөөр төдийлөн ялгаагүй боловч бүс болон өрхийн аж байдлаар ялгаатай байгаа юм.

## Бага болон суурь боловсролд хамрагдалт

- Бага боловсролын хамран сургалт 99 хувь байгаа бөгөөд энэ нь охид, хөвгүүдийн хувьд бараг ялгаагүй байна.
- Дунд сургуульд суралцах насны буюу 12-15 насны хүүхдүүдийн 93 хувь нь зохих шатны сургуульд хамрагдан суралцаж байна.
- Бага сургуулийн 1-р ангид элсэн орсон хүүхдүүдийн 99 хувь нь 5-р анги хүртэл тасралтгүй анги дэвшин суралцаж байгаа бөгөөд энэ нь хотод 100 хувь, хөдөөд 97 хувь байна.

## Төрсний бүртгэл

- Манай улсад 5 хүртэлх насны нийт хүүхдийн төрсний бүртгэлд хамрагдалт 99 хувьтай байна.
- Хүүхдийн төрсний бүртгэлд хамрагдалт нь хот, хөдөө, бүс, өрхийн аж байдлаар ялгаагүй байв.

## Хүүхдийн хөдөлмөр

- НҮБ-ын Хүүхдийн сангийн шинэчилсэн тодорхойлолтоор 5-11 насны хүүхдүүдийн 34 хувь, 12-14 насны хүүхдүүдийн 18 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Судалгааны үр дүнгээр 5-14 насны нийт хүүхдийн дунд хөдөлмөр эрхлэлт 29 хувь байна. Монгол Улсын хувьд өрхийн хэрэгцээнд зориулж ус зөөх, түлээ түлш бэлтгэх үйл ажиллагааг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулахгүйгээр гэрийн ажил гэж үздэг. Тиймээс өөрийн орны онцлогт суурилж тооцвол 5-14 насны хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлт 10 хувьтай, 5-11 насны хүүхдийнх 8 хувьтай, 12-14 насны хүүхдийн 16 хувьтай байгаа юм.

## Хүүхдийн хүмүүжил

- 2-14 насны нийт хүүхдийн 46 хувь нь гэр бүлийн гишүүдийн зүгээс сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэлийг ямар нэг байдлаар хүлээсэн байна.
- Өрхийн асуулгад хамрагдсан 2-14 насны хүүхэдтэй өрхийн насанд хүрэгчдийн 16 хувь нь хүүхдийг хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэлийг хэрэглэж болно гэж үздэгээ илэрхийлжээ.

## Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага

- Монголын 15-49 насны эмэгтэйчүүдийн (15-54 насны эрэгтэйчүүдийн) 11 хувь (10 хувь) нь нөхөр нь эхнэрээ тодорхой шалтгааны улмаас цохиж зодож болно гэж үздэг байна.
- Эмэгтэйчүүдийн дунд эхнэр нь хүүхэддээ анхаарал тавихгүй байх (9 хувь) эсвэл дур мэдэн их хэмжээний мөнгөөр худалдан авалт хийсэн тохиолдолд (3 хувь) нөхөр нь эхнэрээ цохиж зодож болно гэж үзэх нь их байна.

- Эрэгтэйчүүдийн дунд ч мөн адил дээрх 2 шалтгаан хамгийн өндөр (6 болон 4 хувь) байгаа юм.

### **ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадал**

- Монгол Улсад 15-49 насны эмэгтэйчүүдийн 29 хувь, 15-54 насны эрэгтэйчүүдийн 26 хувь нь ХДХВ-ийн халдварын талаарх цогц мэдлэгтэй байна. Цогц мэдлэгийн түвшин 15-24 насны залуу эмэгтэйчүүдийн хувьд 32, эрэгтэйчүүдийн хувьд 29 хувь байна.
- 15-49 насны эмэгтэйчүүдийн 93 хувь, 15-54 насны эрэгтэйчүүдийн 88 хувь нь ХДХВ, ДОХ-ын талаар сонсчээ. Гэсэн хэдий ч ХДХВ-ийн халдвараас сэргийлэх 2 аргыг мэддэг эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн хувь харьцангуй бага буюу харгалзан 72 болон 71 хувь байв.
- Нийтлэг байдаг ташаа 2 ойлголтыг няцаасан (34 хувь) болон ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг (79 хувь) эмэгтэйчүүдийн хувь ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргын мэдлэгийн түвшинтэй адилаар эрэгтэйчүүдийнхээс илүү байна.
- Эмэгтэйчүүдийн 79 хувь нь ХДХВ-ийн халдвар эхээс ураг, нярайд халдварлах боломжтой гэдгийг мэдэж байхад эрэгтэйчүүд харьцангуй доогуур буюу 68 хувь нь мэддэг байна. ХДХВ-ийн халдвар эхээс ураг, нярайд халдварлах 3 замыг гурвууланг нь эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) 40 хувь (25 хувь) мэддэг байхад эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) 13 хувь (21 хувь) нь халдвар дамжих аль ч замыг мэддэггүй байна.
- 15-49 насны эмэгтэйчүүдийн 4 хувь, 15-54 насны эрэгтэйчүүдийн 5 хувь нь ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хүмүүст хандах хандлагыг тодорхойлох 4 төрлийн асуултад бүгдэд нь хүлээн зөвшөөрсөн хариулт өгч байгаа нь хангалтгүй үзүүлэлт бөгөөд манай улсад ДОХ-той хүмүүст эергээр хандах хандлага маш доогуур байгааг харуулж байна.
- ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрыг 15-49 насны эмэгтэйчүүдийн 70 хувь, 15-54 насны эрэгтэйчүүдийн 62 хувь нь мэддэг байна. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн 19 хувь, эрэгтэйчүүдийн 12 хувь нь судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд уг шинжилгээг өгч, хариугаа авсан байна.

### **Бэлгийн зан үйл**

- 15-24 насны эрэгтэйчүүдийн 13 хувь, эмэгтэйчүүдийн 1 хувь нь судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд оржээ. Нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон залуу эрэгтэйчүүдийн 69 хувь нь хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна.
- 15-24 насны эрэгтэйчүүдийн 3 хувь, эмэгтэйчүүдийн 1 хүрэхгүй хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон ба сүүлийн 12 сард энэ насны залуу эмэгтэйчүүдийн 2 хувь нь өөрөөсөө 10 ба түүнээс дээш насаар ах хүнтэй бэлгийн хавьталд орсон байна.

### **Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл харилцааны технологийн хүртээмж**

- Эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) 23 хувь (24 хувь) нь долоо хоногт наад зах нь 1 удаа сонин уншиж, 1 удаа FM, радио сонсож, 1 удаа телевиз үздэг байхад 3 хувь (2 хувь) нь алийг нь ч хэрэглэдэггүй байна.
- 15-24 насны эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) 84 хувь (79 хувь) нь компьютер хэрэглэж байсан, 72 хувь (72 хувь) нь сүүлийн 1 жилд хэрэглэсэн, 55 хувь (59 хувь) нь сүүлийн 1 сарын хугацаанд долоо хоног бүр хэрэглэсэн байна. 15-24 насны эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) 68 хувь (66 хувь) нь интернэт хэрэглэж үзсэн бөгөөд сүүлийн нэг жилд 59 хувь (60 хувь) нь хэрэглэжээ. Интернэтийг сүүлийн 1 сарын хугацаанд долоо хоног

бүр хэрэглэсэн залуу эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) хувь харьцангуй бага буюу 43 хувь (47 хувь) байна.

### **Тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ**

- Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн 26 хувь, 15-54 насны нийт эрэгтэйчүүдийн 81 хувь нь тамхи татаж үзсэн байна. Эмэгтэйчүүдийн 6 хувь, эрэгтэйчүүдийн 54 хувь нь судалгаанаас өмнөх 1 сарын хугацаанд янжуур, бусад утаатай болон утаагүй тамхийг татжээ.
- Тамхи татдаг эрэгтэйчүүд хот, хөдөөд (54-56 хувь) ижил түвшинтэй байхад хотын эмэгтэйчүүдийн (8 хувь) дунд тамхи татах нь хөдөөгийн эмэгтэйчүүдийнхээс (3 хувь) илүү буюу 2.4 дахин их байна.
- 15-54 насны эрэгтэйчүүдийн 49 хувь, 15-49 насны эмэгтэйчүүдийн 22 хувь нь сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа уусан байна.
- Эрэгтэйчүүдийн 3 хувь, эмэгтэйчүүдийн 1 хүрэхгүй хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө архи ууж үзжээ.
- Архи, согтууруулах ундааны хэрэглээ хотын болон чинээлэг өрхийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дунд илүү их байна.

### **Амьдралын сайн сайхан байдал**

- 15-24 насны залуу эмэгтэйчүүд өөрийн гэр бүл (93 хувь), сурч байгаа сургууль (91 хувь) болон найз, нөхөрлөлдөө (90 хувь) маш их сэтгэл хангалуун байна. Залуу эрэгтэйчүүдийн хувьд ч мөн адил өөрийн гэр бүл (96 хувь), найз, нөхөрлөл (93 хувь) болон өөртөө (91 хувь) маш их сэтгэл хангалуун байдаг байна.
- 15-24 насны залуу эмэгтэйчүүдийн 64 хувь, эрэгтэйчүүдийн 65 хувь нь амьдралдаа сэтгэл хангалуун байгаа гэж хариулжээ.
- 15-24 насны өөрийгөө аз жаргалтай гэж үздэг залуу эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхтэй ойролцоо (84 хувь, 86 хувь) байв.
- 15-24 насны залуучуудын 54 хувь нь судалгаанаас өмнөх 1 жилийн хугацаанд амьдралаа сайжирсан гэж хариулсан боловч залуу эрэгтэйчүүдийн 86 хувь, эмэгтэйчүүдийн 92 хувь нь ирэх нэг жилд амьдралаа сайжирна гэсэн итгэлтэй байлаа.



**БҮЛЭГ I**

**ТАНИЛЦУУЛГА**

---

# I

---

Энэхүү тайлан нь Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран 2010 онд явуулсан Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС)-ны үр дүнгийн тайлан юм. Энэ судалгаагаар Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг үнэлэх үнэ цэнэтэй мэдээллийг гаргахын зэрэгцээ 2000 оны 9 сард НҮБ-ын 191 гишүүн орон баталсан Мянганы Тунхаглал, 2002 оны 5 сард хуралдаж, НҮБ-ын 189 гишүүн орон оролцсон хүүхдийн асуудлаарх НҮБ-ын тусгай чуулганы "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалын үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрт дэвшүүлсэн зорилго, зорилтууд хэрхэн хэрэгжиж байгааг дүгнэх хэрэгцээнд үндэслэн энэхүү судалгааг явуулсан юм.

Хүүхдийн төлөө дэлхийн дээд хэмжээний 1990 оны уулзалтаар олон улсын хамтын нийгэмлэгээс дэвшүүлсэн амлалтыг хэрэгжүүлэх зорилгоор дээрх баримт бичгүүдийг баталсан билээ.

Улс орнуудын Засгийн Газар хүүхдийн амьдрах ахуй нөхцлийг сайжруулахын төлөө дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх явцыг хянаж байх үүрэг хүлээж дээрх олон улсын гэрээнд гарын үсэг зурсан юм. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн Сан дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн байдаг (Доорх хүснэгтийг үзнэ үү).

## **Үйл ажиллагааны амлалт: Үндэсний болон олон улсын түвшинд тайлагнах үүрэг хариуцлага**

"Мянганы Тунхаглал", "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглал, "Үйл ажиллагааны хөтөлбөр"-т нэгдэн гарын үсэг зурсан Засгийн Газрууд дэвшүүлсэн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хянаж байна гэдгээ амласан. Үүнд:

"Бид хөгжлийн төлөө зорилтуудыг үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дэлхий нийт, бүс нутаг, үндэсний түвшинд үнэлж, үндэсний болон боломжтой бол орон нутгийн түвшинд тогтмол хянах болно. Үүний тулд Үндэсний статистикийн байгууллагын хувьд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хүйс, нас, бусад ялгавартай шинж тэмдгүүдээр илэрхийлэх, хүчин зүйлүүдээр задлан мэдээлэх боломжийг сайжруулж, хүүхдэд чиглэсэн судалгаа шинжилгээг өргөн хүрээтэй дэмжих болно. Бид статистикийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, төлөвлөлт, үнэлгээ, хяналтад оролцох олон нийтийн чадавхийг бий болгоно. (Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, 60-р зүйл)

"...Үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд учирч байгаа хүндрэлийг шийдэхийн тулд бид үндэсний болон орон нутгийн түвшинд явц байдлыг тогтмол авч үзэж байх болно ..." (Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, 61-р зүйл)

Үйл ажиллагааны хөтөлбөрийн ( 61-р зүйл) явцын тайланг бэлтгэхэд НҮБ-ын Хүүхдийн Санг тусгайлан оролцохыг уриалахдаа:

Тунхаглалын болон үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг бэлтгэх, тархаахад Засгийн газрууд, сан, хөтөлбөрүүд түүнчлэн НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, бусад талуудтай нягт хамтран ажиллахыг НҮБ-ын Хүүхдийн Сангаас хүүхдийн төлөө дэлхийн тэргүүлэх байгууллагынх нь хувьд хүссэн.

Үүний адилаар Мянганы тунхаглал (31-р зүйл)-д "... Бид тунхаглалын хэрэгжилтэд гарч байгаа ахиц дэвшлийг тогтмол авч үзэж байхыг Ерөнхий Ассемблейгээс хүсэхийн сацуу Ерөнхий нарийн бичгийн даргаас энэ талаар Ерөнхий Ассемблейд цаашдын үйл ажиллагааны талаар тогтмол илтгэж байхыг хүсэж байна" гэжээ.

Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд үндэсний хөгжлийн стратеги, хөтөлбөрүүд тухайлбал, Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Мянганы хөгжлийн үндэсний зорилтуудыг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг бөгөөд дөрөв дэх удаагийн ОУБТС нь дээрх зорилтуудын хэрэгжилтийг хянаж үнэлгээ өгөх мэдээллийн томоохон эх үүсвэрийн нэг болох юм.

Энэхүү тайланд судалгааны хамарсан сэдвүүд болон үзүүлэлтийн үр дүнг танилцуулах болно.

### Судалгааны зорилго

Монгол Улсын "Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа 2010" -ын үндсэн зорилго нь:

- Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн байдалд үнэлгээ өгөх шинэчилсэн мэдээллээр хангах;
- Мянганы тунхаглал болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн бусад зорилтуудын хэрэгжилтэд хяналт үнэлгээ өгөхөд хэрэглэгдэх суурь мэдээллийг баяжуулах;
- Монгол Улсад мэдээлэл, хяналтын системийг сайжруулах, энэхүү системийн боловсон хүчний төлөвлөлт, хэрэгжилт, дүн шинжилгээ хийх чадавхийг дээшлүүлэх;
- Хүүхэд, эмэгтэйчүүдийн байдлын талаар мэдээлэл бий болгох, эмзэг бүлэг болон ялгаатай байдлыг тодорхойлж, бодлого боловсруулагчдад энэ талаарх мэдээллийг өгөхөд оршино.





# БҮЛЭГ II

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТҮҮВЭРЛЭЛТ



© Үндэсний Статистикийн Хороо, /Н.Амарбаясгалан/ 2010 он

---

## II

---

### Түүврийн загвар

Хүүхэд хөгжил судалгаа нь өрхөд суурилсан судалгаа учир түүврийн нэгж нь өрх юм. Судалгааны түүвэрлэлтийн зорилго нь хүүхэд, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаарх үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд, 5 бүс болон хот, хөдөөгөөр тооцоход чиглэгдсэн. Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар гэсэн 5 бүсийг түүврийн бүлэг болгон авч, бүс тус бүрийг дотор нь хот, хөдөөгөөр бүлэглэн 2 шатат түүврийн аргыг ашигласан. Түүврийн хэмжээг улсын хэмжээнд 10500 өрх байхаар тодорхойлж, бүс тус бүрээс сонгох түүврийн тоог бүсүүдэд тэгш хуваарилсан.

Түүврийн анхан шатны нэгжээр засаг захиргааны хамгийн бага нэгж (Улаанбаатар хотод хорооны хэсэг, аймгуудад сумын баг)-ийг сонголоо. Улсын хэмжээнд нийт 420 баг, хэсгийг системчилсэн пропорциональ магадлалт түүврийн аргаар сонгосон. Судалгааны түүврийн анхан шатны нэгж буюу сонгогдсон баг, хэсгийн өрхийн жагсаалтыг нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсээс авч, өрхийн жагсаалтаас 25 өрхийг системчилсэн санамсаргүй түүврийн аргаар сонгосон.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад буюу 2010 оны 9-11 сард Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт мал, амьтны халдварт шүлхий өвчин гарч, Улсын Онцгой байдлын комиссоос хөл хорио тогтоож, судалгааны мэдээлэл цуглуулах явцад бэрхшээл учирсан хэдий ч тэдгээр аймгаас судалгааны мэдээллийг бүрэн цуглуулж чадсан. Ийнхүү судалгаанд сонгогдсон 420 нэгжийг судалгаанд бүрэн хамруулсан юм.

Түүвэрт сонгогдсон өрхүүдээс мэдээллийг цуглуулж, судалгааны үр дүнгийн боловсруулалтыг үндэсний түвшинд хийхдээ түүврийн жинг ашигласан. Судалгааны түүвэрлэлттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт А-аас үзнэ үү.

### Асуулга

Судалгааны асуулгыг боловсруулахдаа судалгааны зорилго, хамрах хүрээг харгалзан НҮБХС-гаас зөвлөмж болгосон стандарт<sup>2</sup> 3 асуулгыг суурь болгон ашиглаж, өөрийн орны онцлогийг тусгасан. Мөн асуулга, түүнд орох асуулт, үзүүлэлтийг боловсруулахдаа өмнөх судалгаатай болон олон улсын түвшинд харьцуулагдах чанарыг алдагдуулахгүй байх зарчмыг баримталсан. Өнөөгийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн энэ удаагийн судалгаанд 15-54 насны эрэгтэйн болон 2-14 насны хүүхдийн асуулгыг шинээр боловсруулж нэмж оруулсан. Судалгаанд хамруулсан насны бүлэг (15-54 нас) нь ОУБТС-4-ийн стандарт асуулгын насны бүлгээс ялгаатай байгаа болно. Энэ нь "Хүүхэд хөгжил-2010" судалгааны асуулгын хуудсыг боловсруулах үед эрэгтэйчүүдийн стандарт асуулга байгаагүйтэй холбоотой юм.

5 төрлийн асуулгын хуудас:

1. Өрхийн асуулга
2. 15-49 насны эмэгтэйн асуулга
3. 5 хүртэлх насны хүүхдийн асуулга

---

<sup>2</sup> ОУБТС-ны стандарт асуулгыг [www.childinfo.org/mics4\\_questionnaire.html](http://www.childinfo.org/mics4_questionnaire.html) цахим хуудсаас харж болно.

4. 2-14 насны хүүхдийн асуулга<sup>3</sup>

5. 15-54 насны эрэгтэйн асуулга

Асуулгын хуудасны асуултын ойлгомжтой байдал, асуулт хоорондын уялдаа холбоо, нэг өрхөөс судалгаа авахад зарцуулах дундаж хугацааг тодорхойлох, мэдээллийг компьютерт оруулах программыг турших зорилгоор туршилтын судалгааг Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүрэг болон Хэнтий аймгийн Хэрлэн, Дадал суманд 2010 оны 5 сард зохион байгуулж явуулсан. Туршилтын судалгааны үр дүнд тулгуурлан асуулгын хуудсанд утга найруулгын засвар хийж, асуулт хоорондын уялдааг сайжруулж боловсруулсан.

Судалгааны баг асуулга авахаас гадна өрхийн хоолондоо хэрэглэж буй давсны иодын агууламжийг шалгаж, гар угаах газрыг ажиглаж, 5 хүртэлх насны хүүхдийн өндөр, жингийн хэмжилтийг хийсэн. Эдгээр хэмжилт, ажиглалт нь асуулгын хуудасны холбогдох бүлгүүдэд тусгагдсан болно.

Өрхийн асуулга дараах бүлгүүдтэй:

- Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл
- Өрхийн гишүүдийн боловсрол
- Ус болон ариун цэврийн байгууламжийн хангамж
- Өрхийн зарим үзүүлэлт
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт
- Хүүхдийн хүмүүжил
- Гар угаах газар
- Иоджуулсан давсны хэрэглээ

Судалгаанд хамрагдсан өрхийн 15-49 насны бүх эмэгтэйг "Эмэгтэйн асуулга"-аар ганцаарчилсан ярилцлага авсан бөгөөд асуулга нь дараах бүлгүүдтэй:

- Эмэгтэйн ерөнхий мэдээлэл
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүртээмж болон мэдээлэл, харилцааны технологийн хэрэглээ
- Хүүхдийн эндэгдэл
- Хүсээгүй жирэмслэлт
- Эх, нялхсын эрүүл мэнд
- Өвчлөлийн шинж тэмдэг
- ЖСАХ-ийн мэдлэг, хэрэглээ
- ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэгцээ
- Гэрлэлтийн байдал
- Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага
- Бэлгийн зан үйл
- ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага
- Тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ<sup>4</sup>
- Амьдралын сэтгэл ханамж<sup>4</sup>

<sup>3</sup> Энэ асуулгаар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн стандарт асуултын дагуу болон өөрийн орны онцлогийг тусгаж осол гэмтлийн талаар судлах зорилготой болно.

<sup>4</sup> Асуулгад анхны хувилбарыг нь ашигласан бөгөөд ОУБТС-4 шинэчилсэн стандартаас өөр болно.

5 хүртэлх насны хүүхдийн асуулга"-д судалгаанд хамрагдсан өрхөд амьдардаг 5 хүртэлх насны<sup>5</sup> бүх хүүхдийн эх, асрамжлагчийг хамруулсан.

Тухайн хүүхэд ээжтэйгээ хамт амьдардаг бол эхээс нь, харин хамт амьдардаггүй буюу төрсөн эхийнх нэр өрхийн гишүүдийн нэрсийн жагсаалтад байхгүй тохиолдолд асрамжлагчаас нь асуулга авсан бөгөөд асуулга нь дараах бүлгүүдтэй:

- Нас
- Төрсний бүртгэл
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил
- Эхийн сүүгээр хооллолт
- Хүүхдийн өвчлөл, эмчилгээ, сувилгаа
- Дархлаажуулалт
- Хүүхдийн жин, өндрийн хэмжилт

"2-14 насны хүүхдийн асуулга"-д судалгаанд хамрагдсан өрхөд амьдардаг 2-14 насны бүх хүүхдийн эх, асрамжлагчийг хамруулсан. Тухайн хүүхэд ээжтэйгээ хамт амьдардаг бол эхээс нь, харин хамт амьдардаггүй буюу төрсөн эхийнх нэр өрхийн гишүүдийн нэрсийн жагсаалтад байхгүй тохиолдолд асрамжлагчаас нь асуулга авсан бөгөөд асуулга нь дараах бүлгүүдтэй:

- Хүүхдийн осол, гэмтэл
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээл

Судалгаанд хамрагдсан 2 өрх тутмын нэгд нь амьдардаг 15-54 насны бүх эрэгтэйчүүдээс "Эрэгтэйн асуулга"-аар ганцаарчилсан ярилцлага авсан бөгөөд асуулга нь дараах бүлгүүдтэй:

- Эрэгтэйн ерөнхий мэдээлэл
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүртээмж болон мэдээлэл, харилцааны технологийн хэрэглээ
- Нөхөн үржихүй
- ЖСАХ-ийн мэдлэг, хэрэглээ
- Гэрлэлтийн байдал
- Гэр бүл төлөвлөлт
- Хүйсийн тэгш эрх
- Бэлгийн зан үйл
- ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага
- Тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ<sup>6</sup>
- Амьдралын сэтгэл ханамж

Судалгааны асуулгыг Хавсралт F-ээс харж болно.

### Сургалт, мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулах ажилтнуудад зориулсан сургалтыг 2010 оны 8 сарын 4-18-ны хооронд 15 хоногийн хугацаанд танхимын болон дадлагын гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулсан.

<sup>5</sup> Уг тайланд "5 хүртэлх насны хүүхэд", "0-4 насны хүүхэд" болон "0-59 сартай хүүхэд" гэсэн ойлголтуудыг нэг утгаар ээлжлэн хэрэглэсэн болно.

<sup>6</sup> Асуулгад анхны хувилбарыг нь ашигласан бөгөөд ОУБТС-4 шинэчилсэн стандартаас өөр болно.

Танхимын сургалтын хугацаанд судалгааны асуулгын бүлэг тус бүрээр мэргэжлийн хүмүүсээр хичээл заалгаж, асуулга бүрээр дадлага хийлгэсэн. Мөн Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Хоол судлалын төвийнхэнтэй хамтран Сонгинохайрхан дүүргийн эмнэлгийн Хүүхдийн тасагт хүүхдийн өндөр, жинг хэмжих дадлагыг хийсэн. Танхимын хичээл болон хүүхдийн өндөр жингийн хэмжилт хийх дадлагын дараа 2 өдөр Чингэлтэй болон Баянзүрх дүүрэгт сонгогдсон өрхүүдээс судалгаа авч, холбогдох хэмжилт, шалгалтын нэгдсэн дадлага хийлгэн эцэст нь сургалтад оролцогчдоос шалгалт авч, судалгаанд ажиллах ажилтнуудыг сонгон шалгаруулсан.

Судалгааны мэдээллийг цуглуулах үүрэг бүхий 10 багийг тус бүр 1 ахлагч, 1 хянагч, 5 ярилцлага авагч (2 эрэгтэй нь хэмжилт хийх ажлыг хариуцан гүйцэтгэсэн)<sup>7</sup>, 2 жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй байхаар зохион байгуулж ажиллуулсан. "Хүүхэд хөгжил-2010" судалгааны мэдээллийг 2010 оны 8-12 сарын хооронд 4 сарын хугацаанд цуглуулсан бөгөөд мэдээлэл цуглуулах явц, чанарт ҮСХ, НҮБХС-гийн ажилтан, олон улсын зөвлөх, судалгааны Удирдлагын зөвлөлийн гишүүд хяналт хийсэн. Хяналтын явцад гарсан алдаа дутагдал, ололт амжилтыг тухай бүр танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

### Мэдээлэл боловсруулалт

Судалгааны цуглуулсан мэдээллийг тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулдаг CPro 4.0 программыг ашиглан компьютерт шивж оруулсан бөгөөд уг ажлыг 1 ахлагч, 10 шивэлтийн оператор 2010 оны 10-12 сарын хугацаанд гүйцэтгэсэн. Мэдээллийн чанарыг баталгаажуулахын тулд бүх мэдээллийг давтан шивж, үзүүлэлт хоорондын уялдааг шалгаж, холбогдох засварыг хийж, мэдээллийн санг эцэслэн боловсруулсан. Судалгааны мэдээлэл шивж оруулах программыг ОҮБТС4-ийн стандарт программд суурилж, өөрийн орны асуулгын хуудастай нийцрүүлэн өөрчилсөн.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ НҮБХС-гаас судалгаанд зориулан боловсруулсан стандарт томъёолол (syntax) болон үр дүнгийн хүснэгтийн загварыг өөрийн орны асуулгын хуудсанд нийцрүүлэн өөрчлөхийн зэрэгцээ нэмэлт хүснэгтүүдийг SPSS 18.0 программ хангамж ашиглан боловсруулсан.

<sup>7</sup> ОҮБТС-ны стандарт удирдамжийн дагуу хэмжигч зөвхөн хэмжилтийг гүйцэтгэдэг болно.



# БҮЛЭГ III

## СУДАЛГААНЫ ХАМРАЛТ, ӨРХ, ХҮН АМЫН ШИНЖ БАЙДАЛ



© НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол /Сокол/ 2012 он

# III

## Судалгааны хамралт

Судалгааны түүвэрт сонгогдсон 10500 өрхөөс 10300 нь судалгааны үед хамрагдах боломжтой байсан бөгөөд эдгээр өрхөөс 10092 нь судалгаанд бүрэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 98 хувь байна. Судалгаанд хамрагдсан өрхөд 15-49 насны нийт 9599 эмэгтэй бүртгэгдсэнээс 8762 нь ганцаарчилсан ярилцлагад хамрагдаж, хамрагдалтын түвшин 91 хувьтай, 5 хүртэлх насны нийт 4114 хүүхэд, 2-14 насны нийт 9440 хүүхэд бүртгэгдсэнээс 5 хүртэлх насны 3956 хүүхдийн, 2-14 насны 9131 хүүхдийн эх/ асрамжлагч нь судалгаанд хамрагдаж, хамрагдалтын түвшин харгалзан 96 болон 97 хувь байлаа. Түүвэрлэгдсэн өрхийн жагсаалтад байгаа сондгой дугаартай өрхийн 15-54 насны эрэгтэйчүүдийг ганцаарчилсан асуулгад хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдвал зохих 5185 эрэгтэй бүртгэгдсэнээс 4025 нь судалгаанд хамрагдаж, хамрагдалтын түвшин 78 хувьтай байна.

Монгол Улсын хэмжээнд судалгааны ерөнхий хамрагдалтыг тооцвол 15-49 насны эмэгтэйн 89 хувь, 5 хүртэлх насны хүүхдийн эх/ асрамжлагчийн 94 хувь, 2-14 насны хүүхдийн эх/ асрамжлагчийн 95 хувь, 15-54 насны эрэгтэйн 76 хувь нь байна (Хүснэгт НН.1-ийг харна уу).

Хамрагдалтын түвшин нь бүс, хот, хөдөө болон байршлаар ижил түвшинтэй байв. Харин 15-54 насны эрэгтэйчүүдийн хамрагдалтын түвшин харьцангуй доогуур байсан бөгөөд энэ нь эрэгтэйчүүд тэр дундаа залуу эрэгтэйчүүд хөдөлгөөн ихтэй байдагтай холбоотой юм.

## Өрхийн шинж байдал


Хүснэгт НН.2-т судалгаанд хамрагдсан хүн амын тархалтыг нас болон хүйсээр харуулсан. Уг тархалтыг Зураг НН.1 хүн амын нас, хүйсийн суваргад ашигласан болно. Судалгаагаар 10092 өрхөд амьдарч байгаа 35981 хүний талаарх мэдээллийг цуглуулсан. Судалгаанд хамрагдсан өрхийн 6086 өрх буюу 60 хувь нь хотын, 4006 өрх буюу 40 хувь нь хөдөөгийнх байна.

Төрөлтийн түвшин 2006 оноос хойш нэмэгдсэнтэй холбогдон нийт хүн амын 11 хувь нь 0-4 насны хүүхэд байна. Мөн нийт хүн амын 61 хувь нь хөдөлмөрийн насны буюу 15-59 насны эрэгтэй, 15-54 насны эмэгтэй байна (Зураг НН.1).

Хүснэгт НН.3 - НН.5-2-д өрхийн суурь мэдээлэл болон 15-49 насны эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүд, 15-54 насны эрэгтэйчүүд, 2-14 насны хүүхдийн судалгааны абсолют тоо (жигнээгүй) мэдээнээс гадна нийт хүн амд тархаасан (жигнэсэн) мэдээллийг харуулсан. Судалгаанд бүрэн хамрагдсан өрх, эмэгтэй, эрэгтэй, 5 хүртэлх болон 2-14 насны хүүхдүүдийн сонгосон шинж байдлаар үзүүлсэн мэдээлэл нь уг тайланд оруулсан үндсэн үр дүнг тайлбарлахад маш их ач холбогдолтойгоос гадна энэ нь судалгааны төлөөлөх чадварыг харуулж байгаа юм. Үлдсэн хүснэгт нь зөвхөн жигнэгдсэн тоог харуулж байгаа бөгөөд Хавсралт А-аас хэрхэн жигнэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.



Зураг НН.1: Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын нас, хүйсийн суварга, Монгол Улс, 2010 он



Хүснэгт НН.3-т өрхийн шинж байдлыг үзүүлсэн. Хүснэгтээс өрхийн мэдээллийг өрхийн тэргүүлэгчийн хүйс, бүс, байршил, суурьшил, өрхийн гишүүдийн тоо, өрхийн тэргүүлэгчийн боловсрол, шашин шүтлэг болон үндэс угсаагаар нь харж болно. Уг шинж байдлууд нь энэхүү тайлангийн дараагийн хүснэгтүүдэд ашиглагдсан.

Судалгаанд бүрэн хамрагдсан 10092 өрхийн 6086 буюу 60 хувь нь хотын, 4006 буюу 40 хувь нь хөдөөгийн өрх байлаа. Нийт өрхийн тал хувь нь 3-4 ам бүлтэй, 26 хувь нь 1-2 ам бүлтэй, 24 хувь нь 5 ба түүнээс олон ам бүлтэй бөгөөд нэг өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 байна. Нийт өрхийн 22 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй байв.

Стандарт жигнэлтийн арга ашигласан тул жигнэсэн болон жигнэгдээгүй өрхийн тоо тэнцүү байгаа болно (Хавсралт А-г харна уу). Хүснэгтэд 0-17 насны, 0-4 насны, 2-14 насны хүүхэдтэй, 15-49 насны эмэгтэйтэй, 15-54 насны эрэгтэйтэй өрхийг харуулсан.

### Хүн амын шинж байдал

15-49 насны эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүд, 15-54 насны эрэгтэйчүүд, 2-14 насны хүүхдүүдийн ерөнхий шинж байдлыг Хүснэгт НН4, НН5, НН5М, НН5А-д харгалзуулан үзүүлсэн. Стандарт түүврийн жин ашигласан тул дээрх хүснэгтүүдэд жигнэгдээгүй болон жигнэгдсэн ажиглалтын тоо тэнцүү байгаа болно. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдийн шинж байдлаарх шаардлагатай тоо мэдээллийг харуулсан мөн хүснэгтэд тухайн шинж байдал тус бүр дэх ажиглалтын утгыг харуулахыг зорьсон болно.

Хүснэгт НН.4-д 15-49 насны эмэгтэйчүүдийг шинж байдлаар нь харуулсан. Бүс, байршил, суурьшил, насны бүлэг, гэрлэлтийн байдал, хүүхэд төрүүлсэн эсэх, сүүлийн 2 жилийн төрөлт, боловсролын түвшин<sup>8</sup>, өрхийн аж байдлын түвшин<sup>9</sup> болон өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг, үндэс угсаа зэрэг мэдээллийг харуулсан.

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйг гэрлэлтийн байдлаар нь авч үзэхэд 64 хувь нь гэр бүлтэй эсвэл хамтран амьдрагчтай, 26 хувь нь огт гэрлээгүй, 4 хувь нь цуцалсан, 3 хувь нь бэлбэсэн, 3 хувь нь тусгаарласан хүмүүс байна. Мөн нийт эмэгтэйчүүдийн 19 хувь нь судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлжээ. Боловсролын байдлаар нь авч үзвэл судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйн 3 хувь нь боловсролгүй, 5 хувь нь бага, 19 хувь нь суурь, 29 хувь нь бүрэн дунд, 10 хувь нь техникийн болон мэргэжлийн, 34 хувь нь дээд боловсролтой байна.

Хүснэгт НН.4М-д 15-54 насны эрэгтэйчүүдийг шинж байдлаар нь харуулахдаа бүс, байршил, суурьшил, насны бүлэг, гэрлэлтийн байдал, төрсөн хүүхэдтэй эсэх, боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг, үндэс угсаа зэрэг мэдээллийг харуулсан.

Судалгаанд хамрагдсан нийт эрэгтэйчүүдийн 65 хувь нь гэр бүлтэй эсвэл хамтран амьдрагчтай, 30 хувь нь огт гэрлээгүй, үлдсэн 5 хувь нь гэр бүлээ цуцалсан, тусгаарласан, бэлбэсэн байна. Боловсролын байдлаар нь авч үзэхэд эмэгтэйчүүдийнхээс харьцангуй доогуур буюу 6 хувь нь боловсролгүй, 9 хувь нь бага, 26 хувь нь суурь, 26 хувь нь бүрэн дунд, 10 хувь нь техникийн болон мэргэжлийн, 23 хувь нь дээд боловсролтой эрэгтэйчүүд байна.

5 хүртэлх насны хүүхдийн зарим шинж байдлыг Хүснэгт НН.5-д үзүүлсэн. Хүйс, бүс, байршил, суурьшил, насны бүлэг, эх/ асрамжлагчийн боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг, үндэс угсаа зэрэг мэдээллийг харуулсан.

<sup>8</sup> Өөрөөр томъёолоогүй тохиолдолд энэхүү тайланд шинж байдлаар ашигласан "боловсрол" гэдэгт судалгаанд хамрагдагчийн боловсролын хамгийн дээд түвшинг ойлгоно.

<sup>9</sup> Өрхийн аж байдлын түвшинд хамааралтай хэрэглээний эд зүйл, сууцны нөхцөл, ус болон ариун цэврийн байгууламж, бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг ашиглан өрхийн хөрөнгө (дээр дурдсан үзүүлэлтүүд) тус бүрт тохирох жинг өгснөөр (хүчин зүйлийн оноо) үндсэн бүрэлдэхүүний шинжилгээ хийгддэг. Өрх тус бүрийн хувь тухайн өрхийн эзэмшдэг эд зүйл, хөрөнгө болон тэдгээрийн жинд суурилан аж байдлын оноог тооцдог. Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амыг тэдгээрийн амьдардаг өрхийн аж байдлын онооны дагуу хамгийн багаас (доогуур) хамгийн их (дээгүүр) хүртэл 5 тэнцүү бүлэг болгон хуваадаг. Уг тооцоонд дараах эд зүйл, үзүүлэлтүүдийг ашигласан: ундны усны эх үүсвэр, ариун цэврийн байгууламжийн төрөл болон хамтарч хэрэглэдэг эсэх, гар угаах газрын үзүүлэлт, өрхийн сууцны төрөл, унтлагын өрөөний тоо, шал, хана, таазны материал, халаалтын эх үүсвэр, халаалтдаа хэрэглэдэг түлшний төрөл, хоолоо болгохдоо ашигладаг түлшний төрөл, цахилгаантай эсэх, өрхийн эд зүйл: нарны цахилгаан эх үүсгүүр, компьютер, интернэт, телевиз, радио, суурин утас, хөргөгч, угаалгын машин, тоос сорогч, номын сан; өрхийн гишүүдэд байдаг эд зүйл: бугуйн цаг, гар утас, зургийн аппарат, унадаг дугай, мотоцикл, хөсөг тэрэг, машин, трактор; сууцны эзэмшил, тариалангийн талбайтай эсэх, мал, амьтантай эсэх, банкинд данстай эсэх. Аж байдлын индекс нь өрхийн хөрөнгийн талаарх мэдээллийг урт хугацаанд ашиглана гэж төсөөлдөг бөгөөд өрхийг доогуур аж байдлаас, дээгүүр аж байдалтай гэж эрэмбэлдэг. Аж байдлын индекс нь одоогийн орлого, зарлагын түвшин болон бодит ядуурлын талаарх мэдээллийг илэрхийлдэггүй. Аж байдлын онооны тооцоолол нь зөвхөн тодорхой мэлээллийн хувьд боломжтой байдаг. Аж байдлын индекс тооцох талаар дэлгэрэнгүй мэдээллийг Ручтейн болон Жонсон, 2004, Филмер ант Притчет, 2001, Гваткин болон бусад 2000-аас олж болно.

Судалгаанд 5 хүртэлх насны нийт 3956 хүүхэд хамрагдсанаас 50 хувь нь хөвгүүд, 50 хувь нь охид байв. 5 хүртэлх насны хүүхдийн эхчүүдийн 5 хувь нь боловсролгүй, 7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 8 хувь нь бага, 18 хувь нь суурь, 27 хувь нь бүрэн дунд, 35 хувь нь дээд боловсролтой байна. Харин хүүхдийн амьдарч байгаа өрхийн аж байдлаар нь авч үзвэл судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны нийт хүүхдийн 24 хувь нь доогуур, 20 хувь нь дунджаас доогуур, 19 хувь нь дундаж, 19 хувь нь дунджаас дээгүүр, үлдсэн 18 хувь нь дээгүүр аж байдалтай өрхөд амьдарч байна.

Хүснэгт НН.5А-д 2-14 насны хүүхдийг шинж байдлаар нь харуулсан. Хүйс, бүс, байршил, суурьшил, насны бүлэг, эх/асрамжлагчийн боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг, үндэс угсаа зэрэг мэдээллийг харуулсан.

2-14 насны судалгаанд хамрагдсан 9131 хүүхдийн хүйсийн харьцаа нь 105, өөрөөр хэлбэл, 2-14 насны 100 охинд 105 эрэгтэй ногдож байна. Судалгаанд хамрагдсан 2-14 насны хүүхдийн эхчүүдийн 4 хувь нь боловсролгүй, 8 хувь нь бага, 21 хувь нь суурь, 27 хувь нь бүрэн дунд, 11 хувь нь техникийн болон мэргэжлийн, 29 хувь нь дээд боловсролтой байв.

### Мэдээллийн задаргаа

Судалгааны үр дүнг улсын дундаж болон бүс нутаг, өрхийн байршил, хот, хөдөөгөөр, эхийн боловсролын түвшин, өрхийн аж байдлын 5 тэнцүү бүлэг, өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа, шашин шүтлэгээр гаргасан.

**Бүс нутаг:** Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар

**Хот, хөдөө (суурьшил):** Нийслэл хот, аймгийн төвийг "хот", сумын төв, хөдөөг "хөдөө" гэж үзсэн.

**Боловсролын түвшин:** Боловсролгүй, бага, суурь, бүрэн дунд, техникийн болон тусгай мэргэжлийн дунд, дээд боловсролтой гэсэн 6 түвшнээр авч үзсэн.

**Өрхийн аж байдлын 5 тэнцүү бүлэг:** Өрхийн ундны усны эх үүсвэр, ариун цэврийн байгууламжийн хангамж, сууцны төрөл, сууцны материал, цахилгааны эх үүсвэр, өрхийн хэрэглээний эд зүйл зэрэг мэдээлэлд статистикийн Фактор анализийн арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийж судалгаанд хамрагдсан өрх бүрт аж байдлын индекс тооцдог. Өрхүүдийг аж байдлаар нь доогуур, дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр, дээгүүр гэсэн 5 тэнцүү бүлэгт өрхүүдийг хуваан авч үзсэн.

**Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа:** Халх, Казак, Бусад

**Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг:** Шүтлэггүй, Будда, Ислам, Бусад

**Хүснэгт НН.1: Өрх, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, 5 хүртэлх болон 2-14 насны хүүхдийн асуулгын үр дүн**

| 35-39         | 0.046                          | 0.059 | 2002.4 | 0.041 | 0.058 | 2002.8 | 0.052 | 0.061 | 2002.2 | 0.052 | 0.063 | 2002.4 |     |     |   |
| 40-44         | 0.063                          | 0.085 | 1999.7 | 0.054 | 0.081 | 2000.2 | 0.071 | 0.088 | 1999.4 | 0.071 | 0.092 | 1999.6 |     |     |   |
| 45-49         | 0.062                          | 0.084 | 1996.7 | 0.053 | 0.079 | 1997.2 | 0.072 | 0.089 | 1996.1 | 0.072 | 0.094 | 1996.4 |     |     |   |

**НҮБ-аас гаргасан Хөгжиж байгаа улс орнуудад зориулсан насжилтын загвар**

| Нялхсын бүлэг | НҮБ-аас гаргасан Хөгжиж байгаа улс орнуудад зориулсан насжилтын загвар |       |        |       |        |        |       |       |             |       |       |        |                  |       |        |    |         |   |
|---------------|--|-------|--------|-------|--------|--------|-------|-------|-------------|-------|-------|--------|------------------|-------|--------|----|---------|---|
|               | Латин Америкийн  |       |        |       | Чилийн |        |       |       | Өмнөд Азийн |       |       |        | Алс дорнод Азийн |       |        |    | Ерөнхий |   |
|               | НЭ   | 5ХЭ   | t      | НЭ    | 5ХЭ    | t      | НЭ    | 5ХЭ   | t           | НЭ    | 5ХЭ   | t      | НЭ               | 5ХЭ   | t      | НЭ | 5ХЭ     | t |
| 15-19         | 0.036  | 0.048 | 2009.7 | 0.040 | 0.045  | 2009.6 | 0.036 | 0.047 | 2009.7      | 0.036 | 0.045 | 2009.6 | 0.036            | 0.046 | 2009.7 |    |         |   |
| 20-24         | 0.038  | 0.050 | 2008.8 | 0.041 | 0.047  | 2008.7 | 0.038 | 0.049 | 2008.8      | 0.038 | 0.048 | 2008.7 | 0.038            | 0.049 | 2008.8 |    |         |   |
| 25-29         | 0.032  | 0.042 | 2007.3 | 0.036 | 0.041  | 2007.1 | 0.033 | 0.042 | 2007.3      | 0.033 | 0.041 | 2007.2 | 0.033            | 0.042 | 2007.3 |    |         |   |
| 30-34         | 0.037  | 0.049 | 2005.3 | 0.043 | 0.048  | 2005.0 | 0.038 | 0.049 | 2005.2      | 0.038 | 0.048 | 2005.2 | 0.038            | 0.048 | 2005.2 |    |         |   |
| 35-39         | 0.044  | 0.060 | 2002.8 | 0.053 | 0.061  | 2002.4 | 0.046 | 0.061 | 2002.6      | 0.045 | 0.059 | 2002.7 | 0.045            | 0.060 | 2002.7 |    |         |   |
| 40-44         | 0.059  | 0.085 | 1999.8 | 0.075 | 0.089  | 1999.4 | 0.064 | 0.089 | 1999.6      | 0.060 | 0.082 | 1999.9 | 0.061            | 0.084 | 1999.8 |    |         |   |
| 45-49         | 0.061  | 0.088 | 1996.4 | 0.077 | 0.091  | 1996.0 | 0.066 | 0.093 | 1995.9      | 0.060 | 0.081 | 1996.8 | 0.063            | 0.086 | 1996.5 |    |         |   |



# БҮЛЭГ V

## ХООЛ ТЭЖЭЭЛ



© НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол /Сокол/ 2012 он



### Хоол тэжээлийн байдал

Хүүхдийн хоол тэжээлийн байдал нь тэдний эрүүл мэндийн илэрхийлэл болдог. Хэрэв хүүхэд тохиромжтой хоол хүнсээр бүрэн хангагдаж, олон дахин өвчлөхгүй, асаргаа сувилгаа сайтай байвал тэдний өсөлт бойжилт зохих түвшинд байхаас гадна хоол тэжээлийн байдал нь хэвийн байдаг.

Дэлхий дахинд тохиолдож буй хүүхдийн эндэгдлийн талаас илүү хувь нь хоол тэжээлийн эмгэгтэй холбоотой байна. Хоол тэжээлийн дуталтай хүүхэд түгээмэл тохиолдох хүүхдийн өвчнөөр эндэх, эсэн мэнд амьдарч чадсан зарим нэг нь өвчлөмтгий, өсөлт бойжилтоор хоцрох эрсдэлтэй байдаг. Хоол тэжээлийн дутлын улмаас нас барсан 4 хүүхэд тутмын 3 нь хөнгөн эсвэл дунд зэргийн дуталтай байсан нь хүүхдийн эндэх эрсдэл буюу эмзэг байдал хоол тэжээлийн дутлын хэлбэрээс хамаарахгүй болохыг илтгэж байна. Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-д өлсгөлөнг 2015 он гэхэд 1990 оны түвшнээс 50 хувиар бууруулна гэж заасан. Хоол тэжээлийн эмгэгийн тархалтыг бууруулснаар хүүхдийн эндэгдэл буурах болно.

Тав хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн үндсэн 3 үзүүлэлтийг лавлагаа хүн амын мэдээлэлд үндэслэн харьцуулан тооцдог.

Энэхүү тайланд ашигласан лавлагаа хүн ам нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас гаргасан өсөлтийн шинэ стандартад тулгуурласан юм<sup>10</sup>. Хоол тэжээлийн байдлыг илтгэх 3 шалгуур үзүүлэлтийг лавлагаа хүн амын утгаас хэлбэлзэх стандарт хазайлт (z-оноо)-аар тодорхойлдог.

**Хүүхдийн биеийн жинг насанд харьцуулсан үзүүлэлт нь** цочмог ба архаг хоол тэжээлийн дутлын аль алиныг нь илэрхийлдэг. Биеийн жин, насны харьцаа нь 5 хүртэлх насны хүүхдийн голч үзүүлэлтээс стандарт хазайлт (СХ)-ыг 2 дахин авснаас доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн тураалтай, харин СХ-ыг 3 дахин авснаас доогуур байвал хүнд хэлбэрийн тураалтай гэж үнэлдэг.

**Биеийн өндрийг насанд харьцуулсан үзүүлэлт нь** хүүхдийн өсөлтийг илэрхийлэх хэмжигдэхүүн юм. Биеийн өндрийг насанд харьцуулсан үзүүлэлт нь 5 хүртэлх насны хүүхдийн голч утгаас стандарт хазайлтыг 2 дахин авснаас доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн өсөлт хоцролттой, харин СХ-ыг 3 дахин авснаас доогуур байвал хүнд хэлбэрийн өсөлт хоцролттой гэж үнэлдэг. Өсөлт хоцролт нь хүүхэд насандаа байвал зохих өндөрт хүрэхгүй буюу намхан байгааг харуулах бөгөөд энэ нь хоол тэжээлийн архаг дутлын илэрхийлэл болдог. Өсөлт хоцролт нь урт удаан хугацааны туршид хангалтгүй хооллож байсан, архаг өвчтэй болсон, олон дахин өвчилсөн зэргээс шалтгаалж үүсдэг байна.

**Биеийн жинг өндөрт харьцуулсан үзүүлэлт нь** 5 хүртэлх насны хүүхдийн голчоос СХ-ыг 2 дахин авснаас доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн туранхай, харин СХ-ыг 3 дахин авснаас доогуур байвал хүнд хэлбэрийн туранхай гэж үнэлдэг. Хүүхэд туранхай байх нь тухайн тохиолдлын хоол тэжээлийн дутлын илэрхийлэл болно.

Энэ нь ихэвчлэн улирлын байдлаас шалтгаалсан хоол хүнсний хомсдол, өвчлөлтэй холбоотой үүсдэг.

<sup>10</sup> [http://www.who.int/childgrowth/standards/second\\_set/technical\\_report\\_2.pdf](http://www.who.int/childgrowth/standards/second_set/technical_report_2.pdf)

Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС)-аар 5 хүртэлх насны хүүхдийн жин, өндрийг НҮБ-ын Хүүхдийн Сан (НҮБХС)-гаас зөвлөмж болгосон биеийн өндөр, жингийн хэмжилтийн багажийг ашиглан хэмжсэн ([www.childinfo.org](http://www.childinfo.org)). Тайлангийн энэ бүлэгт багтсан мэдээлэл нь эдгээр хэмжилтийн үр дүнд тулгуурласан юм.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад хийсэн биеийн өндөр, жингийн хэмжилтийн үр дүнд үндэслэн тооцсон уураг илчлэг дутал (УИД)-ын тархалтыг Хүснэгт NU.1-д харуулав. Түүнчлэн, уг хүснэгтэд биеийн жинг өндөрт харьцуулсан үзүүлэлт нь 5 хүртэлх насны хүүхдийн голчоос СХ-ыг 2 дахин авснаас дээш байгаа буюу илүүдэл жинтэй хүүхдийн эзлэх хувь болон биеийн өндөр, жингийн хэмжилтийн 3 үзүүлэлт тус бүрийн Z-онооны дундаж хэмжээг харууллаа.

Төрсөн он, сар, өдөр нь тодорхой бус хүүхэд байгаагүй бөгөөд биеийн өндөр, жингийн хэмжилтийн үр дүн байж болох хязгаараас хэтэрсэн хүүхдийн мэдээллийг Хүснэгт NU.1-д оруулаагүй юм. Мөн биеийн жин, өндрийн аль нэгийг нь хэмжээгүй хүүхдийн мэдээллийг хассан. Тухайлбал, хүүхдийг жинлэсэн боловч түүний өндрийг нь хэмжээгүй бол уг хүүхдийн мэдээллийг тураалыг тооцоход ашигласан боловч өсөлт хоцролт, туранхай хүүхдийн тархалтыг тооцоход оруулаагүй болно. Судалгаанд хамрагдсан хүүхдийн эзлэх хувийг насаар харьцуулж, хасагдсан шалтгааныг Хүснэгт DQ.6 болон Хүснэгт DQ.7-д харууллаа. Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны нийт хүүхдийн 94 хувийнх нь жин ба өндрийг хоёуланг нь хэмжсэн (Хүснэгт DQ.6). Мөн Хүснэгт DQ.7-д биеийн өндөр, жингийн хэмжилтийн үр дүн байж болох хязгаараас хэтэрсэн эсвэл жин, өндрийн аль нэгийг хэмжээгүйн улмаас үр дүнгийн боловсруулалтаас хасагдсан хүүхдийн эзлэх хувийг үзүүллээ. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 6 хувь нь жин болон насны үзүүлэлт, 7 хувь нь өндөр болон насны үзүүлэлт, 7 хувь нь жин болон өндрийн үзүүлэлтийн тооцооноос дээрх шалтгааны улмаас хасагдсан байна.

Монгол Улсын 5 хүртэлх насны хүүхдийн 3 хувь нь тураалтай, 1 хувь нь хүнд хэлбэрийн тураалтай байна. Мөн 5 хүртэлх насны хүүхдийн 15 хувь нь өсөлт хоцролттой буюу намхан, 5 хувь нь өсөлт зогсонгишилттой (хүнд хэлбэрийн өсөлт хоцролттой), харин 2 хувь нь туранхай буюу өндөртөө тохирохгүй бага жинтэй байна (Хүснэгт NU.1).

Баруун болон Хангайн бүсийн хүүхдүүд өсөлт хоцролтод өртөх магадлал хамгийн өндөр байна. Тухайлбал, Баруун бүсийн 5 хүртэлх насны нийт хүүхдийн 25 хувь, Хангайн бүсийн нийт хүүхдийн 18 хувь нь өсөлт хоцролттой байв. Өсөлт хоцролтын тархалт Улаанбаатар хот болон Төвийн бүсийн хүүхдийн дунд харьцангуй бага байна.


Түүнчлэн, хөдөөд өсөлт хоцролттой (20 хувь) хүүхдийн эзлэх хувь хотынхоос (12 хувь) өндөр байна.

Тав хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдал нь эхийн боловсролын түвшнээс хамаарч, ялгаатай байна. Техникийн болон тусгай мэргэжлийн дунд эсвэл дээд боловсролтой эхчүүдийн хүүхэд тураал болон өсөлт хоцролтод өртөх эрсдэл нь боловсролгүй эсвэл бага боловсролтой эхийн хүүхэдтэй харьцуулахад бага байна. Тухайлбал, өсөлт хоцролттой хүүхдийн эзлэх хувь боловсролгүй эхийн хүүхдүүдийн дунд 28 хувь байхад дээд боловсролтой эхийн хүүхдүүдийн дунд 9 хувь байв.

Мөн доогуур түвшний аж байдалтай өрхөд амьдарч байгаа 5 хүртэлх насны 4 хүүхэд тутмын 1 нь буюу 25 хувь нь өсөлт хоцролттой байхад дээгүүр түвшний аж байдалтай өрхийн бага насны хүүхдийн ердөө 7 хувь нь өсөлт хоцролттой байлаа (Хүснэгт NU.1).

Хүүхдийн хоол тэжээлийн байдлыг насаар авч үзэхэд 12-23 сартай хүүхдүүдийн дунд өсөлт хоцролт хамгийн өндөр (21 хувь), харин 0-11 сартай хүүхдүүдийн дунд харьцангуй бага байгааг дараах зургаас харж болно (Зураг NU.1). Өсөлт хоцролтын тархалт 12-35 сартай хүүхдүүдийн дунд өндөр байгаа нь энэ насны хүүхдүүд эхийн сүүгээр хооллохоо болих, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ус, хоол, хүнс, орчны сөрөг нөлөөнд өртөх эрсдэлтэй байдагтай холбоотой юм.

Зураг NU.1: 5 хүртэлх насны тураалтай, өсөлт хоцролттой, туранхай хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он



Тав хүртэлх насны нийт хүүхдийн дунд тураал болон туранхайн тархалт харьцангуй бага байгаа бөгөөд хоол тэжээлийн эдгээр дутлын тархалт бүс нутаг, өрхийн байршил, аж байдлаар төдийлөн ялгаатай бус байна (Хүснэгт NU.1).

Мөн илүүдэл жинтэй хүүхэд 11 хувь байгаа бөгөөд энэ нь 2005 оны түвшнээс (10 хувь) бараг ялгаагүй байна.

**Эхийн сүүгээр хооллолт ба нялхас, бага насны хүүхдийн хооллолт**

Хүүхдийг амьдралын эхний цөөн хэдэн жилд эхийн сүүгээр хооллох нь тэднийг халдвараас хамгаалах ба тохиромжтой шимт бодисоор хангах, түүнчлэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй хооллолт юм. Харамсалтай нь олон эхчүүд хүүхдээ хөхнөөс хэт эрт гаргах, нялхсын сүүн тэжээл хэрэглэх болсон нь хүүхдийн өсөлт, хөгжил удаашрах, бичил тэжээлийн дуталд өртөх, цэвэр усан хангамж дутмаг үед хүүхэд өвчлөх зэрэг эрсдэлд хүргэдэг.

ДЭМБ/ НҮБХС-гаас хүүхдийн хооллолтын талаар дараах зөвлөмжийг баримталж байна. Үүнд:

- Хүүхдийг 6 сар хүртэл нь эхийн сүүгээр дагнан хооллох,
- 2 ба түүнээс дээш нас хүртэл эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох,
- 6 сар хүрмэгц тохиромжтой, аюулгүй нэмэгдэл хоол өгч эхлэх,
- Нэмэгдэл хоол өгөх давтамж: 6-8 сартай хүүхдийг өдөрт 2 удаа, 9-11 сартай хүүхдийг өдөрт 3 удаа хооллох.


Түүнчлэн, хүүхдийг төрснөөс хойш 1 цагийн дотор эхийн сүүгээр хооллож эхлэхийг зөвлөдөг билээ.

Бага насны хүүхдийн хооллолтын зөвлөмжид тулгуурлан дараах үзүүлэлтийг хоол тэжээлийн үнэлгээнд ашиглаж байна. Үүнд:

- Эрт амлуулалт (нярайг төрсний дараах 1 цагийн дотор амлуулах);
- Эхийн сүүгээр дагнан хооллолт (0-5 сар);
- Эхийн сүүгээр давамгайлан хооллолт (0-5 сар);
- 1 болон 2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон хүүхдийн эзлэх хувь (12-15 сар, 20-23 сар);
- Хүүхдийг эхийн сүүгээр хооллож байгаа голч хугацаа (0-35 сар);
- Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байгаа хүүхдийн эзлэх хувь (0-23 сар);
- Нэмэгдэл хоол (хагас шингэн, шингэн, өтгөн)-онд орсон хүүхдийн эзлэх хувь (6-8 сар);
- Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж байгаа хүүхдийн эзлэх хувь (6-23 сар);
- Эхийн сүүгээр хооллохгүй байгаа бөгөөд сүүн шингэн зүйлийг зохих давтамжаар ууж байгаа хүүхдийн эзлэх хувь (6-23 сар);
- Угжаар шингэн зүйл уусан хүүхдийн хувь (0-23 сар).

Хүснэгт NU.2-т эхийн сүүгээр хооллож байсан, төрсний дараа 1 цаг эсвэл 1 өдрийн дотор ангир уургаа амласан, ангир уургаа амлахаас өмнө ямар нэгэн зүйлээр хооллосон 2 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувийг харууллаа. Эх, хүүхдийн хооронд бие махбодийн болон сэтгэл зүйн холбоо үүсгэх, эхийн сүүгээр хооллолтын хамгийн чухал үе бол эрт амлуулалт юм. Сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 71 хувь нь төрсний дараа нэг цагийн дотор, 92 хувь нь 1 хоногийн дотор хүүхэддээ ангир уургаа амлуулжээ.

Зураг NU.2: Төрсний дараах 1 цаг эсвэл 1 өдрийн дотор хүүхэддээ ангир уургаа амлуулсан эхчүүдийн хувь, Монгол Улс, 2010 он



Ангир уургаа эрт амлуулсан байдлыг бүсээр авч үзэхэд 1 цагийн дотор амлуулах нь Баруун болон Төвийн бүсүүдэд (64 хувь) бусад бүсийнхээс (72-80 хувь) харьцангуй доогуур байна. Хүүхдийг төрсний дараа 1 хоногийн дотор амлуулах нь бүсүүдэд 90-96 хувьтай байна (Зураг NU.2).

Төрсний дараа 1 цаг болон 1 хоногийн дотор ангир уургаа амласан 0-23 сартай хүүхдийн эзлэх хувь өрхийн байршил, эхийн боловсрол, өрхийн аж байдлаар төдийлэн ялгаагүй, харьцангуй ижил түвшинд байгааг Хүснэгт NU.2-оос харж болно.

Казак өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хүүхдүүдийн ердөө 20 хувь, харин халх болон бусад өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хүүхдүүдийн 73 хувь нь төрсний дараа 1 цагийн дотор ангир

уургаа амласан байв (Хүснэгт NU.2).

Түүнчлэн, Хүснэгт NU.2-оос харахад ангир уургаа амлахаас өмнө эхийн сүүнээс өөр ямар нэгэн зүйлээр хооллосон хүүхдийн эзлэх хувь дээд боловсролтой эхчүүдийн хүүхдүүдийн дунд харьцангуй өндөр (13 хувь) байна. Өрхийн аж байдлаар харьцуулан үзэхэд дээгүүр түвшний аж байдалтай өрхийн 0-23 сартай хүүхэд ангир уургаа амлахаас өмнө эхийн сүүнээс өөр ямар нэгэн зүйлээр хооллох хандлага харьцангуй өндөр байна.

Эх, асрамжлагчийн ярилцлагад үндэслэн сүүлийн 24 цагийн хугацаанд хүүхдийн эхийн сүүгээр хооллолт, шингэн зүйлсийн хэрэглээний талаарх мэдээллийг Хүснэгт NU.3-т харууллаа. Эхийн сүүгээр дагнан хооллолт гэдэгт хүүхэд зөвхөн эхийн сүүгээр хооллосон байхыг ойлгоно (аминдэм, эрдсийн бэлдмэл эсвэл эм хэрэглэсэн байж болно). Уг хүснэгтэд амьдралынхаа эхний 6 сар хүртлээ эхийн сүүгээр дагнан хооллосон, мөн 12-15 ба 20-23 сар хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон хүүхдийн эзлэх хувийг харуулсан.

Зургаа хүртэл сартай нийт хүүхдийн 66 хувь нь эхийн сүүгээр дагнан хооллосон байна. Эхийн сүүгээр дагнан хооллосон 0-5 сартай хүүхдийн эзлэх хувь Баруун бүсэд хамгийн өндөр (74 хувь), Хангайн бүс болон Улаанбаатар хотод хамгийн бага (61 болон 62 хувь) байгаа нь Хүснэгт NU.3-аас харагдаж байна. Түүнчлэн, 12-15 сартай хүүхдийн 82 хувь, 20-23 сартай хүүхдийн 65 хувь нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байв. Хөвгүүдийг (85 болон 67 хувь) охидтой харьцуулахад (79 болон 63 хувь) эхийн сүүгээр 1 ба 2 нас хүртэл нь үргэлжлүүлэн хооллодог байна. Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолтыг бүсээр авч үзэхэд Зүүн бүсийн хувьд хамгийн доогуур (71 болон 45 хувь) байхад 1 нас хүртэл эхийн сүүгээр хооллох нь Хангайн бүсэд (95 хувь), харин 2 нас хүртэл эхийн сүүгээр хооллох нь Баруун бүсэд (76 хувь) хамгийн өндөр байлаа.

Хүүхдийн эхийн сүүгээр хооллолтын үргэлжлэх голч хугацааг сонгосон үзүүлэлтээр харьцуулан Хүснэгт NU.4-т харуулав. Тухайлбал, 3 хүртэлх насны хүүхдийн эхийн сүүгээр хооллох голч хугацаа 25 сар, эхийн сүүгээр дагнан хооллолтын голч хугацаа болон эхийн сүүгээр давамгайлан хооллолтын хувьд уг үзүүлэлт адил 4 сар байна. Судалгаанд хамрагдсан 3 хүртэлх насны хүүхдийн эхийн сүүгээр дагнан хооллосон голч хугацаа хүйсийн хувьд төдийлэн ялгаатай бус, харин бүс нутгаар бага зэрэг ялгаатай байна. Баруун бүсийн 3 хүртэлх насны хүүхдийн эхийн сүүгээр дагнан хооллосон хугацаа 5 сар байгаа бол уг үзүүлэлт Хангайн бүс болон Улаанбаатар хотод 3 сар байлаа (Хүснэгт NU.4).

24 хүртэлх сартай хүүхдийн зохистой хооллолтын талаарх үзүүлэлтүүдийг Хүснэгт NU.5-д харуулав. Хүүхдийн зохистой хооллолтыг тэдний наснаас хамаарсан харилцан адилгүй шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон. Тухайлбал, 0-5 сартай хүүхдийн хувьд эхийн сүүгээр дагнан хооллолт нь зохистой хооллолтын үзүүлэлт болдог бол 6-23 сартай хүүхдийн хувьд эхийн сүүнээс гадна шингэн, хагас шингэн, өтгөн хоол, хүнс хэрэглэхийг нэмж зөвлөдөг.

Бага насны хүүхдийн зохистой хооллолтын үр дүнгээс харахад 6-23 сартай хүүхдүүдийн 70 хувь эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ, өтгөн, өтгөвтөр, хөнгөн хоол хүнс хэрэглэж байна. Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоол, хүнс хэрэглэж байгаа хүүхдийн эзлэх хувь хүйс, бүс нутаг, байршлаар тодорхой хэмжээгээр ялгаатай байгааг Хүснэгт NU.5-аас харж болно. 0-23 сартай нийт хүүхдийн 69 хувь нь насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байна. Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байгаа 2 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь бүс нутгаар бага зэрэг ялгаатай буюу Зүүн бүсэд хамгийн доогуур

(65 хувь), Хангайн бүсэд (72 хувь) хамгийн өндөр байна.

6-23 сартай хүүхдийн зохистой хооллолт нь тэдний өсөлт, хөгжил болон хоол тэжээлийн дутлаас сэргийлэхэд онцгой ач холбогдолтой. Хүүхдийг 6 сартайгаас нь эхлэн эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ хангалттай тэжээллэг, аюулгүй, тохиромжтой нэмэгдэл хоолоор хооллох нь эхийн сүүгээр хангаж чадахгүй байгаа тэжээлийн бодисуудын хэрэгцээг нөхөхөд тусална. Эхийн сүүгээр хооллодог 6-8 сартай хүүхдэд 2 ба түүнээс олон удаа өтгөн, өтгөвтөр эсвэл хөнгөн хоол өгөх, 9-23 сартай хүүхдийг өдөрт 3 ба түүнээс олон удаа хооллох шаардлагатай байдаг. Харин хөхөө хөхдөггүй буюу эхийн сүүгээр хооллодоггүй 6-23 сартай хүүхдэд өдөрт 4 ба түүнээс олон удаа сүү болон өтгөн, өтгөвтөр эсвэл хөнгөн хоол, хүнс өгөх шаардлагатай юм.

Судалгаанд хамрагдсан 6-8 сартай нийт хүүхдийн 66 хувь нь өтгөн, өтгөвтөр эсвэл хөнгөн хоол хүнс хэрэглэж байна. Уг үзүүлэлт нь эхийн сүүгээр хооллодог 6-8 сартай хүүхдийн дунд 64 хувьтай байна (Хүснэгт NU.6). Дээрх хүснэгтээс харахад зохих насандаа нэмэгдэл хоолонд орсон хүүхдийн эзлэх хувь хотод статистик ач холбогдол бүхий өндөр байгаа юм. Тухайлбал, хотын 6-8 сартай хүүхдийн 71 хувь нь эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ өтгөн, өтгөвтөр эсвэл хөнгөн хоол, хүнс хэрэглэдэг бол хөдөөгийн хүүхдүүдийн дунд уг үзүүлэлт 58 хувь байна.

Хүснэгт NU.7-д судалгааны мэдээлэл цуглуулахын өмнөх өдөр өтгөн, өтгөвтөр эсвэл хөнгөн хоол, хүнсийг зохих давтамжаар болон түүнээс олон давтамжтай хэрэглэсэн 6-23 сартай хүүхдийн эзлэх хувийг тэдний эхийн сүүгээр хооллолтын байдлаар харьцуулан үзүүлээ.

Эхийн сүүгээр хооллодог 6-23 сартай 5 хүүхэд тутмын нэг (21 хувь) нь нэмэгдэл хоол, хүнсийг өдөрт идвэл зохих хамгийн бага давтамжаар хэрэглэж байна. Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ өдөрт хоолловол зохих хамгийн бага давтамжаар хооллосон охидын эзлэх хувь (23 хувь) хөвгүүдийнхээс бага зэрэг өндөр (18 хувь) байлаа (Хүснэгт NU.7).

Эхийн сүүгээр хооллодоггүй 6-23 сартай хүүхдэд өдөрт хамгийн багадаа 2 удаа сүү, цагаан идээ өгөхөөс гадна нэмэгдэл хоол эсвэл сүү, сүүн бүтээгдэхүүнийг өдөрт 4 ба түүнээс олон удаа өгөх шаардлагатай байдаг. Судалгаанд хамрагдсан хөхөө хөхдөггүй 6-23 сартай нийт хүүхдийн 71 хувь өдөрт доод тал нь 2 удаа сүү, сүүн бүтээгдэхүүн уудаг бөгөөд хүйсийн хувьд ялгаагүй байна (Хүснэгт NU.7). Эхийн сүүгээр хооллодоггүй, өдөрт 4 ба түүнээс олон удаа өтгөн, өтгөвтөр ба хөнгөн хоол, хүнс эсвэл сүү хэрэглэсэн 6-23 сартай хүүхэд 67 хувь байв. Уг үзүүлэлт охид, хөвгүүдийн дунд харьцангуй ижил түвшинд байгааг Хүснэгт NU.7-оос харж болно.

Манай улсад хүүхдэд өгч буй нэмэгдэл хоол нь зохих давтамждаа хүрэхгүй тохиолдол маш түгээмэл байгаа нь 6-23 сартай 3 хүүхэд тутмын ердөө 1 нь (30 хувь) өдөрт идвэл зохих давтамжийн дагуу нэмэгдэл хоол идэж байгаагаас харагдана. Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж байгаа 6-23 сартай хүүхэд хотод 32 хувь, хөдөөд 27 хувь байна. Хүүхдийг хооллох давтамжийг бүсээр авч үзэхэд Баруун бүсийн (15 хувь) хувьд бусад бүсээс доогуур түвшинд байгааг Хүснэгт NU.7-оос харж болно.

Угжаар шингэн зүйл уух нь бохирдсон ус хэрэглэх эсвэл хоол хүнс бэлтгэхдээ эрүүл ахуйн зохистой дадал баримтлаагүй тохиолдолд халдвар дамжуулах эрсдэлийг бий болгодог. 0-23 сартай хүүхдүүдийн дунд угжаар хооллолт түгээмэл байсаар байна. Хоёр хүртэлх насны 5 хүүхэд тутмын 1 нь (21 хувь) судалгаанаас өмнөх 1 хоногт угжаар шингэн зүйл уусан байлаа. Хүснэгт NU.8-аас харахад 6-11 сартай хүүхдэд шингэн зүйлийг угжаар өгөх хандлага

бусад насны хүүхэдтэй харьцуулахад бараг 2 дахин их (34 хувь) байна. Түүнчлэн хотын 0-23 сартай хүүхдүүдийн хувьд угж хэрэглэн шингэн зүйл өгөх нь (26 хувь) хөдөөгийн хүүхдүүдтэй (13 хувь) харьцуулахад мөн л 2 дахин их байгааг харж болно.

### Иоджуулсан давсны хэрэглээ

Иод дутлын эмгэг (ИДЭ) нь бага насны хүүхдийн дунд тохиолдож буй оюун ухааны хомсдол, сэтгэхүйн болон бие махбодийн хөгжил саатах эмгэгийн тэргүүлэх шалтгаан болж байгаа хэдий ч урьдчилан сэргийлж болдог онцлогтой. Нэлээд хүнд хэлбэрийн иодын дутал нь кретинизмын шалтгаан болдог. Түүнчлэн жирэмсэн эмэгтэйчүүд иодын дуталтай байвал дутуу төрөх, зулбах эрсдэлтэй байдаг. Иод дутал нь бамбай булчирхайн томролттой шууд холбоотой бөгөөд иод дутлын үед хамгийн түгээмэл илэрдэг шинж бол бамбай булчирхайн томролт буюу бахлуур юм. ИДЭ-ийн хамгийн гол үр дагавар нь оюун ухааны хөгжил хоцрох, улмаар сурах чадвар ба оюуны чадамж буурах, хөдөлмөрлөх чадвар алдагдах зэрэг юм. Олон улсын түвшинд 2005 он гэхэд иод дутлыг бүрэн устгах зорилт тавьсан билээ. Судалгаагаар зохистой түвшинд иоджуулагдсан давс (>15 parts per million) хэрэглэж буй өрхийн эзлэх хувийг үндсэн үзүүлэлт болгон ашигласан юм.

Манай улсын нутаг дэвсгэрийн 80 гаруй хувь нь иодын дуталтай бүс нутагт хамрагддаг тул 1992-1995 онд ИДЭ-ийн тархалтыг үндэсний түвшинд тогтоох судалгааг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан байна. Энэхүү судалгаагаар МУ-ын 7-12 насны хүүхдийн 29 хувь нь бахлууртай байгааг илрүүлсэн юм. Судалгааны дүнгээр зарим орон нутагт ИДЭ-ийн тархалт анхаарал татахуйц өндөр байсан тул МУ-ын Засгийн газраас "Иод дутлын эмгэгтэй тэмцэх" үндэсний анхдагч хөтөлбөрийг боловсруулж 1996-2001 онд, 2 ба 3 дахь шатны хөтөлбөрийг 2002-2006 ба 2007-2010 онд батлан хэрэгжүүлсэн.

ИДЭ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд МУ-ын Засгийн газраас иоджуулсан давсны үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүн амын иод дутал, иоджуулсан давсны талаарх мэдлэгийг сайжруулах, иоджуулсан давс хэрэглэх хандлага, дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлсэн.

"Иоджуулсан давсны үндэсний стандарт" (2001), "Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай" МУ-ын хууль (2003), Баяжуулсан бүтээгдэхүүнд хяналт тавих журам (2006) зэрэг эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлж, хүнсний зориулалтаар зөвхөн иоджуулсан давсыг хэрэглэж байхаар хуульчилсан юм.

ИДЭ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхлэх үе буюу 1996 оноос хүн амын хүнсний хэрэглээнд иоджуулсан давс анхлан нэвтэрсэн бөгөөд хөтөлбөр хэрэгжих явцад өрхийн иоджуулсан давсны хэрэглээ тасралтгүй нэмэгдэж, ИДЭ-ийн тархалт жилээс жилд буурч байна.


МУ-ын үндэсний стандартад хүнсний давсыг зөвхөн кали иодатаар иоджуулахыг зөвшөөрсөн байдаг. Иймд судалгаанд хамрагдсан өрхийн давсны дээж иод агуулсан эсэхийг тодорхойлохдоо зөвхөн кали иодат (KIO3)-ыг илрүүлэх хурдавчилсан шалгуур ашигласан юм. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 95 хувийнх нь хоол хүнсээ бэлтгэхдээ хэрэглэдэг давсны иодын агууламжийг кали иодатыг илрүүлэх хурдавчилсан шалгуураар шалгасан.

Хүснэгт NU.9-өөс харахад маш цөөн тооны өрх (1 хувь) судалгааны үед давсгүй байжээ. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 70 хувь нь 15 мг/кг (part per million) ба түүнээс их хэмжээгээр иод агуулсан буюу зохистой түвшинд иоджуулсан давс хэрэглэж байна. Өрхийн иоджуулсан давсны хэрэглээ байршлын хувьд статистикийн ач холбогдол бүхий ялгаатай



байна. Тухайлбал, хот суурин газрын 4 өрх тутмын 3 нь (77 хувь), харин хөдөөгийн өрхийн 59 хувь нь зохистой түвшинд иоджуулсан давс хэрэглэж байв. Зохистой түвшинд иоджуулсан давсны хэрэглээ Баруун бүсэд хамгийн бага буюу 48 хувь байгаатай харьцуулахад Улаанбаатар хотод хамгийн өндөр (81 хувь) байлаа (Зураг NU.3).

Зураг NU.3: Хүнсэндээ иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн хувь, Монгол Улс, 2010 он



Зохистой түвшинд иоджуулсан давсны хэрэглээ өрхийн аж байдалтай ихээхэн хамааралтай байгаа бөгөөд өрхийн аж байдал дээгүүр байх тусам иоджуулсан давсны хэрэглээ нэмэгдэж байна. Тухайлбал, доогуур болон дунджаас доогуур аж байдалтай өрхийн 53-68 хувь, харин дунджаас дээгүүр болон дээгүүр аж байдалтай өрхийн 76-79 хувь нь зохистой түвшинд иоджуулсан давс хэрэглэж байв (Хүснэгт NU.9).

#### А аминдэмийн хангамж

А аминдэм нүдний эрүүл мэнд болон дархлааны тогтолцооны хэвийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай. А аминдэм нь сүү, элэг, өндөг, улаан ба улбар шар жимс, улаан наргил модны тос, ногоон өнгийн навчит ногоонд агуулагддаг. Эдгээр хүнс хүний бие махбодийн А аминдэмийн хэрэгцээг шууд хангах эх үүсвэр болж чадна. Хөгжиж буй орны хүн ам жимс, ногооноос А аминдэмийг авдаг боловч, тэдгээрийн 1 хүнд ногдох хэмжээ нь хоол хүнсээр авбал зохих шаардлагатай түвшинд хүрэхгүй байна. А аминдэмийг хоол хүнсээр шаардлагатай хэмжээгээр авч чадахгүй байхын зэрэгцээ өсөлтийн болон өвчлөлийн үед түүний хэрэгцээ ихсэх, аливаа халдварын улмаас А аминдэм хүүхдийн бие махбодоос алдагддаг ажээ. Ялангуяа 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өндөртэй хөгжиж буй орнуудад А аминдэмийн дутал нэлээд түгээмэл тохиолдож байна.

Хүүхдийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний 1990 онд зохион байгуулагдсан уулзалтаар 2000 он гэхэд А аминдэмийн дутал ба сохролыг бүрэн устгах зорилт тавьсан билээ. Энэхүү зорилтыг 1991 оны "Далд өлсгөлөнг устгая" бодлогын бага хурал, 1992 оны Хоол тэжээлийн Олон Улсын Хурал, НҮБ-ын Ерөнхий чуулганы 2002 оны хүүхдийн асуудлаарх тусгай хуралдаанаар хэлэлцэн баталсан байдаг. А аминдэм нь хүүхдийн эрүүл мэнд, дархлааны тогтолцооны хэвийн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй тул түүний дутлыг бууруулах нь хүүхдийн эсэн мэнд амьдралыг дэмжих, түүнчлэн, 2015 он гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны хоёроор бууруулах МХЗ-ыг хангахад шийдвэрлэх үүрэгтэй юм.

А аминдэмийн дутал нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж буй улс орнуудад 6-59 сартай бүх хүүхдийг 6 сар тутамд өндөр тунт А аминдэмээр хангах арга

хэмжээг хэрэгжүүлж байна. Бага насны хүүхдийг жилд 2 удаа өндөр тунт А аминдэмээр хангах нь А аминдэмийн дутлыг устгах, хүүхдийн эсэн мэнд амьдралыг дэмжих аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, үр дүнтэй арга юм. Шинэ төрсөн хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг өндөр тунтай А аминдэмээр хангаснаар тэдний хүүхдийг амьдралынх нь эхний 6 сарын хугацаанд хамгаалах, жирэмслэлт ба хүүхэд хөхүүлэх явцад алдагдсан А аминдэмийг нөхөн сэргээхэд тусалдаг. Судалгаагаар эх, хүүхдийг А аминдэмээр хангах хөтөлбөр хэрэгжүүлж буй улс орнуудад сүүлийн 6 сарын дотор ядаж нэг удаа өндөр тунт А аминдэмийн бэлдмэл хэрэглэсэн 6-59 сартай хүүхдийн эзлэх хувийг тодорхойлсон.

ДЭМБ/ НҮБХС-гийн удирдамжид тулгуурлан МУ-ын Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-наас 6-11 сартай хүүхдийг нэг удаа, 12-59 сартай хүүхдийг 6 сар тутамд өндөр тунт А аминдэмийн бэлдмэлээр хангахыг зөвлөдөг. Манай улс бага насны хүүхдийг өндөр тунт А аминдэмээр хангах ажлыг жил бүрийн 5, 10 дугаар саруудад дархлаажуулалтын арга хэмжээтэй уялдуулан зохион байгуулж байна. Жирэмсэн үед болон хүүхэд хөхүүлэх явцад эхийн бие махбодийн А аминдэмийн хэрэгцээ ихэсдэг тул шинэ төрсөн эхчүүдийг төрөх тасагт байхад нь өндөр тунт А аминдэмээр хангах удирдамжийг хэрэгжүүлж байгаа билээ.

ОУБТС-ны мэдээлэл цуглуулахын өмнөх 6 сарын хугацаанд 6-59 сартай хүүхдийн 61 хувь нь өндөр тунт А аминдэмийг хэрэглэсэн байна. Хот, хөдөөгийн 6-59 сартай хүүхдүүдийн өндөр тунт А аминдэмийн хэрэглээ төдийлэн ялгаагүй байгааг судалгааны дүн харуулж байна (Хүснэгт NU.10).

Судалгаанаас өмнөх 6 сарын хугацаанд 6-11 сартай нийт хүүхдийн 52 хувь, харин 12-23 сартай хүүхдийн 66 хувь нь өндөр тунт А аминдэм хэрэглэсэн байгаа нь өмнөх насны хүүхдийн үзүүлэлтээс нэмэгдсэн байна. Гэсэн хэдий ч хүүхдийн нас ахих тутам өндөр тунт А аминдэмийн хэрэглээ аажим буурч, 24-35 сартай хүүхдийн 64 хувь, 36-47 сартай хүүхдийн 59 хувь, 48-59 сартай хүүхдийн 58 хувь хэрэглэсэн байв.

Мөн Баруун бүсийн хүүхдүүдийн тал хувь (49 хувь) нь А аминдэм ууж байхад бусад бүсийн хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 58-74 хувь байна. А аминдэмжүүлэлтийн хамралт Зүүн болон Хангайн бүсэд хамгийн өндөр байв.

Харин А аминдэмийн хэрэглээ хүүхдийн хүйс, өрхийн байршил болон аж байдлаар төдийлэн ялгаагүй байна.

### **Бага жинтэй төрөлт**

Хүүхдийн төрөх үеийн жин зөвхөн эхийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдлыг илтгээд зогсохгүй, нярайн эсэн мэнд торних, өсөлт, эрүүл мэндийн урт хугацааны үзүүлэлт болохоос гадна нийгэм, сэтгэл зүйн хөгжлийн үндэс болдог байна. Бага жинтэй төрөлт (2500 граммаас бага) хүүхдийн эрүүл мэндэд маш олон эрсдэлийг авчирдаг. Эхийн хэвлийд байхдаа хоол тэжээлийн дуталтай байсан хүүхэд амьдралынхаа эрт үе (эхний сар ба жилүүдэд)-д эндэх өндөр эрсдэлтэй байдаг. Эсэн мэнд амьдарч чадсан зарим нэг нь дархлааны тогтолцооны хэвийн үйл ажиллагаа алдагдах, амьдралынхаа туршид өвчлөх өндөр эрсдэлтэй, хоол тэжээлийн дуталд өртөх, булчингийн хүч багатай байх магадлалтай байдаг ажээ. Мөн ахимаг насандаа чихрийн шижин, зүрх судасны өвчнөөр өвчлөх тохиолдол өндөр байдаг. Түүнчлэн, бага жинтэй төрсөн хүүхдийн оюун ухаан (IQ), сэтгэн бодох чадамж нь буурдаг тул тэдний сурах ба ажиллах чадварт сөргөөр нөлөөлдөг байна.

Хөгжиж буй орнуудад тохиолдож буй бага жинтэй төрөлт нь нэн тэргүүнд эхийн эрүүл мэнд ба хоол тэжээлийн дутлаас шалтгаалж байна. Бага жинтэй төрөлтөд дараах 3 хүчин зүйл

хамгийн ихээр нөлөөлдөг ажээ. Тодруулбал, эх жирэмслэхээс өмнө эсвэл хүүхэд насандаа хоол тэжээлийн дуталтай байх, халдварт өвчнөөр өвчилж байсан болон жирэмсний явцад хангалтгүй хоол тэжээлтэй байсны улмаас бага жинтэй хүүхэд төрүүлдэг байна. Жирэмсний явцад эхийн биеийн жин хангалтгүй нэмэгдэх нь ургийн өсөлт хоцролтын шалтгааны нэлээд их хувийг эзэлдэг юм. Хөгжиж буй орнуудад эх жирэмсэн үедээ халдварын улмаас суулгалт, хумхаагаар өвчлөх нь түгээмэл тохиолддог бөгөөд энэ нь ургийн өсөлт саатах шалтгаан болдог.

Өндөр хөгжилтэй, үйлдвэржсэн орнуудад жирэмсэн эхийн тамхины хэрэглээ бага жинтэй төрөлтийн голлох шалтгаан болж байна. Мөн өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад бие махбодийн өсөлт, хөгжил нь бүрэн гүйцээгүй өсвөр насны охидын жирэмслэлт хоол тэжээлийн дуталтай ураг тээх эрсдэлд хүргэж байна.

Тулгамдаж буй томоохон асуудлын нэг бол хөгжиж буй орнуудад төрж байгаа нярай хүүхдийн талаас илүү хувийг төрөх үед нь жинлэхгүй байгаа явдал юм. Бага жинтэй төрөлтийн эзлэх хувийг тооцохдоо эрүүл мэндийн байгууллагын тоо баримтыг үндэслэн гаргадаг байсан. Гэхдээ уг арга нь хөгжиж буй дийлэнх орнуудын хувьд алдаатай болох нь тогтоогдсон юм. Учир нь эдгээр орнуудад нярай хүүхдийн ихэнх нь эрүүл мэндийн байгууллагад бус гэрийн нөхцөлд төрдөг тул уг тоо баримт нийт төрөлтийг бус түүний зарим хэсгийг төлөөлдөг.

Зураг NU.4: Бага жинтэй (2500 граммаас бага) төрсөн хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он



Түүнчлэн, нэлээд олон хүүхдийг төрөх үед нь жинлэдэггүй тул зөвхөн жинлэсэн хүүхдийн үзүүлэлтээр бага жинтэй төрөлтийг тооцох нь нийт төрөлтийг төлөөлж чадахгүй, алдаатай дүн гардаг тул бага жинтэй төрөлтийн тархалтыг үнэн зөв тогтоох боломжгүй юм. Иймд 2500 граммаас бага жинтэй төрөлтийн эзлэх хувийг тогтоохдоо 2 төрлийн асуултыг ашигласан. Үүнд: хүүхдийн биеийн жингийн талаарх

эхийн үнэлгээ (маш бага, дунджаас бага, дундаж, дунджаас их, маш их) болон хэрэв тухайн хүүхдийг төрөх үед нь жинлэсэн бол төрөх үеийн жингийн талаарх эхийн мэдээлэл эсвэл эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх тэмдэглэлийг үндэслэн судалгааны мэдээлэл цуглуулсан<sup>11</sup>.

Монгол Улсын 0-23 сартай нийт хүүхдийн 98 хувийг төрөх үед нь жинлэсэн бөгөөд тэдгээрийн 5 хувь нь 2500 граммаас бага жинтэй төрсөн байв (Хүснэгт NU.11). Бага жинтэй төрөлтийн түвшин бүс нутгаар ялгаатай байв. Тодруулбал, Баруун бүсэд хамгийн өндөр буюу 7 хувь байхад Улаанбаатар хотод хамгийн бага буюу 4 хувь байна.

2 хүртэлх насны хүүхдүүдийн дунд бага жинтэй төрөлтийн эзлэх хувь хот, хөдөө болон өрхийн аж байдлын түвшнээр төдийлөн ялгаагүй байлаа (Хүснэгт.11).

<sup>11</sup> Тооцооллын арга зүйг дэлгэрэнгүйгээр дараах номноос харж болно. Боерма, Ж. Т., Вэйнштэйн, К. Л., Руцэйн, С.О., болон Соммерфелт, А. И., 1996. Хөгжиж байгаа орнуудын төрөх үеийн жингийн мэдээлэл: Судалгаа тусалж чадах уу? ДЭМБ-ын Бюллетень, 74(2), 209-16.

**Хүснэгт NU.1: Хүүхдийн хоол тэжээлийн байдал**

5 хүртэлх насны хүүхдийн хувь, хоол тэжээлийн байдлаар, биеийн хэмжилтийн 3 үзүүлэлт: насанд харьцуулсан өндөр, өндөрт харьцуулсан жин, насанд харьцуулсан өндөр, өндөрт харьцуулсан жин, Монгол Улс, 2010 ОН

|   | Тухайн насны жингээс |                     |              | Тухайн насны өндрөөс |                     |              | Тухайн өндрийн жингээс |                     |  |     |       |
|---|----------------------|---------------------|--------------|----------------------|---------------------|--------------|------------------------|---------------------|--|-----|-------|
|   | Тураалтай            |                     | Хүүхдийн тоо | Өсөлт хойролттой     |                     | Хүүхдийн тоо | Туранхай               |                     | Илүүдэл жинтэй дээгүүр + 2 CX <sup>6</sup> |     |       |
|   | - 2 CX <sup>1</sup>  | - 3 CX <sup>2</sup> |              | - 2 CX <sup>3</sup>  | - 3 CX <sup>4</sup> |              | - 2 CX <sup>5</sup>    | - 3 CX <sup>6</sup> |  |     |       |
| <b>Хүнс</b>                                 | 3.6                  | 1.1                 | 1 857        | 17.1                 | 5.5                 | 1 846        | 1.9                    | 0.9                 | 11.9                                       | 0.8 | 1 839 |
| Эрэгтэй                                     | 3.0                  | 0.8                 | 1 851        | 13.5                 | 3.8                 | 1 839        | 1.3                    | 0.5                 | 9.8  | 0.7 | 1 834 |
| <b>Бүс</b>                                  | 4.1                  | 1.6                 | 575          | 24.5                 | 6.7                 | 574          | 1.4                    | 0.9                 | 8.3  | 0.7 | 571   |
| Баруун                                      | 4.2                  | 0.9                 | 843          | 18.0                 | 4.9                 | 830          | 1.7                    | 0.4                 | 10.0                                       | 0.7 | 832   |
| Хангай                                      | 2.5                  | 0.8                 | 684          | 12.9                 | 4.0                 | 682          | 0.8                    | 0.1                 | 8.3  | 0.6 | 680   |
| Төв   | 2.6                  | 0.3                 | 276          | 15.5                 | 2.9                 | 274          | 1.0                    | 0.4                 | 7.8  | 0.8 | 273   |
| Зүүн  | 3.0                  | 0.9                 | 1 330        | 10.8                 | 4.4                 | 1 323        | 2.2                    | 1.1                 | 14.4                                       | 0.8 | 1 317 |
| Улаанбаатар                                 |                      |                     |              |                      |                     |              |                        |                     |  |     |       |
| <b>Хот, хөдөө</b>                           | 2.8                  | 0.7                 | 2 139        | 11.9                 | 4.1                 | 2 130        | 1.9                    | 0.9                 | 12.8                                       | 0.7 | 2 121 |
| Хот   | 4.0                  | 1.3                 | 1 570        | 19.9                 | 5.5                 | 1 555        | 1.3                    | 0.4                 | 8.2  | 0.7 | 1 552 |
| <b>Байршил</b>                              |                      |                     |              |                      |                     |              |                        |                     |  |     |       |
| Нийслэл                                     | 3.0                  | 0.9                 | 1 330        | 10.8                 | 4.4                 | 1 323        | 2.2                    | 1.1                 | 14.4                                       | 0.8 | 1 317 |
| Аймгийн төв                                 | 2.5                  | 0.3                 | 808          | 13.8                 | 3.6                 | 807          | 1.4                    | 0.5                 | 10.2                                       | 0.7 | 804   |
| Сумын төв                                   | 3.9                  | 1.3                 | 658          | 15.0                 | 4.2                 | 652          | 0.8                    | 0.3                 | 7.4  | 0.6 | 650   |
| Хөдөө                                       | 4.1                  | 1.3                 | 912          | 23.5                 | 6.4                 | 903          | 1.6                    | 0.5                 | 8.8  | 0.7 | 902   |
| <b>Насны бүлэг</b>                          |                      |                     |              |                      |                     |              |                        |                     |  |     |       |
| 0-5 сартай                                  | 8.4                  | 2.5                 | 381          | 8.0                  | 3.8                 | 375          | 6.4                    | 3.6                 | 13.1                                       | 0.4 | 372   |
| 6-11 сартай                                 | 0.8                  | 0.2                 | 407          | 7.0                  | 1.4                 | 404          | 0.4                    | 0.3                 | 12.3                                       | 1.0 | 406   |
| 12-23 сартай                                | 2.6                  | 1.2                 | 897          | 20.5                 | 6.6                 | 893          | 1.1                    | 0.2                 | 16.2                                       | 0.9 | 890   |
| 24-35 сартай                                | 3.6                  | 0.9                 | 774          | 19.6                 | 6.1                 | 770          | 1.6                    | 0.2                 | 9.2  | 0.8 | 766   |
| 36-47 сартай                                | 3.0                  | 0.4                 | 668          | 15.5                 | 4.8                 | 665          | 0.2                    | 0.2                 | 7.1  | 0.7 | 662   |
| 48-59 сартай                                | 2.8                  | 0.8                 | 582          | 11.7                 | 2.6                 | 578          | 1.7                    | 0.9                 | 6.7  | 0.5 | 577   |
| <b>Эхийн боловсрол*</b>                     |                      |                     |              |                      |                     |              |                        |                     |  |     |       |
| Боловсролгүй                                | 8.0                  | 2.9                 | 175          | 28.2                 | 11.8                | 173          | 1.0                    | 1.0                 | 7.5  | 0.6 | 173   |
| Бага  | 5.1                  | 1.2                 | 283          | 21.1                 | 7.1                 | 280          | 2.0                    | 0.3                 | 10.0                                       | 0.7 | 279   |
| Суурь                                       | 3.6                  | 1.1                 | 692          | 20.6                 | 6.7                 | 687          | 1.1                    | 0.0                 | 7.7  | 0.7 | 684   |
| Бүрэн дунд                                  | 3.1                  | 0.6                 | 1 015        | 15.9                 | 4.0                 | 1 011        | 1.8                    | 0.9                 | 10.1                                       | 0.7 | 1 003 |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд      | 3.3                  | 0.4                 | 250          | 15.1                 | 2.9                 | 248          | 1.2                    | 0.2                 | 9.8  | 0.7 | 250   |
| Дээд  | 2.3                  | 0.9                 | 1 293        | 9.1                  | 3.0                 | 1 286        | 1.8                    | 1.0                 | 13.9                                       | 0.7 | 1 284 |
| <b>Өрхийн аж байдалын түвшин</b>            |                      |                     |              |                      |                     |              |                        |                     |  |     |       |
| Доогуур                                     | 5.0                  | 1.3                 | 884          | 25.2                 | 7.6                 | 876          | 1.2                    | 0.3                 | 7.5  | 0.7 | 872   |
| Дунджаас доогуур                            | 4.0                  | 0.8                 | 743          | 18.4                 | 5.6                 | 737          | 1.5                    | 0.6                 | 8.6  | 0.7 | 737   |
| Дундаж                                      | 2.9                  | 1.0                 | 729          | 11.4                 | 4.1                 | 726          | 2.3                    | 1.2                 | 11.3                                       | 0.7 | 721   |
| Дунджаас дээгүүр                            | 3.2                  | 0.9                 | 684          | 11.9                 | 3.5                 | 680          | 2.3                    | 1.3                 | 13.8                                       | 0.8 | 678   |
| Дээгүүр                                     | 0.9                  | 0.7                 | 669          | 6.5                  | 1.7                 | 665          | 0.8                    | 0.2                 | 14.3                                       | 0.7 | 665   |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |                      |                     |              |                      |                     |              |                        |                     |  |     |       |
| Халх  | 3.2                  | 0.9                 | 2 982        | 14.1                 | 4.5                 | 2 963        | 1.7                    | 0.8                 | 11.2                                       | 0.7 | 2 952 |
| Казаак                                      | 8.9                  | 5.1                 | 129          | 30.4                 | 10.0                | 128          | 1.1                    | 0.6                 | 8.1  | 0.4 | 127   |
| Бусад                                       | 2.5                  | 0.5                 | 590          | 18.4                 | 4.6                 | 585          | 1.0                    | 0.4                 | 9.9  | 0.7 | 586   |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |                      |                     |              |                      |                     |              |                        |                     |  |     |       |
| Шүтдэггүй                                   | 3.0                  | 0.9                 | 1 703        | 14.9                 | 4.9                 | 1 697        | 1.7                    | 0.7                 | 10.1                                       | 0.7 | 1 687 |
| Будда                                       | 3.6                  | 0.8                 | 1 749        | 14.3                 | 4.2                 | 1 732        | 1.7                    | 0.8                 | 11.7                                       | 0.7 | 1 731 |
| Ислам                                       | 9.1                  | 5.2                 | 98           | 32.7                 | 8.8                 | 98           | 0.9                    | 0.8                 | 9.8  | 0.5 | 98    |
| Бусад                                       | 0.6                  | 0.6                 | 148          | 19.9                 | 4.2                 | 148          | 0.0                    | 0.0                 | 10.0                                       | 0.7 | 145   |
| <b>Бүгд</b>                                 | 3.3                  | 0.9                 | 3 708        | 15.3                 | 4.7                 | 3 684        | 1.6                    | 0.7                 | 10.9                                       | 0.7 | 3 672 |

\* Эхийн боловсрол гэдэгт 5 хүртэлх насны хүүхдийн эх асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

\*\* Яйнгөлдээгүй үеийн 12, 12, 12 тохиолдол Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь харгалзан харуулагдаагүй байсныг харуулаагүй болно.

\*\*\* Жйнгөлдээгүй үеийн 13, 13, 14 тохиолдол Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг нь харгалзан харуулагдаагүй байсныг нь харуулаагүй болно.

<sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 2.1а, <sup>2</sup> МХЗ-ын үзүүлэлт 1.8

<sup>3</sup> ХХС-ны үзүүлэлт 2.1б

<sup>4</sup> МХЗ-ын үзүүлэлт 2.2а, <sup>5</sup> МХЗ-ын үзүүлэлт 2.2б

<sup>6</sup> ХХС-ны үзүүлэлт 2.3а, <sup>7</sup> МХЗ-ын үзүүлэлт 2.3б

**Хүснэгт NU.2: Эрт амлуулалт**

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн эхийн сүүгээр хооллож байсан хүүхдийн хувь, төрсний дараа 1 цагийн дотор болон 1 өдрийн дотор ангир уургаа амласан хүүхдийн хувь, ангир уургаа амлахаас өмнө ямар нэг зүйлээр хооллосон хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он

|   | Эхийн сүүгээр хооллож байсан <sup>1</sup> | Ангир уургаа амласан хувь:                 |                               | Ангир уургаа амлахаас өмнө ямар нэгэн зүйлээр хооллосон | Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрүүлсэн хамгийн сүүлийн хүүхдийн тоо |
|---|---|--|-------------------------------|---|--|
|   |   | Төрсний дараах 1 цагийн дотор <sup>2</sup> | Төрсний дараах 1 өдрийн дотор |   |  |
| <b>Бүс</b>  |   |  |                               |   |  |
| Баруун  | 97.6                                      | 63.8                                       | 92.4                          | 4.3   | 241  |
| Хангай  | 96.5                                      | 79.7                                       | 93.0                          | 7.3   | 374  |
| Төв   | 96.2                                      | 64.0                                       | 90.4                          | 12.6  | 308  |
| Зүүн  | 98.6                                      | 78.6                                       | 95.7                          | 3.7   | 107  |
| Улаанбаатар                                       | 98.4                                      | 71.8                                       | 91.5                          | 11.7  | 624  |
| <b>Хот, хөдөө</b>                                 |   |  |                               |   |  |
| Хот   | 98.1                                      | 71.8                                       | 91.6                          | 11.3  | 992  |
| Хөдөө   | 96.6                                      | 70.9                                       | 92.8                          | 6.2   | 662  |
| <b>Байршил</b>                                    |   |  |                               |   |  |
| Нийслэл   | 98.4                                      | 71.8                                       | 91.5                          | 11.7  | 624  |
| Аймгийн төв                                       | 97.5                                      | 71.7                                       | 91.6                          | 10.8  | 368  |
| Сумын төв   | 98.9                                      | 71.6                                       | 95.5                          | 8.3   | 281  |
| Хөдөө   | 94.8                                      | 70.4                                       | 90.8                          | 4.6   | 381  |
| <b>Сүүлийн хүүхдээ төрүүлснээс хойшхи хугацаа</b> |   |  |                               |   |  |
| 0-11 сар  | 97.9                                      | 71.2                                       | 92.6                          | 8.8   | 781  |
| 12-23 сар   | 97.2                                      | 71.6                                       | 91.5                          | 9.9   | 847  |
| <b>Төрөх үеийн тусламж</b>                        |   |  |                               |   |  |
| Мэргэжлийн эмчийн хяналтад                        | 97.9                                      | 71.8                                       | 92.5                          | 9.4   | 1 635  |
| Хамаатан, найз нөхөд                              | (*)                                       | (*)  | (*)                           | (*)   | 5  |
| Бусад/ хариулаагүй                                | (*)                                       | (*)  | (*)                           | (*)   | 15   |
| <b>Хүүхдээ төрүүлсэн газар</b>                    |   |  |                               |   |  |
| Улсын эмнэлэг, амаржих газар                      | 98.1                                      | 71.9                                       | 92.7                          | 9.2   | 1 617  |
| Хувийн эмнэлэг, амаржих газар                     | (*)                                       | (*)  | (*)                           | (*)   | 13   |
| Гэр   | (*)                                       | (*)  | (*)                           | (*)   | 17   |
| Бусад/ хариулаагүй                                | (*)                                       | (*)  | (*)                           | (*)   | 8  |
| <b>Эхийн боловсрол**</b>                          |   |  |                               |   |  |
| Боловсролгүй                                      | 97.2                                      | 73.3                                       | 92.6                          | 3.4   | 61   |
| Бага  | 94.6                                      | 72.4                                       | 90.5                          | 0.3   | 116  |
| Суурь   | 98.5                                      | 73.3                                       | 94.8                          | 6.3   | 282  |
| Бүрэн дунд  | 96.5                                      | 74.7                                       | 91.1                          | 9.5   | 477  |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд            | 96.6                                      | 72.9                                       | 93.5                          | 5.0   | 103  |
| <b>Насны бүлэг</b>                          |  |                    |  |                          |
| 6-11 сартай                                 | 8.6  | 50.7               | 52.3   | 426                      |
| 12-23 сартай                                | 11.7   | 64.4               | 66.4   | 958                      |
| 24-35 сартай                                | 10.8   | 61.4               | 64.0   | 832                      |
| 36-47 сартай                                | 7.0  | 56.4               | 58.5   | 714                      |
| 48-59 сартай                                | 8.1  | 55.2               | 57.5   | 626                      |
| <b>Эхийн боловсрол*</b>                     |  |                    |  |                          |
| Боловсролгүй                                | 9.5  | 50.5               | 56.3   | 165                      |
| Бага  | 8.4  | 55.5               | 58.3   | 287                      |
| Суурь                                       | 10.8   | 61.8               | 64.5   | 659                      |
| Бүрэн дунд                                  | 8.5  | 60.0               | 61.5   | 957                      |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд      | 12.9   | 58.5               | 62.0   | 236                      |
| Дээд  | 9.3  | 58.3               | 59.8   | 1 251                    |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>             |  |                    |  |                          |
| Доогуур                                     | 10.4   | 54.5               | 58.3   | 832                      |
| Дунджаас доогуур                            | 9.8  | 58.6               | 61.7   | 700                      |
| Дундаж                                      | 10.0   | 63.8               | 65.5   | 667                      |
| Дунджаас дээгүүр                            | 7.7  | 62.9               | 63.7   | 697                      |
| Дээгүүр                                     | 9.5  | 55.2               | 56.3   | 659                      |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |  |                    |  |                          |
| Халх  | 10.3   | 60.7               | 63.0   | 2 848                    |
| Казак                                       | 1.5  | 37.2               | 38.3   | 133                      |
| Бусад                                       | 7.6  | 54.6               | 56.3   | 568                      |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |  |                    |  |                          |
| Шүтдэггүй                                   | 10.6   | 58.7               | 61.0   | 1 664                    |
| Будда                                       | 9.4  | 60.1               | 62.4   | 1 637                    |
| Ислам                                       | 1.4  | 38.2               | 39.6   | 106                      |
| Бусад                                       | 5.8  | 62.1               | 63.0   | 140                      |
| <b>Бүгд</b>                                 | 9.5  | 58.8               | 61.0   | 3 556                    |

\* Эхийн боловсрол гэдэгт 6-59 сартай хүүхдийн эх/ асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 11 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

\*\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь хариулагдаагүй 10 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

<sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 2.17

**Хүснэгт NU.11: Бага жинтэй төрсөн хүүхэд**

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд 2500 граммаас бага жинтэй төрсөн хүүхдийн хувь, төрөх үед нь жинлэсэн хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он

|   | Төрсөн хүүхдийн хувь:                  |                                    | Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн хүүхдийн тоо |
|---|--|------------------------------------|---|
|   | 2500 граммаас бага жинтэй <sup>1</sup> | Төрөх үед нь жинлэсэн <sup>2</sup> |   |
| <b>Бүс</b>                                  |  |                                    |   |
| Баруун                                      | 6.6                                    | 96.6                               | 241   |
| Хангай                                      | 4.4                                    | 98.3                               | 374   |
| Төв   | 5.4                                    | 97.2                               | 308   |
| Зүүн  | 4.9                                    | 98.6                               | 107   |
| Улаанбаатар                                 | 3.8                                    | 98.8                               | 624   |
| <b>Хот, хөдөө</b>                           |  |                                    |   |
| Хот   | 4.2                                    | 98.7                               | 992   |
| Хөдөө                                       | 5.6                                    | 97.1                               | 662   |
| <b>Байршил</b>                              |  |                                    |   |
| Нийслэл                                     | 3.8                                    | 98.8                               | 624   |
| Аймгийн төв                                 | 4.7                                    | 98.6                               | 368   |
| Сумын төв                                   | 5.9                                    | 97.3                               | 281   |
| Хөдөө                                       | 5.3                                    | 96.9                               | 381   |
| <b>Эхийн боловсрол*</b>                     |  |                                    |   |
| Боловсролгүй                                | 7.3                                    | 94.4                               | 61  |
| Бага  | 5.7                                    | 96.1                               | 116   |
| Суурь                                       | 5.8                                    | 97.6                               | 282   |
| Бүрэн дунд                                  | 4.2                                    | 97.6                               | 477   |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд      | 3.1                                    | 99.3                               | 103   |
| Дээд  | 4.5                                    | 99.1                               | 615   |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>             |  |                                    |   |
| Доогуур                                     | 5.9                                    | 96.8                               | 368   |
| Дунджаас доогуур                            | 5.0                                    | 96.7                               | 343   |
| Дундаж                                      | 4.7                                    | 98.5                               | 340   |
| Дунджаас дээгүүр                            | 4.0                                    | 99.4                               | 298   |
| Дээгүүр                                     | 3.8                                    | 99.3                               | 305   |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |  |                                    |   |
| Халх  | 4.7                                    | 98.5                               | 1 334   |
| Казак                                       | 8.9                                    | 89.1                               | 60  |
| Бусад                                       | 3.8                                    | 97.6                               | 257   |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |  |                                    |   |
| Шүтдэггүй                                   | 4.8                                    | 98.6                               | 742   |
| Будда                                       | 4.1                                    | 98.4                               | 782   |
| Ислам                                       | 10.1                                   | 90.0                               | 48  |
| Бусад                                       | 6.1                                    | 94.1                               | 71  |
| <b>Бүгд</b>                                 | <b>4.7</b>                             | <b>98.0</b>                        | <b>1 654</b>  |

\* Эхийн боловсрол гэдэгт судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн хүүхдийн насны хүүхдийн эх/ асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 6 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

\*\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь хариулагдаагүй 12 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

<sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 2.18

<sup>2</sup> ХХС-ны үзүүлэлт 2.19

# БҮЛЭГ VI

## ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД



© НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол /Сокол/ 2012 он

# VI

## Дархлаажуулалт

МХЗ-ын Зорилго 4-т 2015 он гэхэд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 оны түвшнээс гуравны хоёроор бууруулах зорилтыг тавьсан. Энэхүү зорилтыг хангахад дархлаажуулалт маш чухал үүрэгтэй. 1974 оноос хэрэгжүүлж эхэлсэн Дархлаажуулалтын Өргөжүүлсэн Хөтөлбөр өнгөрсөн 30 жилийн хугацаанд сая сая хүүхдийн амийг аварсаар ирсэн билээ. Гэвч манай гариг дээр 27 сая хүүхэд товлот дархлаажуулалтад хамрагдаж чадаагүйн улмаас вакцинаар урьдчилан сэргийлдэг өвчнөөр жилдээ 2 сая хүүхэд нас барж байна.

"Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалд улс орнууд үндэсний хэмжээнд нэг хүртэлх насны хүүхдийн 90 хувийг дархлаажуулалтад бүрэн хамруулах, тэр дундаа бүх аймаг, нийслэлийн түвшинд 80-аас дээш хувь хамруулах зорилгыг дэвшүүлсэн.

Монгол Улсад ДЭМБ/ НҮБХС-гийн удирдамжийн дагуу хүүхэд 12 сар хүртлээ сүрьеэгийн эсрэг (БЦЖ) вакцин, сахуу, татран, хөхүүл ханиадны эсрэг (гуравт) вакцины 3 тун, саагийн эсрэг вакцины 4 тун, гепатит Б-гийн эсрэг вакцины төрөх үеийн болон улаан бурханы эсрэг вакциныг хийлгэсэн байх ёстой. 5 хүртэлх насны хүүхдийн эх/ асрамжлагчаас дархлаажуулалтын дэвтрийг авч ярилцлага авагч дархлаажуулалтын талаарх мэдээллийг асуулгын хуудсанд хуулж тэмдэглэсэн.


Манай Улсад 2005 оноос өмнө хүүхдийг сүрьеэ, сахуу, хөхүүл ханиад, татрангийн гуравт, улаан бурхан, гепатит Б-гийн болон улаан бурханы вакцинаар дархлаажуулж байсан. Харин 2005 оноос хойш сахуу, хөхүүл ханиад, татран, Б вируст гепатит, Хиб-ийн таван вакциныг, 2009 оноос улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг нийлсэн нэг вакциныг "Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлот"-д шинээр оруулсан.

Судалгаанд хамрагдсан 12-23 сартай нийт хүүхдийн 85 хувь нь дархлаажуулалтын дэвтэртэй байлаа (Хүснэгт СН.2). Хэрвээ хүүхэд дархлаажуулалтын дэвтэргүй тохиолдолд вакцин тус бүрд хамрагдсан эсэх, гуравт/ тавт болон халдварт саагийн эсрэг вакцины хувьд хэдэн удаа хамрагдсан талаар хүүхдийн эх/ асрамжлагчаас тусгайлан асуусан. Судалгаанд хамрагдсан 12-23 сартай нийт хүүхдийн вакцин тус бүрд хамрагдсан байдлыг Хүснэгт СН.1-д хувиар илэрхийлж үзүүлэв. Тус хүснэгтэд судалгаанаас өмнөх аль ч хугацаанд болон 1 нас хүрэхээсээ өмнө дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн хувийг дархлаажуулалтын дэвтрээс эсвэл ээжийн мэдээлснээр тооцож үзүүлсэн.

12-23 сартай хүүхдүүдийн 98 хувь нь 12 сар хүрэхээсээ өмнө БЦЖ вакцинд, 96 хувь нь гуравт (сахуу, татран, хөхүүл ханиадны эсрэг) вакцины 1-р тунд хамрагдсан байна. Гуравт вакцины 2-р тунд хамрагдалт 94 хувь, 3-р тунд хамрагдалт 92 хувь хүртэл буурчээ (Зураг СН.1). Үүнтэй адил 12 сар хүрэхээсээ өмнө саагийн эсрэг вакцины эхний тунг хийлгэсэн хүүхэд 98 хувь байсан боловч гурав дахь тунг хийлгэсэн хүүхэд 93 хувь хүртэл буурсан байна. 12-23 сартай хүүхдүүдийн 97 хувь нь 12 сар хүрэхээсээ өмнө гепатит Б-гийн эсрэг вакцины төрөх үеийн тунд хамрагджээ. Улаан бурханы эсрэг вакцины эхний тунд хамрагдалтын хувь (87 хувь) бусад вакцины хамралтаас харьцангуй доогуур байлаа. Улсын хэмжээнд үзэхэд 1 нас хүрэхээсээ өмнө товллын вакцинуудаа бүрэн хийлгэсэн хүүхдийн хувь дөнгөж 76 хувь байна.



Зураг СН.1: 1 нас хүрэхээсээ өмнө шаардлагатай вакцинуудыг хийлгэсэн 12-23 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он



Хүснэгт СН.2-д 12-23 сартай хүүхдийн дархлаажуулалтын хамрагдалтын түвшинг шинж байдлаар үзүүлэв. Энэ үзүүлэлтүүд нь судалгаанаас өмнө дурын өдөр вакцинаа хийлгэсэн хүүхдүүдийн талаарх тоо мэдээлэл бөгөөд дархлаажуулалтын дэвтэр болон эхийн хэлсэнд үндэслэн тооцсон болно.

Дархлаажуулалтад хамрагдалт нь хүйс, байршил, хот, хөдөө, эхийн боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшнээр төдийлөн ялгаагүй байна. Харин Баруун болон Төвийн бүсийн хүүхдүүдийн дархлаажуулалтад хамрагдалт бусад бүсийн хүүхдүүдийнхээс харьцангуй доогуур түвшинд байна. Цаашлаад хамрагдвал зохих бүх вакцинд бүрэн хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувь эдгээр бүсэд хамгийн бага (67-68 хувь) байна.

### Суулгалт өвчний үеийн шингэн сэлбэх эмчилгээ

Манай гариг дээр 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын тэргүүлэх шалтгаануудын хоёрт суулгалт өвчин ордог. Суулгалт өвчнөөр нас барж байгаа гол шалтгаан нь шингэн болон эрдсийг их хэмжээгээр алдах явдал юм. Суулгалт өвчний үед шингэн сэлбэх давсны уусмал болон гэрийн нөхцөлд бэлдсэн шингэнүүдийг их хэмжээгээр уулгах нь хүүхдийг эндэхээс сэргийлэх гол арга хэмжээ болдог. Шингэн алдалт, усгүйжилтээс сэргийлж шингэн сэлбэх, тураалаас сэргийлж үргэлжлүүлэн хооллох зэрэг аргууд нь суулгалт өвчний эмчилгээний чухал арга хэмжээнд тооцогддог.

"Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалд "Тав хүртэлх насны хүүхдийн суулгалт өвчний улмаас эндэх эндэгдлийг 2010 он гэхэд 2000 оныхоос тал хувиар бууруулна", Мянганы хөгжлийн зорилтод "2015 он гэхэд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 оны түвшнээс гуравны хоёроор бууруулна" гэж зорилго дэвшүүлсэн. Түүнчлэн, "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглал нь суулгалт өвчний тохиолдлыг 25 хувиар бууруулахыг уриалсан билээ.

Гол үзүүлэлтүүд:

- Шингэн сэлбэх эмчилгээ
- Суулгалтын үед гэрийн нөхцөлд эмчлэх
- Шингэн сэлбэх эмчилгээний зэрэгцээ хоолыг үргэлжлүүлэн өгсөн байдал

"Хүүхэд хөгжил-2010" судалгааны асуулгад эх/ асрамжлагчаас тухайн хүүхэд судалгаанаас өмнөх 14 хоногийн хугацаанд суулгалтаар өвдсөн эсэхийг асуусан. Хэрэв тийм бол суулгалт өвчний үед тухайн хүүхдэд шингэн зүйл уулгасан эсэх, хоолыг үргэлжлүүлэн өгсөн эсэх болон хүүхдийн идсэн, уусан хэмжээ ердийн үеийнхээс их эсвэл бага эсэхийг тодруулсан асуултуудыг нарийвчлан асуусан.


Манай улс "Суулгалт өвчний хяналт", "Хүүхдийн өвчний цогц менежмент" (ХӨЦМ) хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд суулгалт өвчний улмаас хүүхэд эндэх нь маш эрчимтэй буурсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Тав хүртэлх насны хүүхдийн 10 хувь нь судалгаанаас өмнөх 14 хоногийн хугацаанд суулгалт өвчнөөр өвдсөн байна (Суулгалт өвчний тархалтын үзүүлэлтийн үр дүн нь улирал болон эхийн санах байдлаас ихээхэн хамаардаг тул энэ үр дүнг ашиглахдаа болгоомжлох хэрэгтэй). Бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн бага, Төвийн бүсэд хамгийн өндөр байна. Суулгалт хүүхдийг эхийн сүүгээр хооллохоо болих болон нэмэгдэл хоолонд оруулах үед буюу 0-23 сартай хүүхдүүдэд илүү тохиолддог нь харагдаж байна.

Хүснэгт СН.4-д хүүхдийг суулгалт өвчний үед уусан шингэн зүйлээр нь харуулсан бөгөөд хүснэгтэд хүүхдийн эх/ асрамжлагч хэд хэдэн төрлийн шингэн зүйл нэрлэсэн тул нийт дүн нь 100 хувь барихгүйг анхаарна уу. Суулгалт өвчнөөр өвдсөн хүүхдүүдийн 31 хувь нь үйлдвэрийн аргаар бэлтгэсэн шингэн сэлбэх давсны уусмал, 14 хувь нь гэрийн нөхцөлд бэлтгэсэн шингэн сэлбэх уусмал уусан байна. Харин суулгалтаар өвдсөн хүүхдүүдийн 42 хувь нь гэрийн нөхцөлд эмчлэх нэг ба түүнээс олон төрлийн эмчилгээ (үйлдвэрийн аргаар бэлтгэж савласан ШСУ эсвэл гэрийн нөхцөлд бэлтгэсэн ШСУ)-г хийлгэсэн байна.


Тав хүртэлх насны суулгалт өвчнөөр өвдсөн хүүхдүүдийн 43 хувь нь ердийнхөөс илүү их, 56 хувь нь ердийнхтэй адил болон бага шингэн уусан байна. Харин 90 хувь нь бага эсвэл ердийнхтэй адил эсвэл ердийнхөөс илүү хэмжээнд (хоолыг үргэлжлүүлэн идэх) хооллосон байхад 4 хувь нь маш бага, бараг хоол идээгүй гэсэн байна.

*Зураг СН.2: Суулгалт өвчний үед шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он*



Хүснэгт СН.6-д судалгаанаас өмнөх сэлбэх эмчилгээ хийлгэсэн 5 хүртэлх насны 14 хоногийн хугацаанд суулгалтаар өвчилсөн бөгөөд шингэн сэлбэх эмчилгээ хийлгэхийн зэрэгцээ үргэлжлүүлэн хооллож байсан 0-59 сартай хүүхэд болон бусад эмчилгээ авсан талаарх мэдээллийг хувиар харуулав. Суулгалтаар өвдсөн хүүхдүүдийн 56 хувь нь ердийнхөөс илүү шингэн уусан эсвэл шингэн сэлбэх давсны уусмал уусан байна. Харин эдгээр хүүхдүүдийн 62 хувь нь шингэн сэлбэх эмчилгээ хийлгэжээ (шингэн сэлбэх давс болон ХӨЦМ-өөр зөвлөж буй гэрийн шингэн).

*Зураг СН.3: Суулгалт өвчний үед шингэн сэлбэх эмчилгээний зэрэгцээ хоолоо үргэлжлүүлэн идсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он*



Хүснэгт СН.4, СН.5-ын мэдээллийг нэгтгэж үзвэл суулгалттай хүүхдүүдийн 56 хувь нь шингэн сэлбэх эмчилгээ хийлгэхийн зэрэгцээ ХӨЦМ-ийн зөвлөмжийн дагуу үргэлжлүүлэн хооллож байжээ. Суулгалт өвчний үед зохих эмчилгээг хийлгэсэн хүүхдүүд хүйс (эрэгтэй 58 хувь, эмэгтэй 54 хувь) болон хот, хөдөөгөөр (55 болон 57 хувь) төдийлөн ялгаагүй байна. Баруун бүс болон Улаанбаатар хотын эх асрамжлагчдын тал хувь (48-50

хувь) нь хүүхдээ суулгалт өвчнөөр өвдсөн үед зохих эмчилгээг хийж байгааг Хүснэгт СН.6-аас харж болно. Суулгалт өвчний үеийн эмчилгээ, асаргааг өрхийн аж байдлын түвшнээр авч үзэхэд ялгаатай дүр зураг ажиглагдаж байгаа бөгөөд гагцхүү дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүд суулгалт өвчнөөр өвдсөн үед тэдний эх/ асрамжлагчид зөв, зохистой арга хэмжээг илүү авч (66 хувь) байна.

**Хатгалгааны үед антибиотик хэрэглэх ба эмнэлгийн тусламж хайх мэдлэг**

Уушгины хатгалгаа нь хүүхдийн эндэгдлийн зонхилох шалтгааны нэг бөгөөд 5 хүртэлх насны хүүхэд уушгины хатгалгаагаар өвдсөн байж болзошгүй үед антибиотик хэрэглэх нь гол эмчилгээний арга юм. "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалын бас нэг зорилго нь амьсгалын цочмог халдварын улмаас эндэх эндэгдлийг гуравны нэгээр бууруулах асуудал юм.

Хатгалгаа өвчин нь хамар битүүрэх, цээж хэржигнэх шинж биш харин ханиалгалт, амьсгалын тоо олшрох, амьсгал саадтай болох хавсарсан шинжээр илэрдэг.

Гол үзүүлэлтүүд:

- Уушгины хатгалгаа өвчний шинж тэмдэг илэрсэн үед мэргэжлийн эмчид хандсан байдал
- Уушгины хатгалгаа өвчний шинж тэмдэг илэрсэн үед антибиотик хэрэглэх
- Уушгины хатгалгаа өвчний үндсэн 2 шинж тэмдгийн талаарх мэдлэг

Хүснэгт СН.7-д уушгины хатгалгаа өвчнөөр өвдсөн байж болзошгүй хүүхэд болон тэдэнд гэрээс гадуур эмчилгээ хийлгэсэн газрыг харуулсан (Уушгины хатгалгаа өвчний тархалтын үзүүлэлтийн үр дүн нь улирал болон эхийн санах байдлаас ихээхэн хамаардаг тул энэ үр дүнг ашиглахдаа болгоомжлох хэрэгтэй). Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны нийт хүүхдийн 2 хувь нь судалгааны өмнөх 14 хоногт уушгины хатгалгаагаар өвдсөн байж болзошгүй байв. Тэдгээрээс 87 хувь нь зохих тусламж авчээ.

Мөн хүснэгт СН.7-д хатгалгааны шинж тэмдэг илэрсэн байж болзошгүй 5 хүртэлх насны хүүхдэд антибиотик эмчилгээ хийсэн байдлыг хүүхдийн нас, хүйс, амьдарч байгаа өрхийн байршил, эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшнээр харуулсан. Уушгины хатгалгаа өвчний шинж тэмдэг илэрсэн байж болзошгүй нийт хүүхдийн 73 хувь нь антибиотик эмчилгээ хийлгэсэн байна. Уушгины хатгалгаагаар өвдсөн байж болзошгүй

хүүхдийн тоо цөөн тул тохирох тусламж авсан болон антибиотик эмчилгээ хийлгэсэн талаарх үзүүлэлтүүдийг шууд ашиглаж болохгүйг анхаарна уу.

Хатгалгааны үеийн аюултай шинж тэмдгийн талаарх мэдлэгтэй холбоотой үзүүлэлтийг хүснэгт СН.8-д харуулав. Аюултай шинж тэмдгийн талаарх эхийн мэдлэг нь уушгины хатгалгааны үед тохирох тусламж хайх суурь хүчин зүйл мөн. Судалгаанд хамрагдсан нийт эхийн ердөө 1 хувь нь хатгалгааны үеийн аюултай 2 шинж болох амьсгал олшрох, амьсгал саадтай болохыг мэдэж байлаа. Хүүхдийг эмнэлэгт яаралтай үзүүлдэг хамгийн түгээмэл шинж нь халууралт байгааг хүснэгтээс харж болно. Эхчүүдийн 4 хувь нь амьсгал олширвол, 3 хувь нь амьсгал саадтай болбол яаралтай эмнэлэгт хандана гэжээ.

### Хатуу түлшний хэрэглээ

Манай гариг дээр 3 тэрбум гаруй хүн эрчим хүчний үндсэн хэрэглээ буюу халаалт болон хоол хүнсээ болгохдоо хатуу түлш хэрэглэж байна. Хатуу түлшийг халаалт болон хоол хүнс болгохдоо хэрэглэснээр гэрийн дотор их утаа үүсч, бусад зүйлтэй холилдон эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаг. Хатуу түлш хэрэглэснээр дутуу шатсан нүүрстөрөгч ба устөрөгчийн холимог нэгдэл үүсдэгт гол асуудал нь оршдог. Хатуу түлш хэрэглэх нь амьсгалын замын цочмог өвчнүүд, хатгалгаа, уушгины архаг өвчнүүд, хавдар, сүрьеэ, хүүхэд бага жинтэй төрөх, нүдний болрын цайлт, багтраа өвчнүүдээр өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Анхдагч шалгуур үзүүлэлт нь хоол ундаа хийхдээ ихэнхдээ хатуу түлш хэрэглэдэг хүн амын нийт хүн амд эзлэх хувь юм.

Монголын айл өрхүүдийн 68 хувь нь хоол, ундаа болгохдоо хатуу түлш хэрэглэж байна. Хотын өрхүүдийн тал орчим буюу 54 хувь нь хатуу түлш хэрэглэж байхад хөдөөд хатуу түлшний хэрэглээ маш өндөр буюу 90 хувь байгаа юм. Хатуу түлшний хэрэглээ өрхийн аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр ялгаатай байна. Дээгүүр аж байдалтай өрхүүд хоол ундаа болгохдоо хатуу түлшийг бараг хэрэглэдэггүй (2 хувь), харин доогуур аж байдалтай өрхийн хувьд бараг бүгд (99 хувь) хатуу түлш хэрэглэж байна. Хүснэгтээс харахад хоол, ундаа болгохдоо мод болон нүүрс хэрэглэх нь их байгаагаас хатуу түлшний хэрэглээ ерөнхийдөө өндөр байна.

Харилцан адилгүй зууханд ижил түлш хэрэглэхэд бохирдуулагч бодисын хэмжээ харилцан адилгүй байдаг бөгөөд хатуу түлш дагнан хэрэглэх нь гэрийн дотоод орчны агаарын бохирдлын гол шалтгаан болдог. Битүү бөгөөд яндантай зуух нь гэрийн дотоод агаарын бохирдол бага үүсгэдэг байхад задгай зуух нь хатуу түлшнээс үүсэх хортой бодисын нөлөөнөөс хамгаалах боломжгүй байдаг. Хүснэгт СН.10-т хатуу түлшний хэрэглээг хоолоо хийдэг газраар нь үзүүлсэн. Хоол, хүнсээ болгохдоо хатуу түлш хэрэглэдэг өрхүүдийн 31 хувь нь гал тогооны тусдаа өрөөтэй байхад 69 хувь нь гал тогооны тусдаа өрөөгүй байна. Энэ нь гэр доторх агаарын бохирдолд өртөх магадлал манай улсад их байгааг харуулж байгаа юм. Мөн уг үзүүлэлт өрхийн шинж байдлаар эрс ялгаатай байгааг хүснэгтээс харж болно.

### Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхэд болон хүүхдийн осол, гэмтэл

Энэ удаагийн судалгаанд "2-14 насны хүүхдийн асуулга"<sup>12</sup>-р тэдний хөгжлийн бэрхшээлийн болон осол, гэмтэлд өртсөн байдлыг судалсан.

<sup>12</sup> Энэ асуулгаар Эрүүл мэндийн яамны санал болгосноор хүүхдийн осол, гэмтлийг судалсан.

Судалгаанд хамрагдсан 2-14 насны нийт хүүхдийн 14 хувь нь ямар нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй байна<sup>13</sup> (Хүснэгт СН.17). Хотын хүүхдүүдийн 12 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй байхад хөдөө амьдардаг хүүхдүүдийн хувьд уг үзүүлэлт харьцангуй өндөр буюу 15 хувьтай байв. Бүсээр авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдийн хувь бусад бүсүүдтэй харьцуулахад Улаанбаатар хотод хамгийн бага (11 хувь), харин Төвийн бүсэд хамгийн өндөр (19 хувь) байна. Хүснэгт СН.17-оос харахад хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдийн хувь насны бүлэг, эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай байна. Бага насны хүүхдүүд, бага боловсролтой эхийн хүүхдүүд болон доогуур аж байдалтай өрхөд амьдарч байгаа хүүхдүүдийн хувьд бусад хүүхдүүдтэй харьцуулахад илүү хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй байгаа юм.

Судалгаанаас өмнөх 1 жилийн хугацаанд 2-14 насны хүүхдийн 4 хувь нь ямар нэг төрлийн осол, гэмтэлд өртсөн байгааг Хүснэгт СН.17А-аас харж болно. Хөвгүүдийн хувьд осол, гэмтэлд илүү өртөх хандлагатай байна. Хүүхдийн осол, гэмтэлд өртсөн хувь хот, хөдөөгөөр болон өрхийн аж байдлын түвшнээр төдийлөн ялгаагүй байв. Осол, гэмтэлд өртсөн 2-14 насны хүүхдүүдийн хувь бусад бүстэй харьцуулахад Улаанбаатар хотод хамгийн бага буюу 3 хувь байлаа.

Хүүхдүүдийн дунд унаж гэмтэх (53 хувь) хамгийн түгээмэл байгааг Хүснэгт СН.17А-аас харж болно. Хүүхэд ихэвчлэн гэртээ (29 хувь), гудамж, талбай, зам дээр (24 хувь) болон хөдөө, хээр (22 хувь) байхдаа осол гэмтэлд өртдөг байна (Хүснэгт СН.17В).

---

<sup>13</sup> Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг хүүхдийн эх/ асрамжлагчийн хэлсэнд үндэслэн тооцсон бөгөөд мэргэжлийн үнэлгээ хийгээгүй болно.

**Хүснэгт СН.1: Нэг нас хүрэхийн өмнөх дархлаажуулалтад хамрагдалт**

1 нас хүрэхээсээ өмнө хүүхдийн өвчлөлийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он

|   | Судалгаанаас өмнө дархлаажуулалтад хамрагдсан         |                    |            | 1 нас хүрэхээсээ өмнө дархлаажуулалтад хамрагдсан |
|---|---|--------------------|------------|---|
|   | Дархлаажуулалтын дэвтэрнээс                           | Ээжийн мэдээлснээр | Аль аль нь |   |
| Сүрьеэ <sup>1</sup>                         | 83.1  | 14.9               | 97.9       | 97.9  |
| <b>Саа</b>                                  |   |                    |            |   |
| Төрөх үеийн                                 | 83.1  | 14.8               | 97.9       | 97.9  |
| 1   | 84.0  | 13.7               | 97.7       | 97.6  |
| 2   | 83.8  | 12.8               | 96.6       | 96.4  |
| 3 <sup>2</sup>                              | 81.8  | 12.0               | 93.8       | 93.3  |
| <b>Гуравт/ тавт</b>                         |   |                    |            |   |
| 1   | 81.4  | 14.2               | 95.6       | 95.5  |
| 2   | 80.8  | 13.7               | 94.5       | 94.3  |
| 3 <sup>3</sup>                              | 79.1  | 13.3               | 92.4       | 92.1  |
| <b>Хепатит Б</b>                            |   |                    |            |   |
| Төрөх үеийн                                 | 82.9  | 13.7               | 96.7       | 96.7  |
| <b>Улаанбурхан, улаанууд, гахайн хавдар</b> |   |                    |            |   |
| 1 <sup>4</sup>                              | 74.6  | 13.2               | 87.8       | 86.6  |
| Бүх дархлаажуулалтад хамрагдсан             | 67.5  | 9.8                | 77.4       | 75.7  |
| Дархлаажуулалтад хамрагдаагүй               | 0.0   | 0.2                | 0.2        | 0.2   |
| 12-23 сартай хүүхдийн тоо                   | 944   | 944                | 944        | 944   |
|   | <sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 3.1;                     |                    |            |   |
|   | <sup>2</sup> ХХС-ны үзүүлэлт 3.2;                     |                    |            |   |
|   | <sup>3</sup> ХХС-ны үзүүлэлт 3.3                      |                    |            |   |
|   | <sup>4</sup> ХХС-ны үзүүлэлт 3.4; МХЗ-ын үзүүлэлт 4.3 |                    |            |   |

**Хүснэгт СН.2: Дархлаажуулалтад хамрагдалт, сонгосон шинж байдлаар**

Хүүхдийн өвчлөлийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо, Монгол Улс, 2010 он

Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн хувь:

|   | Сурьээ      |        |        | Төрөх үеийн |        |        | Саа         |        |        | Гуравт/тавт |        |        | Хөлатит Б |        | Улаан- бурхан, улаанууд, гахайн хавдар 1 | Хамраг- даагүй | Бүх дархлаа- жуулалтад хамрагдсан | Дархлаа- жуулалтын дэвтрийг үзсэн хувь | 12-23 сартай хүүхдийн тоо |  |
|---|-------------|--------|--------|-------------|--------|--------|-------------|--------|--------|-------------|--------|--------|-----------|--------|--|----------------|-----------------------------------|--|---------------------------|--|
|   | Төрөх үеийн |        |        | Төрөх үеийн |        |        | Төрөх үеийн |        |        | Төрөх үеийн |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
|   | 1           | 2      | 3      | 1           | 2      | 3      | 1           | 2      | 3      | 1           | 2      | 3      | 1         | 2      |  |                |                                   |  |                           |  |
| <b>Хүйс</b>                                 |             |        |        |             |        |        |             |        |        |             |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
| Эрэгтэй                                     | 98.4        | 97.7   | 94.0   | 95.6        | 94.3   | 92.7   | 97.6        | 97.6   | 97.6   | 97.6        | 97.6   | 97.6   | 97.6      | 97.6   | 86.2                                     | 0.5            | 77.7                              | 86.5                                   | 450                       |  |
| Эмэгтэй                                     | 97.5        | 97.8   | 93.6   | 95.7        | 94.6   | 92.2   | 95.8        | 95.8   | 95.8   | 95.8        | 95.8   | 95.8   | 95.8      | 95.8   | 89.3                                     | 0.0            | 77.1                              | 82.9                                   | 493                       |  |
| <b>Бүс</b>                                  |             |        |        |             |        |        |             |        |        |             |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
| Баруун                                      | 96.4        | 97.6   | 91.2   | 93.2        | 91.4   | 88.7   | 93.3        | 93.3   | 93.3   | 93.3        | 93.3   | 93.3   | 93.3      | 93.3   | 79.8                                     | 0.9            | 67.7                              | 79.8                                   | 127                       |  |
| Хангай                                      | 98.9        | 100.0  | 98.1   | 94.2        | 93.6   | 92.6   | 97.3        | 97.3   | 97.3   | 97.3        | 97.3   | 97.3   | 97.3      | 97.3   | 94.1                                     | 0.0            | 84.5                              | 87.5                                   | 228                       |  |
| Төв   | 95.9        | 94.2   | 87.1   | 96.5        | 90.0   | 88.5   | 93.3        | 93.3   | 93.3   | 93.3        | 93.3   | 93.3   | 93.3      | 93.3   | 84.5                                     | 0.5            | 67.1                              | 83.2                                   | 163                       |  |
| Зүүн  | 98.1        | 98.8   | 93.1   | 98.1        | 96.7   | 95.3   | 97.3        | 97.3   | 97.3   | 97.3        | 97.3   | 97.3   | 97.3      | 97.3   | 88.7                                     | 0.0            | 81.0                              | 87.4                                   | 55                        |  |
| Улаанбаатар                                 | 98.8        | 97.8   | 95.1   | 96.6        | 97.7   | 94.9   | 98.8        | 98.8   | 98.8   | 98.8        | 98.8   | 98.8   | 98.8      | 98.8   | 87.9                                     | 0.0            | 80.2                              | 84.8                                   | 371                       |  |
| <b>Хот, хөдөө</b>                           |             |        |        |             |        |        |             |        |        |             |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
| Хот   | 98.9        | 97.8   | 94.5   | 96.7        | 96.2   | 93.7   | 98.6        | 98.6   | 98.6   | 98.6        | 98.6   | 98.6   | 98.6      | 98.6   | 89.4                                     | 0.1            | 79.9                              | 83.2                                   | 571                       |  |
| Хөдөө                                       | 96.4        | 97.1   | 92.7   | 94.1        | 91.9   | 90.5   | 93.8        | 93.8   | 93.8   | 93.8        | 93.8   | 93.8   | 93.8      | 93.8   | 85.3                                     | 0.4            | 73.5                              | 86.8                                   | 373                       |  |
| <b>Байршил</b>                              |             |        |        |             |        |        |             |        |        |             |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
| Нийслэл                                     | 98.8        | 97.8   | 95.1   | 96.6        | 97.7   | 94.9   | 98.8        | 98.8   | 98.8   | 98.8        | 98.8   | 98.8   | 98.8      | 98.8   | 87.9                                     | 0.0            | 80.2                              | 84.8                                   | 371                       |  |
| Аймгийн төв                                 | 99.1        | 97.6   | 93.4   | 96.7        | 93.3   | 91.4   | 98.1        | 98.1   | 98.1   | 98.1        | 98.1   | 98.1   | 98.1      | 98.1   | 92.1                                     | 0.3            | 79.4                              | 80.3                                   | 201                       |  |
| Сумын төв                                   | 96.6        | 98.4   | 93.3   | 96.4        | 93.5   | 91.8   | 93.6        | 93.6   | 93.6   | 93.6        | 93.6   | 93.6   | 93.6      | 93.6   | 84.7                                     | 0.5            | 73.3                              | 89.3                                   | 162                       |  |
| Хөдөө                                       | 96.3        | 97.9   | 92.3   | 92.3        | 90.7   | 89.5   | 93.9        | 93.9   | 93.9   | 93.9        | 93.9   | 93.9   | 93.9      | 93.9   | 85.8                                     | 0.3            | 73.6                              | 84.9                                   | 210                       |  |
| <b>Эхийн боловсрол*</b>                     |             |        |        |             |        |        |             |        |        |             |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
| Боловсролгүй                                | (95.6)      | (97.0) | (94.7) | (95.3)      | (95.3) | (91.2) | (94.8)      | (94.8) | (94.8) | (94.8)      | (94.8) | (94.8) | (94.8)    | (94.8) | (81.5)                                   | (0.0)          | (78.7)                            | (87.0)                                 | 39                        |  |
| Бага  | 98.3        | 98.1   | 94.8   | 94.9        | 94.5   | 94.4   | 94.5        | 94.5   | 94.5   | 94.5        | 94.5   | 94.5   | 94.5      | 94.5   | 90.2                                     | 0.9            | 82.8                              | 83.3                                   | 71                        |  |
| Суурь                                       | 98.7        | 98.3   | 96.4   | 97.9        | 96.8   | 96.1   | 96.8        | 96.8   | 96.8   | 96.8        | 96.8   | 96.8   | 96.8      | 96.8   | 89.8                                     | 0.0            | 81.2                              | 84.9                                   | 174                       |  |
| Бүрэн дүнд                                  | 97.2        | 98.0   | 91.3   | 94.5        | 93.8   | 90.0   | 96.6        | 96.6   | 96.6   | 96.6        | 96.6   | 96.6   | 96.6      | 96.6   | 87.9                                     | 0.2            | 75.5                              | 86.0                                   | 255                       |  |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дүнд      | 98.6        | 100.0  | 99.1   | 100.0       | 97.9   | 96.4   | 95.5        | 95.5   | 95.5   | 95.5        | 95.5   | 95.5   | 95.5      | 95.5   | 83.8                                     | 0.0            | 74.4                              | 92.2                                   | 60                        |  |
| Дээд  | 98.2        | 97.6   | 93.1   | 94.7        | 93.2   | 91.4   | 97.5        | 97.5   | 97.5   | 97.5        | 97.5   | 97.5   | 97.5      | 97.5   | 87.6                                     | 0.2            | 76.1                              | 82.2                                   | 345                       |  |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>             |             |        |        |             |        |        |             |        |        |             |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
| Доогуур                                     | 96.0        | 97.5   | 93.4   | 92.9        | 91.9   | 90.5   | 94.0        | 94.0   | 94.0   | 94.0        | 94.0   | 94.0   | 94.0      | 94.0   | 88.1                                     | 0.3            | 76.5                              | 85.4                                   | 202                       |  |
| Дунджаас доогуур                            | 98.9        | 98.6   | 95.1   | 97.1        | 94.1   | 93.2   | 96.7        | 96.7   | 96.7   | 96.7        | 96.7   | 96.7   | 96.7      | 96.7   | 80.4                                     | 0.3            | 72.1                              | 85.7                                   | 190                       |  |
| Дундаж                                      | 98.2        | 98.7   | 93.9   | 96.4        | 94.8   | 92.8   | 96.4        | 96.4   | 96.4   | 96.4        | 96.4   | 96.4   | 96.4      | 96.4   | 88.2                                     | 0.4            | 78.7                              | 83.3                                   | 191                       |  |
| Дунджаас дээгүүр                            | 99.3        | 97.7   | 91.5   | 96.0        | 94.9   | 90.6   | 99.3        | 99.3   | 99.3   | 99.3        | 99.3   | 99.3   | 99.3      | 99.3   | 90.5                                     | 0.0            | 79.3                              | 88.8                                   | 204                       |  |
| Дээгүүр                                     | 97.2        | 96.7   | 95.7   | 96.0        | 97.4   | 96.0   | 96.9        | 96.9   | 96.9   | 96.9        | 96.9   | 96.9   | 96.9      | 96.9   | 92.2                                     | 0.0            | 80.8                              | 78.8                                   | 157                       |  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |             |        |        |             |        |        |             |        |        |             |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
| Халх  | 98.2        | 97.9   | 94.1   | 95.6        | 94.9   | 92.4   | 96.7        | 96.7   | 96.7   | 96.7        | 96.7   | 96.7   | 96.7      | 96.7   | 88.0                                     | 0.1            | 77.6                              | 85.8                                   | 778                       |  |
| Бусад                                       | 96.9        | 98.0   | 93.1   | 95.7        | 93.0   | 93.0   | 96.4        | 96.4   | 96.4   | 96.4        | 96.4   | 96.4   | 96.4      | 96.4   | 86.5                                     | 0.7            | 76.8                              | 79.6                                   | 164                       |  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |             |        |        |             |        |        |             |        |        |             |        |        |           |        |  |                |                                   |  |                           |  |
| Шүтдэггүй                                   | 98.1        | 97.1   | 92.7   | 94.8        | 93.4   | 91.5   | 96.9        | 96.9   | 96.9   | 96.9        | 96.9   | 96.9   | 96.9      | 96.9   | 88.6                                     | 0.3            | 78.3                              | 85.8                                   | 455                       |  |
| Будда                                       | 98.0        | 97.3   | 94.8   | 96.6        | 96.0   | 93.4   | 96.3        | 96.3   | 96.3   | 96.3        | 96.3   | 96.3   | 96.3      | 96.3   | 88.4                                     | 0.0            | 77.4                              | 86.2                                   | 420                       |  |
| Бусад                                       | 96.4        | 98.2   | 94.7   | 95.0        | 92.6   | 92.6   | 97.4        | 97.4   | 97.4   | 97.4        | 97.4   | 97.4   | 97.4      | 97.4   | 78.3                                     | 0.8            | 70.0                              | 67.6                                   | 66                        |  |
| <b>Бүгд</b>                                 | 97.9        | 97.9   | 93.8   | 95.6        | 94.5   | 92.4   | 96.7        | 96.7   | 96.7   | 96.7        | 96.7   | 96.7   | 96.7      | 96.7   | 87.8                                     | 0.2            | 77.4                              | 84.7                                   | 944                       |  |

\* Эхийн боловсрол гэдэгт 12-23 сартай хүүхдийн эх/асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 1 ажиллалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

\*\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь хариулагдаагүй 4 ажиллалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

( ) 25-49 ажиллалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

**Хүснэгт СН.4: Үйлдвэрийн аргаар болон гэрийн нөхцөлд бэлтгэсэн шингэн сэлбэх давсны уусмал**

Сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн бөгөөд шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн 0-59 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он

|   | Сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн | 0-59 сартай хүүхдийн тоо | Дараахь эмчилгээг хийлгэсэн суулгалт өвчнөөр өвчилсөн хүүхэд: |                              |  | Сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн 0-59 сартай хүүхдийн тоо |
|---|--|--------------------------|---|------------------------------|--|---|
|   |  |                          | Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ШСУ                               | Гэрийн нөхцөлд бэлтгэсэн ШСУ | Үйлдвэрийн аргаар эсвэл гэрийн нөхцөлд бэлтгэсэн ШСУ |   |
| <b>Хүйс</b>                                 |  |                          |   |                              |  |   |
| Эрэгтэй                                     | 11.1   | 1 981                    | 31.6  | 13.9                         | 43.0   | 221   |
| Эмэгтэй                                     | 9.7  | 1 975                    | 29.3  | 13.3                         | 40.9   | 192   |
| <b>Бүс</b>                                  |  |                          |   |                              |  |   |
| Баруун                                      | 13.0   | 613                      | 25.5  | 12.9                         | 37.7   | 80  |
| Хангай                                      | 12.2   | 877                      | 33.2  | 18.9                         | 47.1   | 107   |
| Төв   | 14.8   | 739                      | 27.3  | 13.4                         | 38.4   | 109   |
| Зүүн  | 10.0   | 292                      | 41.4  | 22.9                         | 62.9   | 29  |
| Улаанбаатар                                 | 6.1  | 1 435                    | (32.4)  | (4.9)                        | (37.4)   | 87  |
| <b>Хот, хөдөө</b>                           |  |                          |   |                              |  |   |
| Хот   | 9.2  | 2 298                    | 35.1  | 9.2                          | 42.7   | 211   |
| Хөдөө                                       | 12.1   | 1 658                    | 25.8  | 18.2                         | 41.3   | 201   |
| <b>Байршил</b>                              |  |                          |   |                              |  |   |
| Нийслэл                                     | 6.1  | 1 435                    | (32.4)  | (4.9)                        | (37.4)   | 87  |
| Аймгийн төв                                 | 14.4   | 863                      | 37.0  | 12.3                         | 46.4   | 124   |
| Сумын төв                                   | 12.2   | 698                      | 25.2  | 12.0                         | 36.1   | 85  |
| Хөдөө                                       | 12.1   | 960                      | 26.2  | 22.8                         | 45.1   | 116   |
| <b>Насны бүлэг</b>                          |  |                          |   |                              |  |   |
| 0-11 сартай                                 | 14.7   | 826                      | 41.5  | 8.1                          | 48.8   | 122   |
| 12-23 сартай                                | 15.7   | 958                      | 34.3  | 16.9                         | 47.8   | 150   |
| 24-35 сартай                                | 8.8  | 832                      | 20.1  | 13.0                         | 30.2   | 73  |
| 36-47 сартай                                | 6.1  | 714                      | (18.0)  | (14.4)                       | (30.8)   | 44  |
| 48-59 сартай                                | 3.8  | 626                      | (6.0)   | (21.3)                       | (27.3)   | 24  |
| <b>Эхийн боловсрол*</b>                     |  |                          |   |                              |  |   |
| Боловсролгүй                                | 10.7   | 181                      | (22.1)  | (28.5)                       | (50.6)   | 19  |
| Бага  | 11.6   | 312                      | (22.3)  | (13.0)                       | (32.0)   | 36  |
| Суурь                                       | 8.3  | 730                      | 20.5  | 13.7                         | 31.4   | 60  |
| Бүрэн дунд                                  | 12.0   | 1 069                    | 32.6  | 13.3                         | 44.7   | 128   |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд      | 12.2   | 261                      | (29.5)  | (11.5)                       | (41.0)   | 32  |
| Дээд  | 9.7  | 1 403                    | 36.7  | 12.5                         | 45.9   | 136   |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>             |  |                          |   |                              |  |   |
| Доогуур                                     | 11.2   | 930                      | 24.0  | 20.9                         | 40.6   | 104   |
| Дунджаас доогуур                            | 11.1   | 797                      | 24.6  | 14.0                         | 36.3   | 88  |
| Дундаж                                      | 11.8   | 764                      | 34.9  | 10.2                         | 44.5   | 90  |
| Дунджаас дээгүүр                            | 8.5  | 738                      | 22.2  | 9.0                          | 30.3   | 62  |
| Дээгүүр                                     | 9.3  | 727                      | 50.4  | 10.9                         | 59.4   | 67  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |  |                          |   |                              |  |   |
| Халх  | 10.1   | 3 166                    | 29.7  | 12.9                         | 40.6   | 321   |
| Бусад                                       | 11.6   | 782                      | 33.4  | 16.2                         | 46.7   | 91  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |  |                          |   |                              |  |   |
| Шүтдэггүй                                   | 10.5   | 1 831                    | 29.3  | 15.3                         | 42.2   | 193   |
| Будда                                       | 10.4   | 1 843                    | 31.8  | 9.7                          | 40.1   | 192   |
| Бусад                                       | 9.1  | 271                      | (34.5)  | (27.9)                       | (56.1)   | 25  |
| <b>Бүгд</b>                                 | 10.4   | 3 956                    | 30.6  | 13.6                         | 42.0   | 412   |

\* Эхийн боловсрол гэдэгт 0-59 сартай хүүхдийн эх/ асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 12, 1 ажиглалт (жигнээгүй)-ыг харгалзан харуулаагүй болно.

\*\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь хариулагдаагүй 14, 3 ажиглалт (жигнээгүй)-ыг харгалзан харуулаагүй болно.

( ) 25-49 ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

(\*) 25 хүртэлх ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.



**Хүснэгт СН.5: Суулгалт өвчний үед хүүхдийг хооллосон байдал**

Сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн 0-59 сартай хүүхдийн хувь, өвчтэй үед уусан шингэн болон хоолны хэмжээгээр, Монгол Улс, 2010 он

|   | Суулгалт өвчний үед хүүхдийг хооллосон байдал           |                            |                            |                      |                                      | Суулгалт өвчний үеийн шингэн зүйл өгсөн байдал |                            |                          |                      |                  | Суулгалт өвчний үеийн хооллосон байдал   |                  |                            |  |                      |                  |  |      |   |  |
|---|---|----------------------------|----------------------------|----------------------|--------------------------------------|--|----------------------------|--------------------------|----------------------|------------------|--|------------------|----------------------------|--|----------------------|------------------|--|------|---|--|
|   | Хонот суулгалт өвчнөөр өвдсэн 0-59 сартай хүүхдийн хувь |                            | Хувийн хэмжээнээс маш бага |                      |                                      | Хувийн хэмжээнээс дундаж                       |                            |                          | Хувийн хэмжээнээс их |                  |  | Хоол өгт өгөөгүй |                            | Хоолнод орж үйлсэлж харуулаагүй/мэдэхгүй |                      |                  | Бүгд                                     |      | Сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсэн 0-59 сартай хүүхдийн тоо |  |
| Бусад                                       | 98.2                       | 1.4            | 0.0                              | 0.4             | 100.0                       | 97.7           | 1.4             | 0.0            | 100.0      | 99.1                  | 379                     |
| <b>Бүгд</b>                                 | 97.8                       | 1.7            | 0.4                              | 0.0             | 100.0                       | 97.7           | 1.7             | 0.2            | 100.0      | 98.9                  | 10 092                  |

\*"Өрхийн тэргүүлэгчийн боловсрол" нь хариулагдаагүй 33 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй болно.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 23 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

\*\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь хариулагдаагүй 30 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

¹ ХХС-ны үзүүлэлт 4.6

# БҮЛЭГ VIII

## НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД



© НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол /Жим Холмс/ 2007 он

# VIII

## Төрөлт

Дөрөв дэх удаагийн ХХС-гаар өсвөр насны охидын төрөлтийн коэффициент, төрөлтийн нийлбэр коэффициентийг судалгааны өмнөх нэг жилийн (1-12 сар) хугацаанд эмэгтэйчүүдийн хамгийн сүүлийн төрөлтийн хугацаа (он, сар, өдөр)-г үндэслэн тооцсон. Эдгээр коэффициентийн тооцоололд судалгааны өмнөх нэг жилийн хугацаанд ихэр төрөлт (хоёр, гурван ихэр гэх мэт) болон олон хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн талаарх мэдээлэл маш бага зөрүүтэй байсан.

Өсвөр насны охидын төрөлтийн коэффициент, төрөлтийн нийлбэр коэффициентийг Хүснэгт RH.1-д харуулав. Өсвөр насны охидын төрөлтийн коэффициент (15-19 насны эмэгтэйчүүдийн төрөлтийн тусгай коэффициент)-ийг судалгааны өмнөх нэг жилийн хугацаанд 15-19 насны эмэгтэйчүүдийн төрүүлсэн хүүхдийн тоог тухайн хугацаан дахь 15-19 насны эмэгтэйчүүдийн дундаж тоонд харьцуулан, 1000 эмэгтэйд ногдох дүнгээр тодорхойлно. Төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК)-ийг 15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд таван насны бүлгээр тооцсон төрөлтийн тусгай коэффициентүүдийн нийлбэрээр тооцно. Хэрвээ одоогийн төрөлтийн түвшин хэвээр хадгалагдана гэж төсөөлбөл ТНК нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн насыг дуусах хугацаа хүртэл төрүүлэх нийт хүүхдийн дундаж тоог илэрхийлдэг.

2010 оны ХХС-гаар өсвөр насны охидын төрөлтийн түвшин (15-19 насны 1000 эмэгтэйд ногдох) 38, төрөлтийн нийлбэр коэффициент 3.1 байгаа бөгөөд хүн ам, өрхийн шинж байдлын хувьд төрөлтийн түвшин нэлээд ялгаатай байна. Бүс нутгаар харьцуулж үзэхэд Төвийн бүсэд өсвөр насны охидын төрөлтийн түвшин (15-19 насны 1000 эмэгтэйд ногдох) 85 байгаа нь хамгийн өндөр, харин Баруун бүсэд 18 байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт юм. Гэхдээ Баруун болон Төвийн бүсэд ТНК нь 3.8 байгаа нь бусад бүстэй харьцуулахад өндөр байгаа бөгөөд Улаанбаатараас (ТНК=2.7) бусад бүх бүсэд төрөлтийн түвшин улсын дунджаас (ТНК=3.1) өндөр байна.

Хөдөөд төрөлтийн түвшин тэр дундаа өсвөр насны охидын төрөлт өндөр хэвээр байна. Тухайлбал, хөдөөд өсвөр насны охидын төрөлт 15-19 насны 1000 эмэгтэйд 59 ногдож байхад хотод 30 байна. ТНК буюу нэг эмэгтэй төрүүлсэн хүүхдийн дундаж тоо хөдөөд 3.6, хотод 2.9 байна.

Боловсролгүй болон бага боловсролтой өсвөр насны охидын (төрөлтийн тусгай коэффициент харгалзан 73 ба 90) болон доогуур түвшний аж байдалтай өрхийн өсвөр насны охидын төрөлтийн түвшин (төрөлтийн тусгай коэффициент 79) бусад бүлгийнхэнтэй нь харьцуулахад нэлээд өндөр байна.

Эрт бэлгийн харьцаанд орох, хүүхэд төрүүлэх явдал дэлхийн аль ч бүс нутагт залуу хүн амыг өндөр эрсдэлд хүргэж байна. Хүснэгт RH.2-д 15-19 болон 20-24 насны эмэгтэйчүүдийн эрт төрөлтийн зарим үзүүлэлтүүдийг, Хүснэгт RH.3-д эрт төрөлтийн хандлагыг харуулав.

Хүснэгт RH.2-оос харахад 15-19 насны охидын 5 хувь нь хүүхэд төрүүлсэн, 1 хувь нь анхны хүүхдээ тээж байгаа жирэмсэн, нийт 6 хувь нь хүүхэд төрүүлсэн эсвэл жирэмсэн гэж хариулжээ.



Төв болон Хангайн бүсийн, хөдөөгийн, доогуур түвшний аж байдалтай өрхийн өсвөр насны охидын дунд жирэмслэлт болон эрт төрөлтийн түвшин өндөр байна. Жишээ нь, 15-19 насны хөдөөгийн охидын 7 хувь нь хүүхэд төрүүлсэн, 2 хувь нь анхны хүүхдээ тээж байгаа бол доогуур түвшний аж байдалтай өрхийн өсвөр насны охидын 10 хувь нь хүүхэдтэй, 2 хувь нь анхны хүүхдээ төрүүлэхээр жирэмсэлсэн, нийт 12 хувь нь хүүхэд төрүүлсэн эсвэл жирэмсэн байгаа ажээ.

ХХС 2010-аар хэт залуу насандаа буюу 18 наснаас өмнө эмэгтэйчүүдийн 4 хувь нь хүүхэд төрүүлсэн үр дүн гарчээ. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн 7 хувь нь 18 наснаас өмнө хүүхэд төрүүлсэн байхад хотын эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 2 дахин доогуур буюу 3 хувийг эзэлж байна. Өсвөр насны охидын эрт төрөлтийн түвшинг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн өмнөх үеийн түүхтэй харьцуулахад буурах хандлагатай байна (Хүснэгт RH.3).

### Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл

Гэр бүл төлөвлөлтийн зохистой аргыг сонгон хэрэглэх нь нэгдүгээрт, хэт залуудаа болон хэт орой хүүхэд төрүүлэхээс урьдчилан сэргийлэх, хоёрдугаарт, төрөлт хоорондын зайг уртасгах, гуравдугаарт, хүссэн тоогоор хүүхэдтэй болох боломж олгодог тул эх, хүүхдийн аль алины эрүүл мэндэд тустай. Хосуудыг хэт эрт, хэт орой, хэт ойрхон болон олон жирэмслэхээс хамгаалах талаар мэдээлэл, үйлчилгээгээр хангах явдал чухал юм.

Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 97 хувь (Хүснэгт RH.4A), эрэгтэйчүүдийн 89 хувь (Хүснэгт RH.4AM) нь жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл (ЖСАХ)-ийн талаар мэддэг гэжээ. Эмэгтэйчүүдийн ихэнх нь эм (77 хувь), ерөндөг (76 хувь), тариа (63 хувь), болон эрэгтэй бэлгэвч (60 хувь)-ийг мэддэг байна. Харин эрэгтэйчүүдийн хувьд дийлэнх буюу 84 хувь нь эрэгтэй бэлгэвчийг мэддэг байна.

ЖСАХ-ийн талаарх эмэгтэйчүүдийн мэдлэг боловсролын түвшнээс бусад шинж байдлаар төдийлөн ялгаагүй байгааг Хүснэгт RH.4A-аас харж болно. Боловсролгүй эмэгтэйчүүдийн дунд ЖСАХ-ийн талаарх мэдлэг хамгийн бага (83 хувь) байхад дээд боловсролтой бүх эмэгтэй ЖСАХ-ийн талаар мэддэг байна.

Судалгаагаар гэр бүлтэй болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 55 хувь нь одоогийн байдлаар жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байна (Хүснэгт RH.4). Монголд хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга нь ерөндөг бөгөөд гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 23 хувь нь хэрэглэдэг. Эмэгтэйчүүдийн 3-7 хувь нь умайн 2 талын гуурсан хоолойг боох, тариа, хуанлийн дагуу түр тэвчих, эрэгтэй бэлгэвч хэрэглэдгээ мэдээлжээ. Ердөө 1 хувь нь үрийн суваг боох, эмэгтэй бэлгэвч, суулгац, диафрагм, лаа, царцмаг, хүүхдээ хөхүүлэх болон гадуур тавих аргыг хэрэглэдэг байна.

Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийн хэрэглээ Зүүн бүсэд хамгийн өндөр (64 хувь) байна. Улаанбаатарт ЖСАХ-ийн хэрэглээ бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур байгаа бөгөөд гэрлэсэн болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 52 хувь нь жирэмслэхээс хамгаалах ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байна. Өсвөр насны охидын 52 хувь, 20-24 насны эмэгтэйчүүдийн 47 хувь, 25-39 насны эмэгтэйчүүдийн 58-64 хувь, 40-44 насны эмэгтэйчүүдийн 58 хувь, 45-49 насны эмэгтэйчүүдийн 35 хувь нь ЖСАХ хэрэглэж байна.

ЖСАХ-ийн хэрэглээ эмэгтэйчүүдийн боловсролын түвшнээр харилцан адилгүй байна. Боловсролгүй эмэгтэйчүүдийн 47 хувь, бага болон суурь боловсролтой эмэгтэйчүүдийн 58 хувь ЖСАХ хэрэглэдэг байхад энэ үзүүлэлт дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд 54 хувь байна.

Эмэгтэйчүүдийн хэрэглэж буй жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн төрөл боловсролын түвшнээр бага зэрэг ялгаатай байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшлэх тусам бэлгэвч болон уламжлалт аргын хэрэглээ нэмэгдэж байна (Хүснэгт RH.4).

Судалгаагаар доогуур аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн хэрэглээний түвшин 58 хувь байгаа нь чинээлэг (52 хувь) өрхийн эмэгтэйчүүдийнхээс бага зэрэг өндөр байна.

### Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн дутагдаж буй хэрэгцээ

ЖСАХ-ийн дутагдаж буй хэрэгцээ нь жирэмслэх чадавхитай боловч жирэмслэхээс сэргийлэх ямар нэгэн арга хэрэглэдэггүй, гэхдээ дараагийн төрөлтөө (төрөлт хоорондын зай) хойшлуулахыг хүсч байгаа эсвэл цаашид дахин төрөх огт хүсэлгүй (төрөлтөө зогсоож, хязгаарлах хүсэлтэй) байгаа тохиолдлоор илэрхийлэгдэнэ. ХХС-нд ЖСАХ-ийн дутагдаж буй хэрэгцээг ЖСАХ-ийн одоогийн хэрэглээ, жирэмслэх чадавхи, төрөлтийн сонголтын талаарх багц асуултын тусламжтайгаар тодорхойлсон.

ЖСАХ-ийн хэрэглээ, ЖСАХ-ийн дутагдаж буй болон хангагдсан хэрэгцээний талаарх судалгааны үр дүнг Хүснэгт RH.5-д харуулав.

Жирэмслэхээ хойшлуулах (тодорхой хугацаагаар жирэмслэхгүй байх)-ыг хүсч байгаа ЖСАХ огт хэрэглэдэггүй эмэгтэйчүүдийн хувийг тодорхойлохдоо:

- Жирэмсэн бус, түр үргүйдэлтэй биш<sup>15</sup>, жирэмслэх чадавхитай<sup>16</sup> эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх хүсэлтэй ч 2 ба түүнээс дээш жил хүлээх бодолтой байгаа,
- Жирэмсэн бус, түр үргүйдэлтэй биш, жирэмслэх чадавхитай эмэгтэйчүүд дараагийн хүүхдээ хэзээ төрүүлэх талаар тодорхой бодолгүй байгаа,
- Жирэмсэн, одоогийн жирэмслэлт нь төлөвлөсөн хугацааны жирэмслэлт мөн эсэх нь эргэлзээтэй, жирэмслэлтээ хэсэг хугацаанд хүлээхийг хүсч байсан,
- Түр үргүйдэлтэй, сүүлийн төрөлт нь төлөвлөсөн хугацааны төрөлт мөн эсэх нь эргэлзээтэй, төрөлтөө хэсэг хугацаанд хүлээхийг хүсч байсан.

Жирэмслэхээ зогсоохыг хүсч байгаа (цаашид жирэмслэхийг хүсэхгүй байгаа), ЖСАХ огт хэрэглэдэггүй эмэгтэйчүүдийн хувийг тодорхойлохдоо:

- Жирэмсэн бус, түр үргүйдэлтэй бус, жирэмслэх чадавхитай, цаашид дахин хүүхэдтэй болохыг хүсэхгүй байгаа,
- Жирэмсэн, хүүхэдтэй болохыг хүсэхгүй байгаа,
- Түр үргүйдэлтэй, төрөх хүсэлгүй байгаа.

<sup>15</sup> Түр үргүйдэл гэдэг нь тухайн эмэгтэй сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн, одоогоор жирэмсэн биш, сарын тэмдэг нь сүүлчийн хүүхдээ төрүүлснээс хойш ирээгүй эмэгтэйг хэлнэ.

<sup>16</sup> Жирэмслэх чадавхгүй гэдэг нь огт жирэмсэлж байгаагүй, түр үргүйдэлтэй биш, (1а) сарын тэмдэг нь сүүлийн 6 сард ирээгүй эсвэл (1б) сарын тэмдэг нь огт ирээгүй эсвэл (1в) сүүлийн төрөлтийн өмнө л сарын тэмдэг нь ирсэн эсвэл (1д) цэвэршсэн эмэгтэйг хэлнэ.

(2) Судалгаа явуулах үед судалгааны асуултаар дамжуулан сарын тэмдэг нь огт ирээгүй эсвэл цэвэршсэн, жирэмслэх оролдлогыг 2 ба түүнээс жил хийсэн боловч үр дүнд хүрээгүй физиологийн хувьд жирэмслэх чадавхигүй болох нь тогтоогдсон.

(3) Хүлээгдэж буй дараагийн төрөлтийг асуухад жирэмсэлж чадахгүй нь тогтоогдсон гэж хариулсан.

(4) Судалгааны өмнөх 5 жилийн хугацаанд гэрлэсэн, гэр бүлтэй боловч одоогоор ЖСАХ огт хэрэглээгүй, судалгааны өмнөх 5 жилийн хугацаанд хүүхэд төрүүлээгүй.

ЖСАХ-ийн нийт дутагдаж байгаа хэрэгцээ гэдгийг жирэмслэхээ хойшлуулахыг хүсч байгаа болон төрөлтөө зогсоох, хязгаарлах хүсэлтэй эмэгтэйчүүдийн хэрэгцээний нийлбэр гэж ойлгож болно.

Судалгааны дүнгээс харахад гэр бүлтэй, хамтран амьдрагчтай нийт эмэгтэйчүүдийн 22 хувийнх нь ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдаагүй байгаа бөгөөд тэдний дийлэнх нь дахин төрөх хүсэлгүй (нийт эмэгтэйчүүдийн 17 хувь) байна. ЖСАХ-ийн дутагдаж байгаа хэрэгцээг бүсээр авч үзэхэд Зүүн бүсэд хэрэгцээ хамгийн бага (16 хувь) байна. ЖСАХ-ийн дутагдаж байгаа хэрэгцээ хөдөөгийн эмэгтэйчүүдтэй (20 хувь) харьцуулахад хотын эмэгтэйчүүдийн дунд (24 хувь) өндөр байна. Насны бүлгээр авч үзвэл ЖСАХ дутагдаж байгаа хэрэгцээ ахимаг буюу 40-өөс дээш насны эмэгтэйчүүдийн хувьд өндөр байна. Тухайлбал, ЖСАХ-ийн дутагдаж байгаа хэрэгцээтэй эмэгтэйчүүд 20-39 насны бүлэгт 20 хүрэхгүй хувийг эзэлж байхад 40-44 насны эмэгтэйчүүдийн 29 хувь, 45-49 насны эмэгтэйчүүдийн 38 хувьд ЖСАХ-ийн хэрэгцээ дутагдалтай байна.

Төрөлтөө зогсоох, хязгаарлах хүсэлтэй эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн хангагдсан хэрэгцээнд ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүд, цаашид дахин хүүхэд төрүүлэх хүсэлгүй байгаа эмэгтэйчүүд, нөхөр/ хамтран амьдрагч нь эрэгтэй үрийн суваг боолгох, өөрөө умайн 2 талын гуурсан хоолойг боолгох мэс засал хийлгэсэн, жирэмслэх чадавхгүй нь тогтоогдсон эмэгтэйчүүдийг хамруулна. Жирэмслэлтээ хойшлуулах хүсэлтэй байгаа эмэгтэйчүүдийн хангагдсан хэрэгцээнд ЖСАХ хэрэглэж байгаа, дахин хүүхэд хүсч байгаа, дараагийн хүүхдээ хэзээ төрүүлэх нь шийдэгдээгүй байгаа эмэгтэйчүүд хамрагдана. ЖСАХ-ийн хангагдсан хэрэгцээтэй төрөлтөө зогсоох, хязгаарлах хүсэлтэй эмэгтэйчүүд болон жирэмслэлтээ хойшлуулах хүсэлтэй байгаа эмэгтэйчүүдийн нийлбэрээр нийт ЖСАХ-ийн хангагдсан хэрэглээний түвшинг тодорхойлно.

Судалгаагаар нийт эмэгтэйчүүдийн 55 хувь нь ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдсан гэж хариулсан байна. Төрөлтөө зогсоох, хязгаарлах хүсэлтэй эмэгтэйчүүдийн 36 хувь, жирэмслэлтээ хойшлуулах хүсэлтэй байгаа эмэгтэйчүүдийн 19 хувь нь ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдсан гэжээ.

ХХС-гаар ЖСАХ-ийн хэрэглээ, ЖСАХ-ийн дутагдаж буй хэрэгцээний талаарх мэдээллийг ашиглан ЖСАХ-ийн эрэлтийн ханамжийн хувийг тооцсон. ЖСАХ-ийн эрэлтийн ханамжийн хувь нь одоогоор ЖСАХ хэрэглэж буй нийт гэр бүлтэй болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн хувийн жин, ЖСАХ-ийн нийт эрэлтээр тодорхойлогдоно. ЖСАХ-ийн нийт эрэлтийг ЖСАХ-ийн дутагдаж буй хэрэгцээтэй байгаа (жирэмслэлтээ хойшлуулах, төрөлтөө хязгаарлах) эмэгтэйчүүд, ЖСАХ одоо хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн хувийн жингийн нийлбэрээр тодорхойлно. ХХС 2010-ын дүнгээр ЖСАХ-ийн эрэлтийн ханамж 71 хувь байна.

### **Жирэмсэн үеийн хяналт**

Төрөхийн өмнөх үед жирэмсэн эхчүүдэд үзүүлж буй олон арга хэмжээ нь тэдний эрүүл мэнд төдийгүй нялхсын эрүүл мэндэд маш чухал нөлөө үзүүлдэг. Үр хөврөлийн өсөлт, хөгжил эхийн эрүүл мэндийн хоорондын харилцан хамаарлыг ойлгодог болсны үр дүнд эхийн болон шинээр төрж буй хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээгээр дамжуулан жирэмсэн үед тавигдах бодит хяналт, халамж анхаарал дээшилдэг. Тухайлбал, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлд жирэмсэн болон төрөх үеийн хүндрэлийн талаар ойлголт, мэдлэг өгч, жирэмсэн үедээ мэргэжлийн эмчийн хяналтад хамрагдах, эмчийн хяналтад төрөхийн ач холбогдлыг ойлгуулснаар жирэмсний хяналтад хамрагдалт нэмэгдэж байна.

Түүнчлэн, жирэмсний хяналтын үеэр нялхас эсэн мэнд төрж, өсөхөд нөлөө үзүүлдэг хүчин зүйл болох төрөлт хоорондын зайн талаар мэдлэг мэдээллийг олгодог. Дархлаажуулалт нь эх хүүхэд эсэн мэнд амаржихад чухал ач холбогдолтой. Жирэмсэн эмэгтэйчүүдийг хумхай өвчнөөс сэргийлэх, эмчлэх, жирэмсэн үеийн цус багадалтыг эрт илрүүлж эмчилснээр эхийн эрүүл мэнд сайжирч, нялхас эсэн мэнд мэндэлнэ. Цаашлаад эхийн хоол тэжээлийн байдлыг дээшлүүлэх, БЗДХ болон бусад халдвараар өвчлөхөөс зайлсхийх зэргээр бага жинтэй хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх хосолсон арга хэмжээ авах нөхцөл бүрддэг. Мөн сүүлийн үед ХДХВ эхээс хүүхдэд дамжин халдварлахаас сэргийлэхийн тулд жирэмсний хяналтын үеийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарах боллоо.

ДЭМБ-аас жирэмсэн үеийн хяналтын хэд хэдэн загварыг харьцуулан судалсны үндсэн дээр жирэмсний хяналтад наад зах нь дөрвөн удаа хамрагдсан байхыг зөвлөмж болгосон. Түүнчлэн, ДЭМБ жирэмсний хяналтын үед дараах тусгайлсан үйлчилгээ үзүүлэхийг удирдамж болгодог. Эдгээр нь:

- Цусны даралт хэмжих
- Шээсний шинжилгээ хийх
- Цусны шинжилгээ хийх
- Биеийн жин/биеийн өндрийг хэмжих зэрэг болно.

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн жирэмсэн үеийн хяналтын үйлчилгээг хэнд үзүүлсэн болохыг Хүснэгт RH.6-д харуулав. Жирэмсэн үеийн хяналтад хамрагдалт Монгол Улсад харьцангуй өндөр түвшинд буюу хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 99 хувь нь наад зах нь нэг удаа мэргэжлийн эмчид үзүүлж жирэмсний хяналтад хамрагджээ. Жирэмсэн үеийн хяналтад хамрагдалтын түвшинг хүн ам, өрхийн шинж байдлаар нарийвчлан авч үзэхэд ялгаагүй байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 61 хувь нь өрх/ сумын эмчийн, 32 хувь нь эх баригч эмэгтэйчүүдийн эмчийн, 5 хувь нь эх баригчийн, 1 хувь нь сувилагчийн хяналтад хамрагдсан байна. Эх баригчийн хяналтад үзүүлсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь сумын төв (12 хувь) болон хөдөөгийн (10 хувь), бага боловсролтой (10 хувь) эмэгтэйчүүдийн дунд бусад эмэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

ДЭМБ/ НҮБХС-гаас жирэмсэн эхийг жирэмсний хяналтад наад зах нь дөрвөн удаа хамруулж байхыг зөвлөмж болгосон. Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд хамгийн сүүлд жирэмсэн байх үедээ жирэмсний хяналтад хэдэн удаа орж байсан талаарх мэдээллийг тэдгээрийн шинж байдлаар Хүснэгт RH.7-д харуулав. Жирэмсэн арван эмэгтэй тутмын найм (81 хувь) нь дөрөв ба түүнээс олон удаа жирэмсний хяналтад хамрагдсан байна. Боловсролгүй болон бага боловсролтой (73-76 хувь), мөн казак өрхийн тэргүүлэгчтэй өрхийн (65 хувь) эмэгтэйчүүдийн жирэмсний хяналтад дөрөв ба түүнээс дээш удаа хамрагдах нь бусад бүлгийнхээс хамгийн доогуур үзүүлэлттэй байна.

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн нийт эмэгтэйн 77 хувь нь жирэмсний эрт хяналтад (жирэмсний эхний гурван сарын дотор), 21 хувь нь жирэмсний 3-6 сарын дотор, үлдсэн 2 хувь нь жирэмсний хожуу хяналтад (жирэмсний 6 сараас хойш) оржээ (Хүснэгт RH.7A). Өсвөр насны (55 хувь), боловсролгүй болон бага боловсролтой (69-70 хувь), өрхийн аж байдал нь доогуур (70 хувь), казак өрхийн тэргүүлэгчтэй өрхийн (62 хувь) эмэгтэйчүүдийн жирэмсний эрт хяналтад хамрагдсан түвшин хамгийн доогуур байна.

Жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлсэн үйлчилгээний төрлийг Хүснэгт RH.8-д харуулав. Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 97 хувь нь

жирэмсний хяналтад байхдаа цусны даралтаа хэмжүүлж байсан, 97 хувь нь шээсний, 97 хувь нь цусны, 94 хувь нь БЗДХ-ын шинжилгээ өгсөн, 97 хувь нь жингээ хэмжүүлсэн байна. Эмэгтэйчүүдийн шинж байдлын үзүүлэлтээр нарийвчлан авч үзвэл шээсний болон БЗДХ-ын шинжилгээ хийлгэсэн эмэгтэйчүүдийн хувь Баруун бүсийн (харгалзан 89 хувь ба 79 хувь) болон огт боловсролгүй (харгалзан 85 хувь ба 77 хувь) эмэгтэйчүүдийн дунд харьцангуй доогуур байна. Түүнчлэн, казак өрхийн тэргүүлэгчтэй өрхийн эмэгтэйчүүдийн жирэмсний хяналтад байхдаа авсан үйлчилгээний төрөл хамгийн доогуур байгаа нь анхаарал татаж байна. Тодруулбал, казак өрхийн тэргүүлэгчтэй өрхийн эмэгтэйчүүдийн 97 хувь нь жирэмсний хяналтад байхдаа цусны даралтаа хэмжүүлж, 79 хувь нь шээсний, 83 хувь нь цусны, 59 хувь нь БЗДХ-ын шинжилгээ өгч, 77 хувь нь жингээ хэмжүүлсэн байлаа.

### Төрөх үеийн тусламж

Эхийн эндэгдлийн дөрөвний гурав нь жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалж байна. Төрөлтийг эх барих чадвартай эмнэлгийн ажилтан удирдах, шаардлага гарсан үед эх барихын яаралтай тусламж үзүүлэх унааны боломжтой байдал зэрэг нь эсэн мэнд амаржихуйн үндсэн хүчин зүйл болдог. "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалын нэг зорилго нь эхчүүдийг төрөх үедээ эмнэлгийн мэргэжлийн ажилтны хяналтад байх боломжоор хангахыг баталгаажуулах явдал юм. Энэхүү зорилгын биелэлтийг эмнэлгийн мэргэшсэн ажилтны тусламжтай төрсөн эхчүүдийн хувь, эмнэлэг дэх төрөлтийн хувь гэсэн үзүүлэлтүүдээр хэмжиж байна. 1990-2015 оны хооронд эхийн эндэгдлийг 1990 оны түвшнээс дөрөвний гурваар бууруулах Мянганы хөгжлийн зорилтын биелэлтийг хянахад эмнэлгийн мэргэшсэн ажилтны тусламжтай төрсөн эхчүүдийн хувь гэсэн үзүүлэлтийг ашигладаг.

Мэргэжлийн ажилтны тусламжтай төрсөн төрөлтийн талаарх мэдээллийг гаргахын тулд ХХС-нд хэд хэдэн төрлийн асуултуудыг оруулсан. Эмнэлгийн мэргэжлийн ажилтнуудад их эмч, эх баригч/ бага эмч, сувилагч нарыг багтаан үзсэн болно.

ХХС явуулахаас өмнөх 2 жилийн хугацаанд нийт төрөлтийн 99 хувь нь эмнэлгийн мэргэжлийн ажилтны хяналтад явагджээ (Хүснэгт RH.9). Энэхүү үзүүлэлт хот, хөдөө, бүс болон эмэгтэйн насны хувьд ялгаагүй буюу нэгэн жигд байна. Доогуур түвшний аж байдалтай өрхийн болон боловсролгүй эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмчийн хяналтад хүүхдээ төрүүлсэн хувь нь бусдынхаасаа 2 хүртэлх пунктээр тус бүр бага байв. Энэ нь хэдийгээр анхаарал татахуйц ялгаа биш боловч доогуур түвшний аж байдалтай өрхөд амьдарч байгаа болон боловсролгүй байгаа гэдэг нь тухайн үйлчилгээний хүртээмжид тодорхой хэмжээний ялгаа үүсгэж байгааг анхаарахад илүүдэхгүй.

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд нийт төрөлтийн 69 хувь нь эх баригч эмэгтэйчүүдийн эмчийн, 26 хувь нь эх баригчийн, 3 хувь нь өрхийн/ сумын эмчийн хяналтад төрсөн байна. Бүс нутаг болон хот, хөдөөгөөр зарим ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, эх баригч эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад хүүхдээ төрүүлсэн эхчүүдийн хувь Улаанбаатарт хамгийн өндөр (75 хувь) байхад Төвийн бүсэд хамгийн бага (60 хувь) байна. Мөн хотын эмэгтэйчүүдийн 73 хувь нь эх баригч эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад төрсөн байхад хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 64 хувь байгаа юм.

ДЭМБ-аас мэс заслын аргаар төрсөн хүүхдийн хувийг нийт төрөлтийн 5-15 хувиас хэтрүүлэхгүй байхыг зөвлөдөг боловч энэ үзүүлэлт манай орны хувьд харьцангуй өндөр буюу судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн 21 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна. Мэс заслын аргаар хүүхдээ төрүүлэх

нь хотын эмэгтэйчүүдийн дунд хөдөөгийн эмэгтэйчүүдийнхээс илүү түгээмэл (23 ба 17 хувь) байна. Мөн Улаанбаатар хотын эмэгтэйчүүд хүүхдээ мэс заслын аргаар төрүүлэх явдал бусад бүсийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр, тэр дундаа Баруун болон Хангайн бүсийн эмэгтэйчүүдийнхээс мэдэгдэхүйц өндөр байгааг хүснэгт RH.9-өөс харж болно.

Мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн эхчүүдийн амьдарч буй өрхийн аж байдлаар нь авч үзэхэд дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүд хүүхдээ мэс заслын аргаар төрүүлэх нь доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийнхээс даруй 2 дахин их (31 ба 16 хувь) байна.

Уг үзүүлэлтийг эмэгтэйчүүдийн насны бүлгээр авч үзэхэд нас ахих тусам нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэ нь эмэгтэйн нас ахих тусам төрөх үеийн хүндрэл үүсэх магадлал өндөр байдагтай холбоотой байж болох юм. Тухайлбал, 20 хүртэлх насандаа хүүхдээ төрүүлсэн 10 эмэгтэй тутмын 1 нь, 20-34 насандаа хүүхдээ төрүүлсэн 5 эмэгтэй тутмын 1 нь, 35-49 насандаа хүүхдээ төрүүлсэн 3 эмэгтэй тутмын 1 нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлж байна.

### Төрөх үеийн газар

Эмнэлгийн төрөлтийн хувийн жинг нэмэгдүүлэх нь эх, нярайн эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах нэг гол хүчин зүйл болдог. Төрөх үеийн эмнэлгийн тусламж, тоног төхөөрөмж, эрүүл ахуйн орчин нь эх болон нярайн өвчлөлт, нас баралтын шалтгаан болох аливаа асуудал, халдварын эрсдэлийг бууруулдаг.

Хүснэгт RH.10-д судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлсэн газар болон хүн ам, өрхийн шинж байдлын сонгосон үзүүлэлтээр харуулав.

Монгол Улсын нийт төрөлтийн 99 хувь нь эмнэлгийн байгууллагад төрж байгаа бөгөөд улсын эмнэлэгт 98 хувь, хувийн эмнэлэгт 1 хувь нь бүртгэгдсэн байна. Нийт төрөлтийн нэг хувь нь гэрийн төрөлт байв.

Бүс нутаг, хот, хөдөөгийн хувьд эмэгтэйчүүдийн хүүхдээ төрүүлсэн эмнэлгийн байгууллагуудын ялгаа бага байна. Харин насны бүлгээр авч үзвэл эмэгтэйчүүдийн нас ахих тусам хувийн эмнэлэгт төрсөн эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэж байна. Түүнчлэн, чинээлэг өрхийн эмэгтэйчүүдийн 2 хувь нь хувийн эмнэлэгт төржээ. Гэрийн төрөлт хөдөөд өндөр (2 хувь) хэвээр байна. Мөн Баруун (2 хувь), Хангай (2 хувь), Зүүн (1 хувь) бүсэд гэрийн төрөлт улсын дунджаас өндөр байна. Огт боловсролгүй (4 хувь) болон бага боловсролтой (3 хувь), доогуур аж байдалтай өрхийн (2 хувь) эмэгтэйчүүдийн дунд гэрийн төрөлт өндөр байна.

**Хүснэгт RH.1: Өсвөр насны охидын төрөлтийн түвшин болон төрөлтийн нийлбэр коэффициент**

Өсвөр насны охидын төрөлтийн түвшин болон төрөлтийн нийлбэр коэффициент, Монгол Улс, 2010 он

|  | Өсвөр насны охидын төрөлтийн түвшин <sup>1</sup> (15-19 насны эмэгтэйчүүдийн НБТК) | Төрөлтийн нийлбэр коэффициент |
|--|--|-------------------------------|
| <b>Бүс</b>                               |  |                               |
| Баруун                                   | 18   | 3.8                           |
| Хангай                                   | 46   | 3.3                           |
| Төв                                      | 85   | 3.8                           |
| Зүүн                                     | 31   | 3.4                           |
| Улаанбаатар                              | 30   | 2.7                           |
| <b>Хот, хөдөө</b>                        |  |                               |
| Хот                                      | 30   | 2.9                           |
| Хөдөө                                    | 59   | 3.6                           |
| <b>Байршил</b>                           |  |                               |
| Нийслэл                                  | 30   | 2.7                           |
| Аймгийн төв                              | 30   | 3.5                           |
| Сумын төв                                | 41   | 3.3                           |
| Хөдөө                                    | 76   | 3.8                           |
| <b>Боловсрол</b>                         |  |                               |
| Боловсролгүй                             | 73   | 2.7                           |
| Бага                                     | 90   | 3.9                           |
| Суурь                                    | 12   | 3.1                           |
| Бүрэн дунд                               | 43   | 3.7                           |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд   | 38   | 2.7                           |
| Дээд                                     | 59   | 3.0                           |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>          |  |                               |
| Доогуур                                  | 79   | 3.9                           |
| Дунджаас доогуур                         | 45   | 3.4                           |
| Дундаж                                   | 49   | 3.2                           |
| Дунджаас дээгүүр                         | 11   | 2.3                           |
| Дээгүүр                                  | 26   | 3.0                           |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа</b>  |  |                               |
| Халх                                     | 42   | 3.0                           |
| Казак                                    | 0  | 3.4                           |
| Бусад                                    | 31   | 3.7                           |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг</b> |  |                               |
| Шүтдэггүй                                | 41   | 3.1                           |
| Будда                                    | 37   | 3.2                           |
| Ислам                                    | 0  | 3.4                           |
| Бусад                                    | 63   | 3.3                           |
| <b>Бүгд</b>                              | <b>38</b>  | <b>3.1</b>                    |

<sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 5.1; МХЗ-ын үзүүлэлт 5.4

**Хүснэгт RH.2: Эрт жирэмслэлт**

Хүүхэд төрүүлсэн, анхны хүүхдээ төрүүлэхээр жирэмсэн байгаа, хүүхэд тээж байсан 15-19 насны эмэгтэйчүүд, 15 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн 15-19 насны эмэгтэйчүүд, 18 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн 20-24 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улс, 2010 он

|  | 15-19 насны эмэгтэйчүүдийн хувь: |                                    |  |   | 15-19 насны эмэгтэйчүүдийн тоо | 18 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлж байсан 20-24 насны эмэгтэйчүүдийн хувь <sup>1</sup> | 20-24 насны эмэгтэйчүүдийн тоо |
|--|----------------------------------|------------------------------------|--|---|--------------------------------|---|--------------------------------|
|  | Хүүхэд төрүүлж байсан            | Анхны хүүхдээ тээж байгаа жирэмсэн | Хүүхэд төрүүлсэн эсвэл жирэмсэн байгаа | 15 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн |                                |   |                                |
| <b>Бүс</b>                                 |                                  |                                    |  |   |                                |   |                                |
| Баруун                                     | 1.6                              | 0.4                                | 2.0                                    | 0.0                                     | 180                            | 2.6   | 129                            |
| Хангай                                     | 6.5                              | 2.0                                | 8.5                                    | 0.0                                     | 208                            | 4.0   | 234                            |
| Төв  | 7.7                              | 2.9                                | 10.6                                   | 0.0                                     | 183                            | 5.1   | 194                            |
| Зүүн                                       | 4.0                              | 1.7                                | 5.6                                    | 0.0                                     | 71                             | 4.7   | 74                             |
| Улаанбаатар                                | 4.5                              | 0.8                                | 5.3                                    | 0.0                                     | 544                            | 0.9   | 753                            |
| <b>Хот, хөдөө</b>                          |                                  |                                    |  |   |                                |   |                                |
| Хот  | 3.8                              | 1.1                                | 4.9                                    | 0.0                                     | 804                            | 1.4   | 992                            |
| Хөдөө                                      | 7.2                              | 1.8                                | 8.9                                    | 0.0                                     | 382                            | 4.8   | 393                            |
| <b>Байршил</b>                             |                                  |                                    |  |   |                                |   |                                |
| Нийслэл                                    | 4.5                              | 0.8                                | 5.3                                    | 0.0                                     | 544                            | 0.9   | 753                            |
| Аймгийн төв                                | 2.3                              | 1.7                                | 4.0                                    | 0.0                                     | 260                            | 3.1   | 239                            |
| Сумын төв                                  | 3.5                              | 1.7                                | 5.2                                    | 0.0                                     | 199                            | 3.6   | 179                            |
| Хөдөө                                      | 11.2                             | 1.8                                | 13.0                                   | 0.0                                     | 183                            | 5.7   | 214                            |
| <b>Боловсрол</b>                           |                                  |                                    |  |   |                                |   |                                |
| Боловсролгүй                               | (17.4)                           | (0.0)                              | (17.4)                                 | (0.0)                                   | 24                             | 15.2  | 48                             |
| Бага                                       | 9.1                              | 0.0                                | 9.1                                    | 0.0                                     | 62                             | 10.7  | 43                             |
| Суурь                                      | 2.1                              | 0.3                                | 2.4                                    | 0.0                                     | 417                            | 6.1   | 112                            |
| Бүрэн дунд                                 | 5.4                              | 2.3                                | 7.8                                    | 0.0                                     | 550                            | 2.6   | 365                            |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд     | 3.6                              | 0.9                                | 4.5                                    | 0.0                                     | 79                             | 1.2   | 81                             |
| Дээд                                       | (11.9)                           | (1.8)                              | (13.7)                                 | (0.0)                                   | 54                             | 0.5   | 736                            |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>            |                                  |                                    |  |   |                                |   |                                |
| Доогуур                                    | 10.1                             | 2.0                                | 12.1                                   | 0.0                                     | 162                            | 6.5   | 201                            |
| Дунджаас доогуур                           | 4.5                              | 1.2                                | 5.8                                    | 0.0                                     | 236                            | 5.9   | 269                            |
| Дундаж                                     | 5.7                              | 0.9                                | 6.6                                    | 0.0                                     | 257                            | 0.6   | 323                            |
| Дунджаас дээгүүр                           | 1.4                              | 1.2                                | 2.6                                    | 0.0                                     | 270                            | 0.7   | 279                            |
| Дээгүүр                                    | 4.7                              | 1.5                                | 6.2                                    | 0.0                                     | 261                            | 0.0   | 313                            |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*</b>   |                                  |                                    |  |   |                                |   |                                |
| Халх                                       | 5.3                              | 1.3                                | 6.7                                    | 0.0                                     | 926                            | 2.7   | 1 153                          |
| Бусад                                      | 3.2                              | 1.3                                | 4.5                                    | 0.0                                     | 260                            | 1.0   | 229                            |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг**</b> |                                  |                                    |  |   |                                |   |                                |
| Шүтдэггүй                                  | 6.8                              | 1.7                                | 8.5                                    | 0.0                                     | 461                            | 3.5   | 605                            |
| Будда                                      | 3.4                              | 0.7                                | 4.2                                    | 0.0                                     | 627                            | 1.5   | 668                            |
| Бусад                                      | 5.0                              | 3.3                                | 8.3                                    | 0.0                                     | 95                             | 0.0   | 101                            |
| <b>Бүгд</b>                                | <b>4.9</b>                       | <b>1.3</b>                         | <b>6.2</b>                             | <b>0.0</b>                              | <b>1 186</b>                   | <b>2.4</b>  | <b>1 385</b>                   |

\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 1, 4 ажиглалт (жигнээгүй)-ыг харгалзан харуулаагүй болно.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь хариулагдаагүй 4, 11 ажиглалт (жигнээгүй)-ыг харгалзан харуулаагүй болно.

( ) 25-49 ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

<sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 5.2



**Хүснэгт РН.3: Эрт хүүхэд төрүүлэх хандлага**

15 болон 18 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлж байсан эмэгтгэичүүдийн хувь, хот, хөдөө болон насны бүлгээр, Монгол Улс, 2010 он

| Насны бүлэг | Хот   |                                 |  |                                 | Хөдөө  |                                 |  |                                 | Бүгд   |                                 |  |                                 |                                 |
|-------------|---|---------------------------------|--|---------------------------------|--|---------------------------------|--|---------------------------------|--|---------------------------------|--|---------------------------------|---------------------------------|
|             | 15 нас хүрэхээсээ өмнө эмэгтгэичүүдийн хувь | 15-49 насны эмэгтгэичүүдийн тоо | 18 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн эмэгтгэичүүдийн хувь | 20-49 насны эмэгтгэичүүдийн тоо | 15 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн эмэгтгэичүүдийн хувь | 15-49 насны эмэгтгэичүүдийн тоо | 18 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн эмэгтгэичүүдийн хувь | 20-49 насны эмэгтгэичүүдийн тоо | 15 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн эмэгтгэичүүдийн хувь | 15-49 насны эмэгтгэичүүдийн тоо | 18 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн эмэгтгэичүүдийн хувь | 15-49 насны эмэгтгэичүүдийн тоо | 20-49 насны эмэгтгэичүүдийн тоо |
| 15-19       | 0.0   | 804                             | ...  | ...                             | 0.0  | 382                             | ...  | ...                             | 0.0  | 1 186                           | ...  | ...                             | ...                             |
| 20-24       | 0.0   | 992                             | 1.4  | 992                             | 0.0  | 393                             | 4.8  | 393                             | 0.0  | 1 385                           | 2.4  | 1 385                           | 1 385                           |
| 25-29       | 0.0   | 828                             | 3.1  | 828                             | 0.4  | 509                             | 8.4  | 509                             | 0.2  | 1 336                           | 5.1  | 1 336                           | 1 336                           |
| 30-34       | 0.2   | 814                             | 3.4  | 814                             | 0.3  | 519                             | 7.1  | 519                             | 0.3  | 1 333                           | 4.9  | 1 333                           | 1 333                           |
| 35-39       | 0.0   | 765                             | 4.0  | 765                             | 0.3  | 525                             | 5.9  | 525                             | 0.1  | 1 291                           | 4.8  | 1 291                           | 1 291                           |
| 40-44       | 0.0   | 728                             | 3.8  | 728                             | 0.6  | 464                             | 5.0  | 464                             | 0.2  | 1 192                           | 4.2  | 1 192                           | 1 192                           |
| 45-49       | 0.0   | 657                             | 3.3  | 657                             | 1.1  | 382                             | 9.9  | 382                             | 0.4  | 1 039                           | 5.7  | 1 039                           | 1 039                           |
| <b>Бүгд</b> | 0.0   | 5 587                           | 3.1  | 4 783                           | 0.4  | 3 175                           | 6.8  | 2 793                           | 0.2  | 8 762                           | 4.4  | 8 762                           | 7 576                           |

## Хүснэгт РН.4: Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ

Одоогоор гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 15-49 насны одоогоор гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл хэрэглэдэг (эсвэл нөхөр/ хамтран амьдрагч нь хэрэглэдэг) 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улс, 2010 он

| Ямар нэгэн арга хэрэглэдэггүй              | Одоогоор гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн хувь: |                   |         |       |        |      |         |         |         |                         |                        | Ямар нэгэн арга хэрэглэдэггүй | Одоогоор гэрлэсэн амьдрагчтай эмэгтэйчүүдийн хувь |                           |              |       |                             |                           |                               |
|--|--|-------------------|---------|-------|--------|------|---------|---------|---------|-------------------------|------------------------|-------------------------------|---|---------------------------|--------------|-------|-----------------------------|---------------------------|-------------------------------|
|  | Умай 2 талын гуурсан хоолойн боох                                | Грин сувгийн боох | Ерөндөг | Тариа | Суулца | Эм   | Эрэгтэй | Эмэгтэй | Балтавч | Диафрагма, лаа, цэрпмаг | Хүүхдээ хөхүүлж байгаа |                               |   | Хуангийн далау түр тэнчих | Галуур тавих | Бусад | Орнин үеийн арга хэрэглэдэг | Уламжлалт арга хэрэглэдэг | Ямар нэгэн арга хэрэглэдэггүй |
| <b>Бүс</b>                                 |  |                   |         |       |        |      |         |         |         |                         |                        |                               |   |                           |              |       |                             |                           |                               |
| Баруун                                     | 2.4  | 0.1               | 23.2    | 9.7   | 0.1    | 10.1 | 5.4     | 0.1     | 0.0     | 0.0                     | 0.0                    | 2.7                           | 0.0   | 0.1                       | 51.2         | 2.8   | 54.0                        | 81.3                      |                               |
| Хангай                                     | 4.7  | 0.5               | 28.0    | 5.1   | 0.1    | 10.6 | 4.6     | 0.0     | 0.1     | 0.4                     | 0.4                    | 2.9                           | 0.0   | 0.1                       | 53.7         | 3.4   | 57.1                        | 105.7                     |                               |
| Төв  | 44.4   | 2.0               | 18.4    | 4.5   | 1.0    | 18.9 | 7.6     | 0.0     | 0.2     | 0.0                     | 0.0                    | 4.8                           | 0.1   | 0.1                       | 50.5         | 5.1   | 55.6                        | 108.8                     |                               |
| Зүүн                                       | 3.4  | 0.5               | 30.7    | 5.1   | 1.4    | 14.5 | 5.4     | 0.0     | 0.0     | 0.3                     | 0.3                    | 2.4                           | 0.1   | 0.3                       | 60.9         | 3.2   | 64.1                        | 44.2                      |                               |
| Улаанбаатар                                | 2.0  | 0.5               | 19.8    | 2.1   | 0.0    | 11.5 | 9.1     | 0.0     | 0.1     | 0.3                     | 0.3                    | 5.9                           | 0.0   | 0.2                       | 45.2         | 6.4   | 51.6                        | 203.3                     |                               |
| <b>Хот, хөдөө</b>                          |  |                   |         |       |        |      |         |         |         |                         |                        |                               |   |                           |              |       |                             |                           |                               |
| Хот  | 47.8   | 2.1               | 20.8    | 3.1   | 0.2    | 11.3 | 8.4     | 0.0     | 0.1     | 0.2                     | 0.2                    | 5.3                           | 0.0   | 0.2                       | 46.5         | 5.8   | 52.2                        | 32.2                      |                               |
| Хөдөө                                      | 41.4   | 3.7               | 25.4    | 6.7   | 0.5    | 13.9 | 5.1     | 0.0     | 0.0     | 0.2                     | 0.2                    | 2.8                           | 0.1   | 0.1                       | 55.4         | 3.2   | 58.6                        | 234.1                     |                               |
| <b>Байршил</b>                             |  |                   |         |       |        |      |         |         |         |                         |                        |                               |   |                           |              |       |                             |                           |                               |
| Нийслэл                                    | 2.0  | 0.5               | 19.8    | 2.1   | 0.0    | 11.5 | 9.1     | 0.0     | 0.1     | 0.3                     | 0.3                    | 5.9                           | 0.0   | 0.2                       | 45.2         | 6.4   | 51.6                        | 203.3                     |                               |
| Аймгийн төв                                | 46.7   | 2.2               | 22.5    | 4.7   | 0.6    | 10.8 | 7.1     | 0.1     | 0.1     | 0.1                     | 0.1                    | 4.4                           | 0.0   | 0.2                       | 48.6         | 4.7   | 53.3                        | 122.9                     |                               |
| Сумын төв                                  | 41.5   | 3.4               | 24.5    | 5.8   | 0.5    | 13.6 | 6.6     | 0.0     | 0.1     | 0.1                     | 0.1                    | 3.8                           | 0.0   | 0.1                       | 54.5         | 4.0   | 58.5                        | 103.3                     |                               |
| Хөдөө                                      | 41.3   | 3.9               | 26.1    | 7.3   | 0.4    | 14.1 | 3.8     | 0.0     | 0.1     | 0.3                     | 0.3                    | 2.0                           | 0.1   | 0.0                       | 56.2         | 2.5   | 58.7                        | 130.8                     |                               |
| <b>Насны бүлэг</b>                         |  |                   |         |       |        |      |         |         |         |                         |                        |                               |   |                           |              |       |                             |                           |                               |
| 15-19                                      | 48.3   | 0.0               | 12.2    | 8.7   | 0.0    | 13.0 | 17.8    | 0.0     | 0.0     | 0.0                     | 0.0                    | 0.0                           | 0.0   | 0.0                       | 51.7         | 0.0   | 51.7                        | 57                        |                               |
| 20-24                                      | 53.4   | 0.0               | 13.9    | 4.2   | 0.2    | 17.1 | 9.8     | 0.0     | 0.0     | 0.8                     | 0.8                    | 0.7                           | 0.0   | 0.0                       | 45.1         | 1.5   | 46.6                        | 618                       |                               |
| 25-29                                      | 42.4   | 0.7               | 22.8    | 5.6   | 0.5    | 15.2 | 9.8     | 0.0     | 0.3     | 0.2                     | 0.2                    | 2.3                           | 0.0   | 0.0                       | 55.1         | 2.5   | 57.6                        | 102.2                     |                               |
| 30-34                                      | 40.4   | 1.4               | 20.3    | 5.9   | 0.3    | 15.3 | 7.1     | 0.1     | 0.1     | 0.2                     | 0.2                    | 3.0                           | 0.1   | 0.2                       | 56.1         | 3.5   | 59.6                        | 108.8                     |                               |
| 35-39                                      | 35.9   | 5.5               | 26.6    | 5.4   | 0.3    | 13.3 | 6.5     | 0.1     | 0.1     | 0.3                     | 0.3                    | 5.8                           | 0.1   | 0.0                       | 58.0         | 6.1   | 64.1                        | 105.8                     |                               |
| 40-44                                      | 42.0   | 4.5               | 25.8    | 3.4   | 0.4    | 9.6  | 5.6     | 0.0     | 0.0     | 0.0                     | 0.0                    | 7.7                           | 0.0   | 0.0                       | 50.3         | 7.7   | 58.0                        | 97.0                      |                               |
| 45-49                                      | 64.6   | 4.0               | 17.5    | 1.9   | 0.1    | 3.0  | 2.6     | 0.0     | 0.0     | 0.0                     | 0.0                    | 5.6                           | 0.0   | 0.8                       | 29.1         | 6.3   | 35.4                        | 79.0                      |                               |
| <b>Амьд байгаа хүүхдийн тоо</b>            |  |                   |         |       |        |      |         |         |         |                         |                        |                               |   |                           |              |       |                             |                           |                               |
Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид, 2003 онд Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколд, 2004 онд Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколд тус тус нэгдэн орсон. Мөн ОУХБ-ын үндсэн 8 конвенцийг соёрхон баталсаны дотор Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138 дугаар Конвенцийг 2002 онд, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182-р Конвенцийг 2001 онд тус тус соёрхон баталжээ.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 32 дугаар зүйлд "Оролцогч улсууд хүүхдийн эдийн засгийн мөлжлөг болон боловсрол эзэмшихэд нь саад болох, эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд нь аюултай ажил эрхлэхээс хамгаалуулах эрхийг хүлээн зөвшөөрнө..." гэжээ. Мөн "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалд хүүхдийн хөдөлмөрийг устгах 9 стратеги болон хүүхдийг мөлжлөгөөс хамгаалах тухай МХЗ-ийн уриалгыг дурдсан байдаг.

"Хүүхэд хөгжил" судалгааны асуулгад 5-17 насны хүүхдийн ажил, хөдөлмөрийн холбогдолтой хэд хэдэн асуултуудыг оруулсан юм.

Судалгааны өмнөх долоо хоногт:

- 5-11 нас: Долоо хоногт наад зах нь 1 цаг эдийн засгийн ямар нэг үйл ажиллагаанд оролцсон эсвэл 28 ба түүнээс дээш цагийг гэрийн ажилд зарцуулсан;
- 12-17 нас: Долоо хоногт наад зах нь 14 цаг эдийн засгийн ямар нэг үйл ажиллагаанд оролцсон эсвэл 28 ба түүнээс дээш цагийг гэрийн ажилд зарцуулсан бол тухайн хүүхдийг хөдөлмөрийн харилцаанд оролцсон гэж үзнэ.

Эдийн засгийн ямар нэг үйл ажиллагаа гэдэгт өөрийн өрхөөс гадуур хөлстэй, хөлсгүй хийсэн ажил, мөн өөрийн өрхийн аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж хийсэн ажлыг ойлгохоос гадна өрхийнхөө хэрэгцээнд зориулан ус зөөх, түлээ түлш бэлтгэх зэргийг оруулна. Энэхүү тодорхойлолт нь хүүхдийн хувьд үгүй болгох ёстой ажил хөдөлмөрийг хүүхдийн хөдөлмөрөөс ялгах боломжийг олгож байгаа болно.

Хүснэгт СР.2-т хүүхдийн хөдөлмөрийг хүүхдийн эрхэлсэн ажлын төрлөөр харуулав. Хүүхэд нэгээс олон төрлийн ажил эрхэлж болох тул нийт дүн 100 хувьд барихгүй. 5-14 насны нийт хүүхдийн 29 хувь, түүний дотор 5-11 насны хүүхдийн 34 хувь, 12-14 насны хүүхдийн 18 хувь нь хөдөлмөр эрхэлж байгааг хүснэгтээс харж болно.

Судалгааны өмнөх 7 хоногийн хугацаанд 5-11 насны нийт хүүхдийн 33 хувь нь нэгээс дээш цагийг эдийн засгийн үйл ажиллагаанд, 2 хувь нь гэрийн ажилд 28-аас дээш цаг зарцуулжээ. Харин 12-14 насны нийт хүүхдийн 15 хувь нь судалгааны өмнөх 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд 14 ба түүнээс дээш цаг, 5 хувь нь гэрийн ажилд 28 ба түүнээс дээш цаг зарцуулжээ. Эдийн засгийн үйл ажиллагаанд хөвгүүд (5-11 насны 37 хувь, 12-14 насны 18 хувь) охидоос (5-11 насны 29 хувь, 12-14 насны 12 хувь) илүү оролцож байна. Мөн хөдөөгийн хүүхдүүдийн хувьд хотын хүүхдүүдтэй харьцуулахад илүүтэйгээр эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдогийг хүснэгтээс харж болно. Харин гэрийн ажлын хувьд охидууд болон хөдөөгийн хүүхдүүд илүү их цаг зарцуулдаг байна.

Хүүхдийн хөдөлмөрийг ерөнхийд нь авч үзвэл 5-14 насны хөвгүүдийн 32 хувь, охидын 26 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцсон байна. Уг үзүүлэлт нь хотод 22 хувь, хөдөөд 38 хувьтай байгаа юм. Бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн бага (16 хувь), Баруун

бүсэд хамгийн өндөр (40 хувь) байв. Эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшин дээшлэх тутам хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд оролцож байгаа нь буурч байна.

#### Нэмэлт 5:

Хэрвээ дээр хэрэглэсэн ойлголтыг өөрийн орны нөхцөл байдлыг харгалзан үзэх, өмнөх судалгааны ойлголттой нийцрүүлэх үүднээс Монгол Улсын хувьд өрхийн хэрэгцээнд зориулж ус зөөх, түлээ түлш бэлтгэх ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулахгүй, гэрийн ажил гэж үздэг. Тиймээс өөрийн улс орны онцлогт суурилж тооцвол 5-14 насны хүүхдийн 10 хувь, 5-11 насны хүүхдийн 8 хувь, 12-14 насны хүүхдийн 16 хувь нь хөдөлмөр эрхэлдэг (Хүснэгт СР.2А) байна. Мөн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн сургуульд хамрагдалт 95 хувь (Хүснэгт СР.3А) гарахаар байна. 2005 оны Хүүхэд хөгжил судалгаанд хүүхдийн хөдөлмөрийг тооцохдоо энэхүү тодорхойлолтыг ашигласан тул үр дүнг харьцуулах боломжтой юм.

Түүнчлэн, харьцуулах үүднээс хүүхдийн хөдөлмөрийн асуултыг 5-17 насны хүүхдээс асуусан. 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг 12-14 насны хүүхдийнхтэй адилаар долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд хамгийн багадаа 14 цаг, гэрийн ажилд хамгийн багадаа 28 цаг зарцуулснаар тооцсон. 5-17 насны хүүхдийн үзүүлэлтүүдийг Хүснэгт СР.2, СР.2А, СР.3 болон СР.3А-д олон улсын болон өөрийн орны онцлогт суурилснаар тооцож харуулав.

Хүснэгт СР.3-т 5-14 насны хөдөлмөр эрхэлдэг бөгөөд сургуульд явдаг хүүхдийн эзлэх хувь болон 5-14 насны сургуульд явдаг хүүхдийн хэдэн хувь нь хөдөлмөр эрхэлж байгааг харууллаа. 5-14 насны хөдөлмөр эрхэлдэг нийт хүүхдийн дийлэнх (96 хувь) нь сургуульд хамрагддаг байна. Харин 5-14 насны сургуульд сурдаг нийт хүүхдийн бараг 30 хувь хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд энэ үзүүлэлт хотод 23 хувь, хөдөөд 38 хувьтай байна.

#### Хүүхдийн хүмүүжил

"Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалд "хүүхэд аливаа төрлийн хүчирхийллээс хамгаалагдах ёстой..." гэж заасан ба Мянганы тунхаглалд хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, доромжлолоос хамгаалахыг уриалсан байдаг.

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орж, конвенцийн үзэл санаа, зарчимд нийцүүлэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг 1996 оноос батлан хэрэгжүүлж эхэлсэн ба энэ хуулиар хүүхэд бүрийн аливаа төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийг баталгаажуулсан билээ.

Энэхүү судалгаанд хамрагдсан 2-14 насны хүүхэдтэй өрх бүрээс нэг хүүхдийг санамсаргүй аргаар сонгож, хүүхдийн эцэг, эх/ асран хамгаалагчаас хүүхдээ үгэнд орохгүй бол хүмүүжлийн ямар арга хэрэглэдэг тухай асуусан юм.

Хүүхдийн хүмүүжилтэй холбоотой дараах 2 үзүүлэлтийг тооцсон:

1) Шийтгэлийн зорилгоор сэтгэл зүйн хүчирхийлэл эсвэл бага болон хүнд зэргийн бие махбодийн шийтгэл хүлээсэн 2-14 насны хүүхдийн тоо;

2) 2-14 насны хүүхэдтэй ба хүүхдээ зөв хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэлийн арга ашиглах нь зөв гэж үздэг эцэг, эх/ асран хамгаалагчийн тоо.

Хүснэгт СР.4-өөс харахад судалгааны өмнөх 1 сарын хугацаанд 2-14 насны хүүхдийн 39 хувьд нь эцэг, эх болон гэр бүлийн гишүүд хүүхдийг хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн бус хүмүүжлийн аргыг хэрэглэсэн нь өмнөх 2005 оны ХХС-ны дүнтэй харьцуулахад бараг 2 дахин нэмэгдсэн байгаа бөгөөд хүүхдийн гаргасан ямар нэг алдаа дутагдлыг тайлбарлан хэлж ойлгуулах байдал нэмэгдэж байгаа нь сайшаалтай юм. Гэсэн хэдий ч 2-14 насны нийт хүүхдийн 46 хувь нь сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэлийн аль нэг хэлбэрээр өөрийн эх/ асран хамгаалагч эсвэл гэр бүлийн бусад гишүүдээр шийтгүүлсэн байна. Энэ үзүүлэлт эрэгтэй (48 болон 43 хувь), Төвийн бүсийн (54 болон 40-46 хувь), 5-9 насны (48 болон 44-45 хувь) хүүхдүүдийн хувьд бусадтай харьцуулахад өндөр байна. Харин казак өрхийн тэргүүлэгчтэй болон өрхийн тэргүүлэгч нь исламын шашин шүтдэг өрхийн хүүхдүүдийн хувьд (28 хувь) улсын дунджаас доогуур байгаа юм. Эцэг, эх/ асран хамгаалагчаасаа бие махбодийн хүнд хэлбэрийн шийтгэл амссан 2-14 насны хүүхдийн эзлэх хувь 3 байгаа нь хүүхдийн хүчирхийлэлгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх эрхийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Нөгөө талаас судалгаанд хамрагдсан нийт эцэг, эх/ асран хамгаалагчийн 16 хувь нь хүүхдээ хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэлийн аргыг хэрэглэж болно гэж үздэг байна (Хүснэгт СР.4). Үүнээс харахад эцэг, эх/ асран хамгаалагчдын дийлэнх хэсэг хүүхдийг бие махбодийн шийтгэлийн аргаар хүмүүжүүлэх шаардлагагүй гэж үздэг боловч судалгаанд хамрагдсан дөрвөн хүүхэд тутмын нэг (25 хувь) нь бие махбодийн шийтгэлээр шийтгүүлсэн байна. Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэх талаарх эцэг, эх/ асран хамгаалагчдын хандлага тэдний боловсролын түвшнээс бага зэрэг хамаарч байна. Тухайлбал, боловсролгүй болон бага боловсролтой 5 эцэг, эхийн нэг (21 хувь) нь хүүхдээ хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэл оногдуулах нь зөв гэж үздэг байхад энэ үзүүлэлт дээд боловсролтой эцэг, эхчүүдийн хувьд 14 хувь байна.

### Эрт гэрлэлт

Залуу охидын хувьд 18 насанд хүрэхээсээ өмнө гэрлэх явдал амьдралд байсаар байна. НҮБ-ын Хүүхдийн сангаас дэлхий дахинд хийсэн судалгаанаас харахад 20-24 насны 64 сая гаруй эмэгтэй 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн буюу хамтран амьдарч эхэлсэн байна. Эрт гэрлэлтэд нөлөөлдөг хүчин зүйлст хүүхдийн насны лавлагааг гаргадаг тухайн улсын иргэний бүртгэлийн тогтолцоо, насанд хүрээгүй хүний гэрлэлтийн асуудлаарх эрх зүйн тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэгч механизм, ийм үйлдлийг хөхиүлэн дэмждэг уламжлалт болон шашны хууль зэрэг орно.

Дэлхийн олон оронд санхүүгийн болон нийгмийн хувьд ашигтай байж магадгүй гэж үзэн охиноо эрт нөхөрт гаргахыг эцэг, эх нь дэмждэг бөгөөд нөгөө талаар гэр бүлийнхээ санхүүгийн ачааг нимгэлэхийг хүсдэг байна. Гэвч үнэндээ эрт гэрлэлт нь хүний эрхийн зөрчил бөгөөд охидын хөгжилд нөлөөлж, эрт жирэмслэлт, нийгмээс тусгаарлагдах байдалд хүргэн, улмаар бага боловсрол эзэмшин, мэргэжлийн сургалтад хамрагдаж чадаагүйгээс жендэрт суурилсан ядууралд хүргэдэг.

Гэрлэсэн залуу охид өвөрмөц боловч гол төлөв нийтэд ил байдаггүй бүлэг хүмүүс юм. Өөрсдөө хүүхэд хэвээрээ хэдий ч гэрийн ажилд дарагдсан, хүүхэд төрүүлж, өсгөх үүрэгтэй эдгээр охидын шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдмал, амьдралын сонголт муутай байдаг. Эрт гэрлэлтэд хөвгүүд ч мөн адил өртдөг боловч үр нөлөө нь оксидод тооны болон эрүүл мэндийн хувьд илүү тусдаг. Хосууд албан ёсоор гэрлээгүй боловч эхнэр, нөхөр болон хамтран амьдрах асуудал ч гэрлэлтийн нэгэн адил хүний эрхийн асуудал юм. Насанд хүрээгүй

охин эрэгтэй хүнтэй хамт амьдарч, түүнийг асран халамжилж байгаа бол насанд хүрээгүйгээс үл хамааран түүнийг насанд хүрсэн эмэгтэй мэт үздэг. Түүнчлэн, тэд албан ёсоор гэр бүл болоогүйгээс өв залгамжлах, иргэншил авах, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх зэрэг нэмэлт асуудлууд бий болж, гэрлэсэн охидоос илүү эмзэг байдалд ордог.

Судалгаанаас харахад хүүхдийг эрт гэрлэхэд хүргэдэг хоорондоо харилцан уялдаатай олон хүчин зүйл байдаг. Ядуурал, охидын хамгаалал, гэр бүлийн нэр хүнд, нийгмийн тогтворгүй байдлын үеийн үйл ажиллагаа зэрэг нь охидыг насанд хүрээгүй байхдаа гэр бүл болоход хүргэдэг хамгийн гол хүчин зүйлс билээ. Залуу насандаа гэрлэсэн эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөмтгий байдаг. Хосуудын насны зөрүү эрх мэдлийн хүчирхийлэл болон эрт бэлэвсрэх эрсдэлд нөлөөлдөг.

Эрт гэрлэлттэй холбоотой өөр нэг асуудал бол охидын бэлгийн амьдрал эхлэх нас юм. 18 нас хүрэхээс өмнө гэр бүлтэй болсон эмэгтэйчүүд сүүлд гэр бүл болсон эмэгтэйчүүдээс илүү олон хүүхэд төрүүлэх хандлагатай байдаг. Жирэмслэлттэй холбоотой нас баралт 15-19 насны гэрлэсэн болон гэрлээгүй охид, ялангуяа энэ бүлгийн хамгийн залуу охидын хувьд нас баралтын голлох шалтгаан болдог. Бага насандаа гэрлэж буй охид гол төлөв өөрөөсөө ахимаг насны эртэй гэр бүл болдог бөгөөд энэ нь тэдний ХДХВ-ийн халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Энэ судалгаанд Монгол Улсын охидын эрт гэрлэлтийг 15 болон 18 насанд хүрэхээс өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувиар илэрхийлж байна (Хүснэгт СР.5). Эрт гэрлэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувийг Хүснэгт СР.5-д харуулав. Нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүдийн хувьд 15 наснаас өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй бага (0.4 хувь) байгаа боловч хот, хөдөөгийн болон боловсролын түвшний ялгаатай байдал харагдаж байна. Тухайлбал, 15 нас хүрэхээсээ өмнө гэрлэх нь хөдөөд хотоос 2 дахин, боловсролгүй эмэгтэйчүүдийн хувьд улсын дунджаас 6 дахин өндөр байгаа юм.

Арван таван нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь бага байгаа боловч 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн 20-49 насны эмэгтэйчүүдийн хувь харьцангуй өндөр (7 хувь) байна. 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувийг бүсээр авч үзвэл Баруун бүс болон Улаанбаатар хотод (4-5 хувь) бусад бүстэй (9 хувь) харьцуулахад хамгийн бага байлаа. Энэ үзүүлэлтэд хот, хөдөө, боловсрол болон өрхийн амьжиргааны түвшнээр ялгаатай байгааг хүснэгтээс харж болно. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад 15-19 насны 20 эмэгтэй тутмын нэг нь гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай байна. Эрт гэрлэлт нь хот, хөдөө, боловсрол болон амьжиргааны түвшний ялгаатай байдалтай шууд хамааралтай байгаа нь эмэгтэйчүүдийг чадваржуулах замаар тэдний эрх зөрчигдөхөөс сэргийлэхэд чиглэсэн бодлого, стратегийг түлхүү хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Эрэгтэйчүүдийн хувьд эрт гэрлэлтийн үзүүлэлтүүд эмэгтэйчүүдийнхээс харьцангуй доогуур байгаа нь Хүснэгт СР.5М-ээс харагдаж байна. Энэ нь залуу насны охид ахимаг насны эрэгтэйчүүдтэй гэр бүл болох нь түгээмэл болохыг харуулж байна.

Хүснэгт СР.6 (СР.6М)-д 15 ба 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн буюу гэр бүлийн харилцаанд орсон эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн эзлэх хувийг хот, хөдөө болон насны бүлгээр харууллаа. 15 ба 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн хувийг насны бүлгээр авч үзэх нь эрт гэрлэлтийн ерөнхий хандлагыг харахад хэрэгтэй байдаг. 15 ба 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн эзлэх хувийг насны бүлгээр үзвэл эрт гэрлэх хандлага буурч байгаа нь харагдаж байна. Тухайлбал, 15 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн

эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувь 50-54 насны болон 45-49 насны хүн амын дунд хамгийн өндөр (0.8 болон 1 хувь) байгаа юм. Харин 18 нас хүрэхээсээ өмнөх гэрлэх нь 25-29 насны эмэгтэйчүүд (8 хувь), 35-39 насны эрэгтэйчүүд (3 хувь)-ийн дунд хамгийн өндөр байна. Өөрөөр хэлбэл, эрт гэрлэлтийн үзүүлэлт 24 болон түүнээс доош насны эмэгтэйчүүдийн дунд улсын дунджаас доогуур байгаа нь залуу насандаа гэр бүл болох хандлага сүүлийн жилүүдэд буурч байгааг харуулж байна.

Эрт гэрлэлтийг тодорхойлдог өөр нэг үзүүлэлт нь хосуудын насны зөрүү ба үүнийг өөрөөсөө 10 ба түүнээс дээш насаар ах хүнтэй гэрлэсэн эсвэл гэр бүлийн харилцаанд орсон эмэгтэйчүүдийн хувиар илэрхийлдэг. Хүснэгт СР.7-д эхнэр, нөхрийн насны зөрүүг харууллаа. Үүнээс харахад Монгол Улсад 15-19 настай нийт эмэгтэйчүүдийн 9 хувь нь өөрөөсөө 10 ба түүнээс дээш насаар ах, 29 хувь нь 5-9 насаар ах эрэгтэйтэй гэр бүл болсон байна. Харин эдгээр үзүүлэлт 20-24 настай гэрлэсэн эмэгтэйн хувьд харьцангуй бага (2 хувь, 13 хувь) байна.

### Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага

Гэр бүлд олон тулгамдсан асуудал гарах болсны нэг нь гэр бүлийн хүчирхийлэл билээ. Хүчирхийлэл нь төдийлөн ил харагддаггүй, үр дагавар нь гэмт хэргийн шинжтэй байдгаараа онцлог юм.

Монгол Улсын УИХ-аас "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийг 2004 онд, "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг 2007 онд тус тус батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн, төрөөс олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйл, хандлагыг өөрчлөх талаар тодорхой ажлуудыг хийж байна. Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодийн, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно гэж заасан байдаг.

Гэр бүлийн хүчирхийллийн эдгээр хэлбэрийг судлах зорилгоор 15-49 насны эмэгтэйчүүд болон 15-54 насны эрэгтэйчүүдээс янз бүрийн тохиолдолд нөхөр нь эхнэр/ хамтран амьдрагчаа цохих буюу зодох явдал байж болох эсэх талаарх санаа бодлыг тандсан асуултыг асуусан. Эдгээр асуулт нь нөхөр/ хамтран амьдрагчийн зүгээс үйлддэг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд нөлөөлж болох нийгмийн итгэл үнэмшлийг тодорхойлох зорилготой юм. Нөхөр/ хамтран амьдрагч эхнэр/ хамтран амьдрагчаа тодорхой тохиолдолд зодох нь зөв гэж үзэж байгаа эмэгтэйчүүд бодит амьдрал дээр өөрийнхөө нөхөр/ хамтран амьдрагчид зодуулдаг эсвэл эрэгтэйчүүд нь өөрийн эхнэр/ хамтран амьдрагчаа зоддог байх магадлалтай гэж үзэж болохгүй.

Энэ асуултад судалгаанд хамрагдагчид хэрхэн хариулсныг Хүснэгт СР.11 болон Хүснэгт СР.11М-д харуулав. Монгол Улсын эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн 11 (10) хувь нь нөхөр нь эхнэрээ тодорхой шалтгааны улмаас зодох зөв гэж үзэж байна. Нөхрийнхөө хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөг эмэгтэйчүүд хүүхдээ үл тоомсорлох (9 хувь), дур мэдэн их хэмжээний мөнгөөр худалдаа хийх зэргээр (3 хувь) бие даасан байдлаа илэрхийлэхэд нөхөр нь тэднийг зодох зөв гэж ихэнх тохиолдолд хүлээн зөвшөөрдөг байдал харагдаж байна. Эрэгтэйчүүдийн хувьд мөн адил дээрх 2 шалтгаан хамгийн өндөр (6 болон 4 хувь) байв. Казак өрхийн тэргүүлэгчтэй (15 болон 24 хувь) болон өрхийн тэргүүлэгч нь Исламын шашин шүтдэг (14 болон 26 хувь) өрхийн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн дунд гэр бүлийн хүчирхийллийг илүү хүлээн зөвшөөрөх хандлагатай байна. Түүнчлэн, энэ үзүүлэлт хот, хөдөө, бүс, боловсролын болон амьжиргааны түвшинтэй шууд хамааралтай байгааг хүснэгтээс харж болно.

**Хүснэгт СР.1: Төрсний бүртгэл**

5 хүртэлх насны хүүхдийн хувь, төрснийг нь бүртгүүлсэн эсэхээр, Монгол Улс, 2010 он

|   | Иргэний бүртгэлд төрснийг нь бүртгүүлсэн<br>5 хүртэлх насны хүүхэд |             |                                 |                                  | 5 хүртэлх<br>насны<br>хүүхдийн тоо |
|---|--|-------------|---------------------------------|----------------------------------|------------------------------------|
|   | Төрсний гэрчилгээ байгаа   |             | Төрсний<br>гэрчилгээ<br>байхгүй | Нийт<br>бүртгүүлсэн <sup>1</sup> |                                    |
|   | Үзсэн  | Үзээгүй     |                                 |                                  |                                    |
| <b>Хүйс</b>                                 |  |             |                                 |                                  |                                    |
| Эрэгтэй                                     | 76.6   | 21.7        | 0.4                             | 98.8                             | 1 981                              |
| Эмэгтэй                                     | 80.0   | 18.9        | 0.3                             | 99.2                             | 1 975                              |
| <b>Бүс</b>                                  |  |             |                                 |                                  |                                    |
| Баруун                                      | 64.8   | 33.0        | 0.7                             | 98.5                             | 613                                |
| Хангай                                      | 75.8   | 23.6        | 0.0                             | 99.4                             | 877                                |
| Төв   | 74.3   | 24.2        | 0.8                             | 99.3                             | 739                                |
| Зүүн  | 66.3   | 32.9        | 0.3                             | 99.6                             | 292                                |
| Улаанбаатар                                 | 90.2   | 8.3         | 0.1                             | 98.6                             | 1 435                              |
| <b>Хот, хөдөө</b>                           |  |             |                                 |                                  |                                    |
| Хот   | 84.5   | 14.1        | 0.3                             | 98.9                             | 2 298                              |
| Хөдөө                                       | 69.8   | 28.9        | 0.4                             | 99.1                             | 1 658                              |
| <b>Байршил</b>                              |  |             |                                 |                                  |                                    |
| Нийслэл                                     | 90.2   | 8.3         | 0.1                             | 98.6                             | 1 435                              |
| Аймгийн төв                                 | 75.0   | 23.8        | 0.6                             | 99.4                             | 863                                |
| Сумын төв                                   | 73.2   | 25.1        | 0.4                             | 98.7                             | 698                                |
| Хөдөө                                       | 67.4   | 31.7        | 0.3                             | 99.4                             | 960                                |
| <b>Насны бүлэг</b>                          |  |             |                                 |                                  |                                    |
| 0-11 сартай                                 | 77.1   | 16.9        | 1.0                             | 95.1                             | 826                                |
| 12-23 сартай                                | 80.5   | 19.2        | 0.3                             | 100.0                            | 958                                |
| 24-35 сартай                                | 78.3   | 21.4        | 0.3                             | 100.0                            | 832                                |
| 36-47 сартай                                | 77.4   | 22.6        | 0.0                             | 100.0                            | 714                                |
| 48-59 сартай                                | 77.8   | 22.2        | 0.0                             | 100.0                            | 626                                |
| <b>Эхийн боловсрол*</b>                     |  |             |                                 |                                  |                                    |
| Боловсролгүй                                | 75.6   | 24.4        | 0.0                             | 100.0                            | 181                                |
| Бага  | 72.9   | 26.4        | 0.2                             | 99.6                             | 312                                |
| Суурь                                       | 73.3   | 25.1        | 0.6                             | 99.0                             | 730                                |
| Бүрэн дунд                                  | 81.1   | 17.4        | 0.2                             | 98.7                             | 1 069                              |
| Техникийн болон тусгай<br>мэргэжлийн дунд   | 73.1   | 24.5        | 0.8                             | 98.4                             | 261                                |
| Дээд  | 81.3   | 17.3        | 0.3                             | 99.0                             | 1 403                              |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>             |  |             |                                 |                                  |                                    |
| Доогуур                                     | 66.7   | 32.1        | 0.4                             | 99.2                             | 930                                |
| Дунджаас доогуур                            | 78.3   | 20.3        | 0.2                             | 98.8                             | 797                                |
| Дундаж                                      | 80.5   | 17.6        | 0.6                             | 98.6                             | 764                                |
| Дунджаас дээгүүр                            | 85.8   | 13.7        | 0.1                             | 99.6                             | 738                                |
| Дээгүүр                                     | 83.4   | 14.7        | 0.5                             | 98.6                             | 727                                |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |  |             |                                 |                                  |                                    |
| Халх  | 80.0   | 18.8        | 0.2                             | 99.0                             | 3 166                              |
| Казак                                       | 70.9   | 25.8        | 1.6                             | 98.3                             | 148                                |
| Бусад                                       | 71.6   | 26.6        | 0.8                             | 99.0                             | 635                                |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |  |             |                                 |                                  |                                    |
| Шүтдэггүй                                   | 76.4   | 22.3        | 0.3                             | 99.1                             | 1 831                              |
| Будда                                       | 80.6   | 18.0        | 0.3                             | 98.8                             | 1 843                              |
| Ислам                                       | 70.7   | 25.8        | 1.4                             | 97.8                             | 117                                |
| Бусад                                       | 80.4   | 19.6        | 0.0                             | 100.0                            | 154                                |
| <b>Бүгд</b>                                 | <b>78.3</b>  | <b>20.3</b> | <b>0.3</b>                      | <b>99.0</b>                      | <b>3 956</b>                       |

\* Эхийн боловсрол гэдэгт 5 хүртэлх насны хүүхдийн эх/ асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

\*\* “Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа” нь хариулагдаагүй 12 ажиглалт (жигнээгүй)-ыг харгалзан харуулаагүй болно.

\*\*\* “Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг” нь хариулагдаагүй 14 ажиглалт (жигнээгүй)-ыг харгалзан харуулаагүй болно.

<sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 8.1



**Хүснэгт СР.2: Хүүхдийн хөдөлмөр**

Судалгаанаас өмнөх 7 хоногийн хугацаанд эдийн засгийн үйл ажиллагаа болон гэрийн ажилд оролцсон хүүхдийн хувь, насны бүлгээр, 5-14 болон 5-17 насны хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он

|                             | 5-11 насны хүүхдийн хувь:   |                      |                   |                      |  |                      | 12-14 насны хүүхдийн хувь:  |                      |                   |                      |  |                      | 15-17 насны хүүхдийн хувь:  |                      |                   |                      |  |                      |     |      |      |
|-----------------------------|-----------------------------|----------------------|-------------------|----------------------|--|----------------------|-----------------------------|----------------------|-------------------|----------------------|--|----------------------|-----------------------------|----------------------|-------------------|----------------------|--|----------------------|-----|------|------|
|                             | Эдийн засгийн үйл ажиллагаа |                      | Хүүхдийн хөдөлмөр |                      | 28 ба түүнээс олон цагийг гарин зарцуулсан |                      | Эдийн засгийн үйл ажиллагаа |                      | Хүүхдийн хөдөлмөр |                      | 28 ба түүнээс олон цагийг гарин зарцуулсан |                      | Эдийн засгийн үйл ажиллагаа |                      | Хүүхдийн хөдөлмөр |                      | 28 ба түүнээс олон цагийг гарин зарцуулсан |                      |     |      |      |
|                             | Хөдөлмөр эрхэлдэг           | Хөдөлмөр эрхэлдэггүй | Хөдөлмөр эрхэлдэг | Хөдөлмөр эрхэлдэггүй | Хөдөлмөр эрхэлдэг                          | Хөдөлмөр эрхэлдэггүй | Хөдөлмөр эрхэлдэг           | Хөдөлмөр эрхэлдэггүй | Хөдөлмөр эрхэлдэг | Хөдөлмөр эрхэлдэггүй | Хөдөлмөр эрхэлдэг                          | Хөдөлмөр эрхэлдэггүй | Хөдөлмөр эрхэлдэг           | Хөдөлмөр эрхэлдэггүй | Хөдөлмөр эрхэлдэг | Хөдөлмөр эрхэлдэггүй | Хөдөлмөр эрхэлдэг                          | Хөдөлмөр эрхэлдэггүй |     |      |      |
| <b>Хүйс</b>                 |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |     |      |      |
| Эрэгтэй                     | 0.5                         | 0.2                  | 37.3              | 37.3                 | 42.1                                       | 1.3                  | 37.6                        | 2402                 | 1.0               | 0.4                  | 67.0                                       | 48.8                 | 18.4                        | 62.9                 | 3.9               | 20.8                 | 1088                                       | 3.0                  | 1.2 | 66.5 | 41.6 |
| Эмэгтэй                     | 0.0                         | 0.1                  | 29.1              | 29.2                 | 54.3                                       | 2.6                  | 30.6                        | 2213                 | 0.7               | 0.4                  | 51.6                                       | 39.8                 | 12.2                        | 75.5                 | 6.0               | 15.9                 | 1063                                       | 1.7                  | 0.6 | 51.6 | 37.5 |
| <b>Бүс</b>                  |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |     |      |      |
| Баруун                      | 0.3                         | 0.3                  | 47.3              | 47.6                 | 43.6                                       | 2.5                  | 48.2                        | 805                  | 1.1               | 0.2                  | 70.1                                       | 49.2                 | 21.4                        | 63.5                 | 6.4               | 25.0                 | 409  | 2.0                  | 0.6 | 70.0 | 43.3 |
| Хангай                      | 0.1                         | 0.1                  | 40.7              | 40.7                 | 48.9                                       | 1.8                  | 41.2                        | 1048                 | 0.2               | 0.2                  | 58.7                                       | 39.9                 | 18.9                        | 59.9                 | 5.0               | 21.4                 | 481  | 3.4                  | 2.1 | 65.9 | 36.6 |
| Төв                         | 0.6                         | 0.3                  | 37.8              | 37.8                 | 48.8                                       | 3.3                  | 39.0                        | 873                  | 3.1               | 1.6                  | 62.8                                       | 43.4                 | 20.2                        | 68.5                 | 6.0               | 23.6                 | 425  | 5.5                  | 2.3 | 61.7 | 34.0 |
| Зүүн                        | 0.0                         | 0.1                  | 32.3              | 32.3                 | 46.2                                       | 1.3                  | 32.9                        | 394                  | 0.0               | 0.0                  | 58.5                                       | 46.6                 | 11.9                        | 70.2                 | 3.4               | 14.4                 | 175  | 0.9                  | 0.0 | 59.8 | 43.0 |
| Улаанбаатар                 | 0.3                         | 0.0                  | 18.4              | 18.4                 | 49.6                                       | 1.1                  | 19.4                        | 1494                 | 0.0               | 0.0                  | 51.3                                       | 44.6                 | 6.7                         | 79.4                 | 3.6               | 9.7                  | 660  | 0.9                  | 0.0 | 50.6 | 41.6 |
| <b>Хот, хөдөө</b>           |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |     |      |      |
| Хот                         | 0.2                         | 0.0                  | 25.1              | 25.1                 | 51.6                                       | 1.3                  | 26.2                        | 2554                 | 0.2               | 0.1                  | 56.9                                       | 48.2                 | 8.9                         | 78.9                 | 4.3               | 12.4                 | 1156                                       | 1.5                  | 0.4 | 55.0 | 43.3 |
| Хөдөө                       | 0.4                         | 0.3                  | 43.6              | 43.7                 | 43.5                                       | 2.7                  | 44.2                        | 2060                 | 1.6               | 0.7                  | 62.2                                       | 39.9                 | 22.8                        | 57.7                 | 5.7               | 25.3                 | 994  | 3.8                  | 1.7 | 67.0 | 34.0 |
| <b>Байршил</b>              |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |     |      |      |
| Нийслэл                     | 0.3                         | 0.0                  | 18.4              | 18.4                 | 49.6                                       | 1.1                  | 19.4                        | 1494                 | 0.0               | 0.0                  | 51.3                                       | 44.6                 | 6.7                         | 79.4                 | 3.6               | 9.7                  | 660  | 0.9                  | 0.0 | 50.6 | 41.6 |
| Аймгийн төв                 | 0.1                         | 0.1                  | 34.5              | 34.6                 | 54.3                                       | 1.7                  | 35.9                        | 1060                 | 0.6               | 0.3                  | 64.4                                       | 53.0                 | 11.8                        | 78.3                 | 5.1               | 16.0                 | 496  | 2.5                  | 1.1 | 62.2 | 46.1 |
| Сумын төв                   | 0.8                         | 0.3                  | 48.3              | 48.5                 | 52.5                                       | 3.1                  | 49.1                        | 996                  | 3.0               | 1.0                  | 72.9                                       | 52.1                 | 21.6                        | 73.5                 | 6.5               | 25.0                 | 510  | 5.1                  | 1.2 | 74.4 | 45.9 |
| Хөдөө                       | 0.0                         | 0.2                  | 39.2              | 39.2                 | 35.1                                       | 2.3                  | 39.5                        | 1064                 | 0.2               | 0.4                  | 51.0                                       | 27.0                 | 24.0                        | 41.0                 | 4.8               | 25.6                 | 485  | 2.5                  | 2.2 | 60.0 | 22.6 |
| <b>Сургуульд хамрагдалт</b> |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |                             |                      |                   |                      |  |                      |     |      |      |
| Хамрагддаг                  | 0.3                         | 0.1                  | 34.3              | 34.4                 | 50.0                                       | 2.0                  | 35.2                        | 4299                 | 0.9               | 0.4                  | 59.2                                       | 44.7                 | 14.8                        | 69.5                 | 4.9               | 18.0                 | 2101                                       | 1.6                  | 0.8 | 57.4 | 40.9 |
| Хамрагддаггүй               | 0.0                         | 0.0                  | 20.7              | 20.7                 | 20.2                                       | 1.4                  | 21.0                        | 316                  | 0.0               | 0.0                  | 66.9                                       | 31.1                 | 35.8                        | 55.1                 | 3.9               | 35.8                 | 50   | 9.1                  | 1.5 | 78.0 | 30.3 |

|   |            |            |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |             |             |             |             |
|---|------------|------------|-------------|-------------|-------------|------------|-------------|-------------|------------|------------|-------------|-------------|-------------|-------------|------------|-------------|-------------|------------|------------|-------------|-------------|-------------|-------------|------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
| <b>Эхийн боловсрол*</b>                     |            |            |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |             |             |             |             |
| Боловсролгүй                                | 0.0        | 0.0        | 42.3        | 39.8        | 0.5         | 42.3       | 204         | 1.5         | 0.0        | 73.0       | 50.1        | 22.9        | 65.9        | 3.2         | 24.0       | 67          | 3.8         | 0.0        | 65.4       | 32.1        | 36.4        | 55.1        | 8.9         | 42.1       | 48          | 37.8        | 271         | 38.4        | 319         |             |
| Бага  | 0.8        | 0.0        | 44.4        | 44.8        | 3.9         | 45.0       | 383         | 1.5         | 0.0        | 63.2       | 47.3        | 17.0        | 57.9        | 5.2         | 19.9       | 148         | 4.5         | 1.5        | 64.7       | 31.7        | 34.7        | 57.5        | 6.0         | 36.1       | 119         | 38.0        | 530         | 37.7        | 650         |             |
| Суурь                                       | 0.2        | 0.1        | 40.0        | 43.3        | 2.5         | 40.8       | 988         | 0.8         | 0.8        | 63.9       | 43.8        | 20.5        | 60.5        | 3.7         | 22.1       | 486         | 3.4         | 1.4        | 70.4       | 42.9        | 28.8        | 62.8        | 5.9         | 31.9       | 341         | 34.6        | 1474        | 34.1        | 1815        |             |
| Бүрэн дунд                                  | 0.2        | 0.1        | 33.6        | 33.6        | 48.0        | 1.6        | 34.2        | 1245        | 0.8        | 0.0        | 62.9        | 48.2        | 14.8        | 71.3        | 5.0        | 17.7        | 600         | 2.8        | 0.2        | 63.6        | 42.2        | 22.8        | 69.2        | 7.7        | 27.5        | 486         | 28.8        | 1845        | 28.6        | 2331        |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд      | 1.0        | 0.8        | 41.1        | 41.5        | 53.7        | 1.4        | 42.0        | 477         | 1.1        | 1.5        | 66.8        | 47.6        | 19.2        | 71.6        | 7.6        | 23.6        | 321         | 2.1        | 2.2        | 66.0        | 45.7        | 20.5        | 72.6        | 5.5        | 24.3        | 326         | 34.6        | 798         | 31.6        | 1124        |
| Дээд  | 0.1        | 0.0        | 20.9        | 51.6        | 1.7         | 22.1       | 1313        | 0.6         | 0.0        | 43.9       | 36.9        | 7.4         | 76.7        | 4.4         | 11.5       | 529         | 0.9         | 0.4        | 43.0       | 34.2        | 9.4         | 75.8        | 6.5         | 15.4       | 496         | 19.1        | 1842        | 18.3        | 2338        |             |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>             |            |            |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |             |             |             |             |
| Доогуур                                     | 0.2        | 0.0        | 39.4        | 39.6        | 34.1        | 2.0        | 39.8        | 1005        | 0.5        | 0.2        | 52.7        | 30.2        | 22.6        | 41.5        | 3.0        | 23.5        | 457         | 2.3        | 1.3        | 60.0        | 24.9        | 36.2        | 44.8        | 6.4        | 38.4        | 319         | 34.7        | 1461        | 35.4        | 1781        |
| Дунджаас доогуур                            | 0.8        | 0.3        | 46.4        | 46.5        | 52.7        | 1.9        | 46.8        | 1095        | 0.5        | 0.8        | 77.2        | 59.7        | 17.7        | 74.9        | 5.5        | 20.9        | 488         | 3.7        | 0.9        | 78.5        | 51.1        | 28.0        | 69.1        | 6.7        | 32.1        | 383         | 38.8        | 1583        | 37.5        | 1966        |
| Дундаж                                      | 0.1        | 0.3        | 39.7        | 39.8        | 49.8        | 2.8        | 40.9        | 872         | 1.8        | 0.5        | 76.3        | 59.6        | 17.3        | 77.1        | 6.3        | 20.9        | 457         | 3.5        | 1.6        | 77.8        | 55.1        | 24.3        | 71.0        | 8.5        | 29.7        | 368         | 34.0        | 1330        | 33.1        | 1698        |
| Дунджаас дээгүүр                            | 0.2        | 0.0        | 31.5        | 51.8        | 0.9         | 32.0       | 877         | 0.9         | 0.0        | 69.2       | 55.0        | 14.1        | 76.2        | 5.6         | 17.9       | 420         | 0.8         | 0.5        | 73.1       | 57.8        | 15.3        | 77.8        | 4.6         | 18.9       | 379         | 27.4        | 1297        | 25.5        | 1676        |             |
| Дээгүүр                                     | 0.0        | 0.0        | 1.7         | 1.7         | 53.0        | 2.2        | 3.9         | 765         | 0.6        | 0.3        | 6.1         | 6.2         | 0.5         | 78.8        | 4.0        | 4.5         | 329         | 1.6        | 0.3        | 8.6         | 7.2         | 3.0         | 79.2        | 7.2        | 10.0        | 373         | 4.1         | 1094        | 5.6         | 1467        |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |            |            |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |             |             |             |             |
| Халх  | 0.2        | 0.1        | 31.5        | 31.5        | 48.5        | 1.9        | 32.3        | 3648        | 0.7        | 0.5        | 58.0        | 43.6        | 14.7        | 70.0        | 4.4        | 17.4        | 1679        | 2.5        | 0.9        | 57.4        | 38.5        | 19.8        | 69.5        | 6.4        | 24.5        | 1387        | 27.6        | 5327        | 27.0        | 6714        |
| Казак                                       | 0.7        | 0.0        | 42.5        | 43.2        | 43.8        | 2.6        | 43.7        | 208         | 2.2        | 0.0        | 67.3        | 40.6        | 27.5        | 62.4        | 10.4       | 33.5        | 96          | 1.4        | 0.0        | 62.6        | 30.6        | 32.7        | 56.7        | 11.2       | 36.8        | 95          | 40.5        | 304         | 39.6        | 399         |
| Бусад                                       | 0.4        | 0.0        | 40.0        | 40.0        | 46.5        | 1.7        | 40.9        | 754         | 0.9        | 0.0        | 63.2        | 48.3        | 15.1        | 66.6        | 5.8        | 18.7        | 373         | 2.3        | 1.1        | 68.3        | 47.3        | 22.2        | 71.2        | 6.4        | 26.0        | 338         | 33.6        | 1127        | 31.8        | 1465        |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |            |            |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |            |            |             |             |             |             |            |             |             |             |             |             |             |
| Шүтдэггүй                                   | 0.1        | 0.1        | 34.5        | 34.5        | 46.0        | 2.5        | 35.5        | 1966        | 0.8        | 0.5        | 60.4        | 47.8        | 12.8        | 69.9        | 5.4        | 16.2        | 892         | 1.8        | 0.6        | 57.3        | 37.6        | 20.2        | 65.5        | 7.1        | 24.6        | 696         | 29.5        | 2858        | 28.5        | 3554        |
| Будда                                       | 0.4        | 0.2        | 32.5        | 32.5        | 49.8        | 1.5        | 33.1        | 2302        | 0.9        | 0.4        | 57.9        | 41.6        | 16.6        | 68.9        | 4.2        | 19.1        | 1108        | 2.5        | 1.2        | 61.7        | 42.4        | 20.6        | 73.1        | 6.3        | 25.1        | 965         | 28.6        | 3410        | 27.8        | 4374        |
| Ислам                                       | 0.9        | 0.0        | 41.4        | 42.2        | 44.1        | 1.5        | 42.9        | 161         | 2.9        | 0.0        | 73.0        | 44.4        | 29.7        | 67.6        | 9.7        | 36.6        | 73          | 2.0        | 0.0        | 62.3        | 28.4        | 35.0        | 57.6        | 9.2        | 38.7        | 68          | 41.0        | 234         | 40.5        | 301         |
| Бусад                                       | 0.0        | 0.4        | 23.5        | 23.9        | 51.7        | 0.0        | 23.9        | 165         | 0.0        | 0.0        | 53.5        | 43.6        | 9.9         | 65.8        | 2.9        | 12.8        | 73          | 6.0        | 0.8        | 55.2        | 37.8        | 19.6        | 66.5        | 4.1        | 23.2        | 86          | 20.5        | 238         | 21.2        | 324         |
| <b>Бүгд</b>                                 | <b>0.3</b> | <b>0.1</b> | <b>33.4</b> | <b>33.4</b> | <b>48.0</b> | <b>1.9</b> | <b>34.2</b> | <b>4615</b> | <b>0.9</b> | <b>0.4</b> | <b>59.4</b> | <b>44.3</b> | <b>15.3</b> | <b>69.1</b> | <b>4.9</b> | <b>18.4</b> | <b>2150</b> | <b>2.4</b> | <b>0.9</b> | <b>59.7</b> | <b>39.7</b> | <b>20.9</b> | <b>69.1</b> | <b>6.7</b> | <b>25.4</b> | <b>1822</b> | <b>29.2</b> | <b>6765</b> | <b>28.4</b> | <b>8587</b> |

\* Эхийн боловсрол гэдэгт 5-17 насны хүүхдийн эх/асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно. Мөн эхийн боловсрол нь хариулагдаагүй ажиглалт (жигнээгүй) 5-11 насны хүүхдийн хувьд 3, 12-14 насны хүүхдийн хувьд байхгүй, бусад хүүхдийн хувьд харгалзан 4, 3, 7 болно.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 8, 2, 3, 10, 13 ажиглалт (жигнээгүй)-ыг харгалзан харуулаагүй болно.

\*\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь хариулагдаагүй 19, 5, 8, 24, 32 ажиглалт (жигнээгүй)-ыг харгалзан харуулаагүй болно.

**Хүснэгт СР.2А: Өөрийн орны онцлогт суурилж тооцсон хүүхдийн хөдөлмөр**

Судалгаанаас өмнөх 7 хоногийн хугацаанд эдийн засгийн үйл ажиллагаа болон гэрийн ажилд оролцсон хүүхдийн хувь, насны бүлгээр, өөрийн орны онцлогт суурилан тооцсон 5-14 болон 5-17 насны хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он

|                             | 5-11 насны хүүхдийн хувь:   |          |                   |          |   |          | 12-14 насны хүүхдийн хувь:  |          |                   |          |   |          | 15-17 насны хүүхдийн хувь:  |          |                   |          |   |          |     |      |     |      |      |      |      |       |      |       |      |       |
| Бэлбэсэн                      | (3.1)   | (1.4)   | (3.1)   | (0.0)  | (0.0)   | (0.0)   | (4.4)                                    | (4.4)                               | 29                                   |
| Цуцалсан                      | 6.8   | 12.2  | 12.2  | 0.0  | 0.0   | 9.9   | 16.6                                     | 20.5                                | 76                                   |
| Тусгаарласан                  | 4.0   | 9.1   | 6.3   | 0.5  | 0.9   | 5.9   | 14.0                                     | 16.1                                | 81                                   |
| Огт гэрлэж байгаагүй          | 2.2   | 6.5   | 3.1   | 1.3  | 0.7   | 5.0   | 9.0                                      | 10.6                                | 1 223                                |



|  |            |            |            |            |            |            |            |            |              |  |  |  |  |
|--|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|--------------|--|--|--|--|
| <b>Боловсрол</b>                           |            |            |            |            |            |            |            |            |              |  |  |  |  |
| Боловсролгүй                               | 3.7        | 11.4       | 7.1        | 2.6        | 1.7        | 7.8        | 16.2       | 17.3       | 234          |  |  |  |  |
| Бага                                       | 2.7        | 10.8       | 3.1        | 2.1        | 1.6        | 4.6        | 12.0       | 13.3       | 380          |  |  |  |  |
| Суурь                                      | 2.4        | 7.1        | 3.6        | 1.2        | 0.8        | 4.5        | 9.9        | 10.9       | 1 055        |  |  |  |  |
| Бүрэн дүнд                                 | 1.8        | 4.8        | 2.9        | 1.1        | 0.7        | 3.7        | 7.9        | 9.4        | 1 034        |  |  |  |  |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд     | 2.1        | 7.4        | 4.2        | 1.1        | 0.5        | 5.1        | 9.6        | 11.2       | 417          |  |  |  |  |
| Дээд                                       | 1.3        | 3.1        | 2.2        | 0.3        | 0.1        | 1.5        | 5.0        | 5.3        | 906          |  |  |  |  |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>            |            |            |            |            |            |            |            |            |              |  |  |  |  |
| Доогуур                                    | 2.7        | 10.3       | 4.6        | 2.0        | 1.8        | 5.5        | 12.9       | 14.4       | 827          |  |  |  |  |
| Дунджаас доогуур                           | 3.1        | 9.2        | 4.9        | 1.3        | 0.8        | 6.0        | 12.3       | 13.6       | 742          |  |  |  |  |
| Дундаж                                     | 1.8        | 4.8        | 3.6        | 1.2        | 0.4        | 3.2        | 8.2        | 8.8        | 785          |  |  |  |  |
| Дунджаас дээгүүр                           | 1.1        | 4.2        | 2.5        | 0.8        | 0.4        | 2.5        | 5.8        | 6.8        | 846          |  |  |  |  |
| Дээгүүр                                    | 1.7        | 3.0        | 1.4        | 0.4        | 0.1        | 2.4        | 5.3        | 6.1        | 825          |  |  |  |  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*</b>   |            |            |            |            |            |            |            |            |              |  |  |  |  |
| Халх                                       | 2.1        | 5.8        | 3.3        | 1.0        | 0.7        | 3.9        | 8.2        | 9.4        | 3 238        |  |  |  |  |
| Казак                                      | 4.3        | 11.3       | 4.2        | 2.2        | 1.0        | 3.5        | 15.0       | 15.2       | 154          |  |  |  |  |
| Бусад                                      | 1.5        | 7.5        | 3.4        | 1.3        | 0.9        | 4.1        | 10.4       | 11.0       | 626          |  |  |  |  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг**</b> |            |            |            |            |            |            |            |            |              |  |  |  |  |
| Шүтдэггүй                                  | 2.1        | 6.4        | 3.0        | 1.1        | 0.4        | 4.5        | 8.9        | 10.5       | 1 773        |  |  |  |  |
| Будда                                      | 2.1        | 6.0        | 3.8        | 1.1        | 1.0        | 3.4        | 8.6        | 9.3        | 1 961        |  |  |  |  |
| Ислам                                      | 4.2        | 10.7       | 4.3        | 2.2        | 1.3        | 3.7        | 14.2       | 14.2       | 119          |  |  |  |  |
| Бусад                                      | 0.0        | 4.3        | 1.7        | 0.8        | 0.0        | 3.5        | 6.0        | 6.3        | 154          |  |  |  |  |
| <b>Бүгд</b>                                | <b>2.1</b> | <b>6.2</b> | <b>3.3</b> | <b>1.1</b> | <b>0.7</b> | <b>3.9</b> | <b>8.8</b> | <b>9.9</b> | <b>4 025</b> |  |  |  |  |

\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 8 ажиглалт (жингээгүй)-ыг харуулаагүй.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь хариулагдаагүй 20 ажиглалт (жингээгүй)-ыг харуулаагүй.

( ) 25-49 ажиглалт (жингээгүй) дээр үндэслэн тооцсон.

<sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 8.14

**Хүснэгт СР.12: Хүүхдийн амьдралын нөхцөл, өнчин хүүхэд**

0-17 насны хүүхдийн хувь, амьдралын нөхцлөөр, төрсөн эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй 0-17 насны хүүхдийн хувь, хагас, бүтэн өнчин хүүхдийн хувь, Монгол Улс, 2010 он

|   | Эцэг, эхийнхээ хэн нэгэнтэй нь амьдардаг |                   | Эцэгтэйгээ хамт амьдардаг |                    | Эцэгтэйгээ хамт амьдардаг |                    | Төрсөн эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй | Хагас, бүтэн өнчин хүүхэд | 0-17 насны хүүхдийн тоо |            |                  |      |        |
|---|--|-------------------|---------------------------|--------------------|---------------------------|--------------------|---|---------------------------|-------------------------|------------|------------------|------|--------|
|   | Зөвхөн эцэг нь амьд                      | Зөвхөн эх нь амьд | Хоёулаа амьд              | Хоёулаа нас барсан | Эцэг нь амьд              | Эцэг нь нас барсан |   |                           |                         | Эх нь амьд | Эх нь нас барсан |      |        |
| <b>Хүйс</b>                                 |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| Эрэгтэй                                     | 0.2                                      | 0.5               | 5.0                       | 0.4                | 10.7                      | 4.9                | 1.5                                     | 0.9                       | 1.4                     | 100.0      | 6.0              | 6.9  | 6 507  |
| Эмэгтэй                                     | 0.2                                      | 0.6               | 4.8                       | 0.5                | 11.2                      | 4.5                | 0.8                                     | 0.6                       | 1.4                     | 100.0      | 6.0              | 6.3  | 6 150  |
| <b>Бүс</b>                                  |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| Баруун                                      | 0.1                                      | 0.4               | 2.8                       | 0.5                | 4.8                       | 4.7                | 0.5                                     | 1.0                       | 0.5                     | 100.0      | 3.7              | 6.7  | 2 167  |
| Хангай                                      | 0.2                                      | 0.4               | 3.7                       | 0.4                | 6.7                       | 5.4                | 1.0                                     | 1.4                       | 1.8                     | 100.0      | 4.7              | 7.9  | 2 807  |
| Төв   | 0.3                                      | 0.6               | 6.3                       | 0.1                | 13.7                      | 4.6                | 1.4                                     | 0.3                       | 1.6                     | 100.0      | 7.3              | 5.9  | 2 367  |
| Зүүн  | 0.4                                      | 0.6               | 6.7                       | 0.4                | 10.6                      | 5.6                | 1.0                                     | 0.4                       | 0.9                     | 100.0      | 8.2              | 7.5  | 998    |
| Улаанбаатар                                 | 0.1                                      | 0.7               | 5.5                       | 0.5                | 15.5                      | 4.1                | 1.6                                     | 0.5                       | 1.6                     | 100.0      | 6.9              | 6.0  | 4 318  |
| <b>Хот, хөдөө</b>                           |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| Хот   | 0.1                                      | 0.6               | 5.8                       | 0.4                | 13.9                      | 4.9                | 1.4                                     | 0.6                       | 1.5                     | 100.0      | 7.0              | 6.8  | 7 198  |
| Хөдөө                                       | 0.3                                      | 0.4               | 3.7                       | 0.4                | 7.0                       | 4.4                | 0.8                                     | 1.0                       | 1.2                     | 100.0      | 4.8              | 6.5  | 5 459  |
| <b>Байршил</b>                              |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| Нийслэл                                     | 0.1                                      | 0.7               | 5.5                       | 0.5                | 15.5                      | 4.1                | 1.6                                     | 0.5                       | 1.6                     | 100.0      | 6.9              | 6.0  | 4 318  |
| Аймгийн төв                                 | 0.2                                      | 0.6               | 6.1                       | 0.3                | 11.6                      | 6.2                | 1.2                                     | 0.6                       | 1.4                     | 100.0      | 7.2              | 8.0  | 2 880  |
| Сумын төв                                   | 0.3                                      | 0.5               | 5.4                       | 0.4                | 9.9                       | 4.6                | 0.9                                     | 0.9                       | 1.5                     | 100.0      | 6.7              | 6.8  | 2 563  |
| Хөдөө                                       | 0.2                                      | 0.3               | 2.2                       | 0.3                | 4.5                       | 4.2                | 0.8                                     | 1.1                       | 1.1                     | 100.0      | 3.0              | 6.1  | 2 896  |
| <b>Насны бүлэг</b>                          |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| 0-4   | 0.0                                      | 0.1               | 3.2                       | 0.1                | 11.4                      | 1.6                | 0.6                                     | 0.2                       | 0.8                     | 100.0      | 3.5              | 2.0  | 4 070  |
| 5-9   | 0.1                                      | 0.7               | 6.0                       | 0.3                | 11.0                      | 3.2                | 1.3                                     | 0.6                       | 1.8                     | 100.0      | 7.0              | 4.9  | 3 234  |
| 10-14                                       | 0.5                                      | 0.9               | 5.2                       | 0.7                | 10.7                      | 6.9                | 1.4                                     | 1.0                       | 1.4                     | 100.0      | 7.2              | 10.0 | 3 631  |
| 15-17                                       | 0.2                                      | 0.7               | 6.1                       | 0.8                | 10.4                      | 10.0               | 1.9                                     | 1.9                       | 2.2                     | 100.0      | 7.8              | 13.5 | 1 822  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн боловсрол*</b>      |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| Боловсролгүй                                | 0.4                                      | 0.6               | 4.5                       | 0.5                | 9.3                       | 6.0                | 0.9                                     | 2.2                       | 1.5                     | 100.0      | 5.9              | 9.6  | 859    |
| Бага  | 0.4                                      | 1.3               | 6.8                       | 0.5                | 10.1                      | 4.7                | 0.6                                     | 1.5                       | 2.1                     | 100.0      | 9.1              | 8.5  | 1 520  |
| Суурь                                       | 0.1                                      | 0.2               | 3.0                       | 0.2                | 8.1                       | 3.2                | 1.2                                     | 0.7                       | 1.0                     | 100.0      | 3.4              | 4.4  | 3 196  |
| Бүрэн дунд                                  | 0.2                                      | 0.4               | 3.6                       | 0.6                | 11.1                      | 5.6                | 1.0                                     | 0.5                       | 1.6                     | 100.0      | 4.8              | 7.3  | 2 772  |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд      | 0.1                                      | 0.7               | 5.7                       | 0.5                | 12.6                      | 6.7                | 1.5                                     | 0.6                       | 1.4                     | 100.0      | 6.9              | 8.6  | 1 474  |
| Дээд  | 0.2                                      | 0.6               | 7.0                       | 0.3                | 14.0                      | 4.0                | 1.5                                     | 0.3                       | 1.3                     | 100.0      | 8.2              | 5.6  | 2 795  |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>             |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| Доогуур                                     | 0.2                                      | 0.3               | 2.1                       | 0.3                | 6.1                       | 3.9                | 0.7                                     | 1.3                       | 1.3                     | 100.0      | 2.9              | 6.0  | 2 736  |
| Дунджаас доогуур                            | 0.3                                      | 0.8               | 4.6                       | 0.2                | 13.0                      | 6.3                | 0.8                                     | 0.6                       | 2.1                     | 100.0      | 5.8              | 8.2  | 2 773  |
| Дундаж                                      | 0.3                                      | 0.4               | 5.1                       | 0.6                | 12.5                      | 5.5                | 1.2                                     | 1.1                       | 1.5                     | 100.0      | 6.3              | 7.8  | 2 491  |
| Дунджаас дээгүүр                            | 0.1                                      | 0.8               | 6.2                       | 0.4                | 9.9                       | 3.6                | 1.4                                     | 0.5                       | 0.9                     | 100.0      | 7.4              | 5.4  | 2 435  |
| Дээгүүр                                     | 0.1                                      | 0.5               | 7.2                       | 0.6                | 13.8                      | 3.9                | 2.0                                     | 0.3                       | 1.2                     | 100.0      | 8.3              | 5.3  | 2 221  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| Халх  | 0.2                                      | 0.6               | 4.9                       | 0.4                | 11.7                      | 4.8                | 1.3                                     | 0.8                       | 1.5                     | 100.0      | 6.1              | 6.7  | 9 977  |
| Казах                                       | 0.2                                      | 0.2               | 4.1                       | 0.5                | 1.8                       | 6.3                | 0.4                                     | 1.2                       | 0.0                     | 100.0      | 5.0              | 8.4  | 550    |
| Бусад                                       | 0.1                                      | 0.5               | 5.0                       | 0.6                | 9.6                       | 3.9                | 0.8                                     | 0.6                       | 1.2                     | 100.0      | 6.2              | 5.6  | 2 113  |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |  |                   |                           |                    |                           |                    |   |                           |                         |            |                  |      |        |
| Шүтдэггүй                                   | 0.2                                      | 0.3               | 4.1                       | 0.3                | 11.1                      | 3.3                | 1.2                                     | 0.8                       | 1.3                     | 100.0      | 5.0              | 4.9  | 5 448  |
| Будда                                       | 0.1                                      | 0.6               | 5.4                       | 0.5                | 11.1                      | 5.6                | 1.2                                     | 0.8                       | 1.6                     | 100.0      | 6.7              | 7.6  | 6 261  |
| Ислам                                       | 0.3                                      | 0.4               | 3.7                       | 0.5                | 1.9                       | 6.9                | 0.5                                     | 1.4                       | 0.0                     | 100.0      | 4.9              | 9.5  | 421    |
| Бусад                                       | 0.6                                      | 1.2               | 6.9                       | 0.5                | 15.9                      | 7.4                | 0.6                                     | 0.2                       | 1.8                     | 100.0      | 9.3              | 10.0 | 482    |
| <b>Бүгд</b>                                 | 0.2                                      | 0.5               | 4.9                       | 0.4                | 11.0                      | 4.7                | 1.2                                     | 0.8                       | 1.4                     | 100.0      | 6.0              | 6.6  | 12 657 |

\*"Өрхийн тэргүүлэгчийн боловсрол" нь харуулагдаагүй 45 ажилтат (жингээгүй)-ыг харуулаагүй болно.

\*\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 25 ажилтат (жингээгүй)-ыг харуулаагүй.

\*\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь харуулагдаагүй 47 ажилтат (жингээгүй)-ыг харуулаагүй.

1 ХХС-ны үзүүлэлт 9.17

2 ХХС-ны үзүүлэлт 9.18

**Хүснэгт СР.13: Өнчин болон өнчин биш хүүхдүүдийн сургуульд хамрагдалт**  
 10-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, өнчин эсэхээр, Монгол Улс, 2010 он

|   | Эцэг, эх нь нас барсан хүүхдийн хувь (өнчин) | Эцэг, эх нь амьд бөгөөд эцэг, эхийнхээ хэн нэгэнтэй эсвэл хоёулангтай нь хамт амьдардаг хүүхдийн хувь (өнчин биш) | 10-14 насны хүүхдийн тоо | Өнчин хүүхдүүдийн сургуульд хамрагдалт <sup>1</sup> | 10-14 насны өнчин хүүхдийн тоо | Өнчин биш хүүхдүүдийн сургуульд хамрагдалт <sup>2</sup> | 10-14 насны өнчин биш хүүхдийн тоо | Өнчин болон өнчин биш хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын харьцаа |        |
|---|--|---|--------------------------|---|--------------------------------|---|------------------------------------|--|--------|
|   |  |   |                          |   |                                |   |                                    | (*)  | (*)    |
| <b>Хүйс</b>                                 |  |   |                          |   |                                |   |                                    |  |        |
| Эрэгтэй                                     | 0.5  | 82.7  | 1 827                    | (*)   | 10                             | 97.6  | 1 511                              | (*)  | (*)    |
| Эмэгтэй                                     | 0.9  | 84.2  | 1 704                    | (*)   | 15                             | 98.9  | 1 436                              | (*)  | (*)    |
| <b>Бүс</b>                                  |  |   |                          |   |                                |   |                                    |  |        |
| Баруун                                      | 0.7  | 87.6  | 653                      | (*)   | 5                              | 98.1  | 572                                | (*)  | (*)    |
| Хангай                                      | 0.4  | 84.1  | 820                      | (*)   | 3                              | 97.3  | 690                                | (*)  | (*)    |
| Төв   | 0.2  | 82.3  | 696                      | (*)   | 1                              | 98.0  | 572                                | (*)  | (*)    |
| Зүүн  | 0.4  | 79.5  | 295                      | (*)   | 1                              | 97.9  | 234                                | (*)  | (*)    |
| Улаанбаатар                                 | 1.3  | 82.3  | 1 068                    | (*)   | 14                             | 99.3  | 879                                | (*)  | (*)    |
| <b>Хот, хөдөө</b>                           |  |   |                          |   |                                |   |                                    |  |        |
| Хот   | 1.1  | 81.9  | 1 913                    | (*)   | 21                             | 99.2  | 1 567                              | (*)  | (*)    |
| Хөдөө                                       | 0.3  | 85.2  | 1 618                    | (*)   | 5                              | 97.1  | 1 379                              | (*)  | (*)    |
| <b>Байршил</b>                              |  |   |                          |   |                                |   |                                    |  |        |
| Нийслэл                                     | 1.3  | 82.3  | 1 068                    | (*)   | 14                             | 99.3  | 879                                | (*)  | (*)    |
| Аймгийн төв                                 | 0.8  | 81.6  | 844                      | (*)   | 6                              | 99.1  | 689                                | (*)  | (*)    |
| Сумын төв                                   | 0.3  | 83.0  | 825                      | (*)   | 3                              | 98.6  | 685                                | (*)  | (*)    |
| Хөдөө                                       | 0.2  | 87.5  | 793                      | (*)   | 2                              | 95.7  | 694                                | (*)  | (*)    |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн боловсрол*</b>      |  |   |                          |   |                                |   |                                    |  |        |
| Боловсролгүй                                | 2.0  | 74.0  | 200                      | (*)   | 4                              | 95.1  | 148                                | (*)  | (*)    |
| Бага  | 0.7  | 73.4  | 365                      | (*)   | 3                              | 97.6  | 288                                | (*)  | (*)    |
| Суурь                                       | 0.1  | 91.1  | 966                      | (*)   | 1                              | 97.4  | 880                                | (*)  | (*)    |
| Бүрэн дунд                                  | 1.0  | 83.8  | 791                      | (*)   | 8                              | 99.0  | 663                                | (*)  | (*)    |
| Техникийн болон тусгай мэргэжлийн дунд      | 1.2  | 82.6  | 466                      | (*)   | 6                              | 98.7  | 385                                | (*)  | (*)    |
| Дээд  | 0.5  | 81.0  | 735                      | (*)   | 4                              | 99.5  | 595                                | (*)  | (*)    |
| <b>Өрхийн аж байдлын түвшин</b>             |  |   |                          |   |                                |   |                                    |  |        |
| Доогуур                                     | 0.3  | 86.9  | 724                      | (*)   | 2                              | 95.1  | 629                                | (*)  | (*)    |
| Дунджаас доогуур                            | 0.5  | 82.6  | 842                      | (*)   | 4                              | 97.8  | 696                                | (*)  | (*)    |
| Дундаж                                      | 0.8  | 81.1  | 724                      | (*)   | 5                              | 99.3  | 588                                | (*)  | (*)    |
| Дунджаас дээгүүр                            | 0.7  | 84.9  | 666                      | (*)   | 5                              | 99.6  | 565                                | (*)  | (*)    |
| Дээгүүр                                     | 1.6  | 81.6  | 575                      | (*)   | 9                              | 99.9  | 469                                | (*)  | (*)    |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**</b>   |  |   |                          |   |                                |   |                                    |  |        |
| Халх  | 0.7  | 83.2  | 2 768                    | (*)   | 19                             | 98.5  | 2 304                              | (*)  | (*)    |
| Казақ                                       | 0.9  | 84.3  | 161                      | (*)   | 1                              | 99.5  | 136                                | (*)  | (*)    |
| Бусад                                       | 0.8  | 84.3  | 597                      | (*)   | 5                              | 96.8  | 503                                | (*)  | (*)    |
| <b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг***</b> |  |   |                          |   |                                |   |                                    |  |        |
| Шүтдэггүй                                   | 0.7  | 86.4  | 1 471                    | (*)   | 10                             | 98.0  | 1 271                              | (*)  | (*)    |
| Будда                                       | 0.7  | 81.6  | 1 821                    | (*)   | 14                             | 98.4  | 1 486                              | (*)  | (*)    |
| Ислам                                       | 1.1  | 84.8  | 125                      | (*)   | 1                              | 98.6  | 106                                | (*)  | (*)    |
| Бусад                                       | 0.0  | 71.4  | 104                      | (*)   | .                              | 98.8  | 74                                 | (*)  | (*)    |
| <b>Бүгд</b>                                 | 0.7  | 83.4  | 3 531                    | (100.0)   | 25                             | 98.2  | 2 947                              | (1.02)   | (1.02) |

\* "Өрхийн тэргүүлэгчийн боловсрол" нь харуулагдаагүй ажиглалт (жигнээгүй) 10-14 насны хүүхдийн хувьд 10, 10-14 насны өнчин хүүхдийн хувьд байхгүй, 10-14 насны өнчин биш хүүхдийн хувьд 10 болно.  
 \*\* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй ажиглалт (жигнээгүй) 10-14 насны хүүхдийн хувьд 5, 10-14 насны өнчин хүүхдийн хувьд байхгүй, 10-14 насны өнчин биш хүүхдийн хувьд 3 болно.  
 \*\*\* "Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг" нь харуулагдаагүй ажиглалт (жигнээгүй) 10-14 насны хүүхдийн хувьд 11, 10-14 насны өнчин хүүхдийн хувьд байхгүй, 10-14 насны өнчин биш хүүхдийн хувьд 10 болно.  
 ( ) 25-49 ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.  
 (\*) 25 хүртэлх ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.  
<sup>1</sup> ХХС-ны үзүүлэлт 9.19; МХЗ-ын үзүүлэлт 6.4  
<sup>2</sup> ХХС-ны үзүүлэлт 9.20; МХЗ-ын үзүүлэлт 6.4



# БҮЛЭГ XII

## ХДХВ, ДОХ, БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ



© НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол /П.Болор/ 2007 он

## XII

### ХДХВ-ын халдварын талаарх мэдлэг, ХДХВ, ДОХ-ын талаарх ташаа ойлголтууд

Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдвар хэрхэн халдварладаг, түүнээс хэрхэн сэргийлэх талаар зөв мэдлэгтэй байх нь энэхүү халдвараас сэргийлэх хамгийн чухал нөхцөл юм. Зөв мэдээлэл өгөх нь халдвараас сэргийлэх арга замыг зааж өгөх, мэдлэгийг нэмэгдүүлэх эхний алхам болдог. ХДХВ-ийн тухай ташаа ойлголтууд түгээмэл байдаг бөгөөд эдгээр нь залуу хүмүүст эргэлзээ төрүүлэх, урьдчилан сэргийлэх талаарх чармайлтыг сааруулахад хүргэдэг.

Хүн амын дунд хоол хүнсээ хувааж хэрэглэснээр эсвэл шумууланд хазуулснаар ХДХВ халдварладаг гэсэн нийтлэг буруу ойлголтуудаас гадна улс орнуудад өөр өөр ташаа ойлголтууд байдаг. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХДХВ, ДОХ-ын талаарх тусгай хуралдаанаас залуучуудын ХДХВ-ийн халдвараас өөрийгөө сэргийлэх мэдлэг, дадлыг дээшлүүлэхийг Засгийн газруудад уриалсан байдаг.

ХДХВ ба түүнээс сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх, халдвар тархахаас сэргийлэхийн тулд хүмүүсийн дадал, хандлагыг өөрчлөх замаар дээрх зорилтын хэрэгжилтийг хэмжихээс гадна МХЗ-ын ХДХВ-ийн тархалтыг 50 хувиар бууруулна гэсэн зорилт хэрхэн хэрэгжиж байгааг харуулдаг үзүүлэлтүүдийг тооцдог. Энэ бүлгийг 15-49 насны эмэгтэйчүүд болон 15-54 насны эрэгтэйчүүдээс асуусан.


ХДХВ хэрхэн халдварладаг болох түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөв бөгөөд цогц мэдлэгтэй залуу эмэгтэйчүүдийн хувь нь МХЗ, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХДХВ, ДОХ-ын талаарх тусгай хуралдааны үзүүлэлт юм. Монголын ОУБТС 2010-д ХДХВ-ийн талаар сонссон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс ХДХВ-ийн халдвараас сэргийлэх дараах 3 аргыг мэддэг эсэхийг асуусан. Үүнд: халдвар аваагүй, зөвхөн нэг бэлгийн хавьтагчтай байх, бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэх мөн бэлгийн хавьтлыг тэвчих зэрэг болно.

Эдгээр үзүүлэлтүүдийг эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдээр ялган Хүснэгт НА.1, НА.1М-д үзүүлсэн. Нийт эмэгтэйчүүдийн 93 хувь, эрэгтэйчүүдийн 88 хувь нь ДОХ-ын талаар сонсчээ. Гэсэн хэдий ч ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргыг мэддэг эмэгтэйчүүдийн хувь 72, эрэгтэйчүүдийн хувь 71 байна. Эмэгтэйчүүдийн 78 хувь нь халдвар аваагүй, зөвхөн нэг бэлгийн хавьтагчтай байх, 81 хувь нь бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэх нь ХДХВ-ийн халдвараас сэргийлж болно гэж хариулжээ. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 79 хувь, эрэгтэйчүүдийн 73 хувь нь эрүүл харагдаж байгаа хүн ХДХВ-ийн халдвар авсан байж болно гэж мэддэг байна. Хотын эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн 78 хувь нь ХДХВ-ийн халдвараас сэргийлэх 2 аргыг мэддэг байхад хөдөөгийн эрэгтэйчүүдийн 61 хувь, эмэгтэйчүүдийн 63 хувь нь л мэддэг байв. Түүнчлэн, ХДХВ-ийн халдвараас сэргийлэх 2 аргын талаарх мэдлэг Баруун бүсийн эрэгтэйчүүд (60 хувь), эмэгтэйчүүд (63 хувь)-ийн дунд хамгийн бага байгаа юм. Боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшнээр авч үзвэл эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн боловсрол болон аж байдлын түвшин нэмэгдэх тутам ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэг нэмэгдэж байна.

ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг болон ХДХВ-ийн халдварын талаарх ташаа ойлголтыг зөв тодорхойлж чадсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн

хувийг мөн Хүснэгт НА.1 болон Хүснэгт НА.1М-д харуулсан. Энэ үзүүлэлтийг гаргахдаа тухайн улсад хамгийн түгээмэл байдаг ташаа ойлголтыг хэрэглэхийг зөвлөдөг бөгөөд манай улсын хувьд хоол хүнсээ хувааж хэрэглэснээр, шумууланд хазуулснаар ХДХВ-ийн халдвар дамжих талаарх ойлголтыг хэрэглэсэн. ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргын талаарх мэдлэгийн адилаар нийтлэг байдаг 2 ташаа ойлголтыг үгүйсгэсэн болон ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг эмэгтэйчүүд (34 хувь)-ийн хувь эрэгтэйчүүдийнхээс (30 хувь) илүү байна. Эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн 46 (40) хувь нь шумууланд хазуулснаар, 65 (60) хувь нь ДОХ-той хүнтэй хоол хүнсээ хувааж хэрэглэснээр ХДХВ халдварлахгүй гэдгийг тус тус няцаасан, харин 79 (73) хувь нь ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэдэж байв. Баруун болон Зүүн бүсийн, хөдөөгийн, ахимаг насны, бага боловсролтой, өрхийн аж байдлын түвшин доогуур өрхийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дунд нийтлэг байдаг 2 ташаа ойлголтыг няцаах болон ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэдэх нь хамгийн бага байгааг зургаас харж болно (Зураг НА.1).

Зураг НА.1: ХДХВ, ДОХ-ын халдварын талаарх цогц мэдлэгтэй эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улс, 2010 он



ХДХВ, ДОХ-ын талаарх цогц мэдлэгтэй эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-эд ХДХВ-ийн халдвар бэлгийн замаар дамжихаас сэргийлэх 2 аргыг (ХДХВ-ийн халдваргүй, бэлгийн нэг үнэнч хавьтагчтай байх, бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэх) зөв тодорхойлсон, мөн нийтлэг байдаг 2 ташаа ойлголтыг (шумууланд хазуулснаар эсвэл ХДХВ-ийн халдвартай хүнтэй хоол, хүнсээ хувааж идсэнээр ХДХВ-ийн халдвар дамждаг) үгүйсгэж чадсан, түүнчлэн, гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болно гэдгийг мэддэг эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийг хамруулсан. Хүснэгт НА.1, НА.1М-д цогц мэдлэгтэй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувийг харуулав. Монгол Улсын хувьд ХДХВ-ийн халдварын талаарх цогц мэдлэг бага түвшинд буюу 15-49 насны эмэгтэйчүүдийн ердөө 29 хувь, 15-54 насны эрэгтэйчүүдийн 26 хувь нь цогц мэдлэгтэй байгаа юм. Ялангуяа, уг үзүүлэлт хөдөөгийн (18 болон 14 хувь), Баруун болон Зүүн бүсийн (17-19 болон 15-17 хувь), боловсролгүй, бага, суурь боловсролтой (8-16 болон 5-16 хувь), доогуур аж байдалтай өрхийн (13 болон 10 хувь) эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дунд маш бага байна.

ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргыг мэддэг, нийтлэг байдаг 2 ташаа ойлголтыг үгүйсгэсэн, мөн ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг 15-24 насны эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хувийг Хүснэгт НА.2, НА.2М-д харуулсан. Хэдийгээр залуу эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн ХДХВ-ийн талаарх мэдлэгийн түвшин (тухайлбал, цогц мэдлэгийн түвшин 32 болон 29 хувь) 15-49 насны эмэгтэйчүүд болон 15-54 насны эрэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байгаа ч шинж байдлаар авч үзвэл ерөнхийдөө ижил дүр зураг ажиглагдаж байна.

ХДХВ эхээс ураг, нярайд халдварладаг талаарх мэдлэг нь эмэгтэйчүүд жирэмсэн үедээ хүүхдээ халдвар авахаас сэргийлэхийн тулд ХДХВ-ийн шинжилгээ өгөхөд хүргэх хамгийн чухал бөгөөд эхний алхам болдог. Эмэгтэй хүн жирэмсэн болон төрөх үед мөн хүүхдээ хөхөөр хооллож байх хугацаанд ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд халдварладаг болохыг мэддэг байх ёстой. Хүснэгт НА.3 болон НА.3М-д 15-49 насны эмэгтэйчүүд болон 15-54 насны эрэгтэйчүүдийн ХДХВ халдвар эхээс ураг, нярайд дамжих талаарх мэдлэгийн түвшинг харууллаа. Эмэгтэйчүүдийн 79 хувь, эрэгтэйчүүдийн 68 хувь нь ХДХВ-ийн халдвар эхээс ураг, нярайд дамждаг болохыг мэддэг ажээ. Эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн 40 (25) хувь нь ХДХВ-ийн халдвар эхээс ураг, нярайд халдварлах 3 замыг мэддэг хувь байхад 13 (21) хувь нь халдварлах ямар ч замыг мэддэггүй байна. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дунд хамгийн түгээмэл мэддэг эхээс ураг, нярайд халдвар дамжих зам нь жирэмсэн үе (72 болон 59 хувь), үүний дараагаар төрөх үе (62 болон 50 хувь), хамгийн бага мэддэг нь хүүхдээ хөхүүлэх үе (51 болон 35 хувь) байв.

### **ХДХВ, ДОХ-ын халдвартай хүмүүст хандах хандлага**

ХДХВ, ДОХ-ын халдвар авсан хүмүүст хандах хандлагын талаарх үзүүлэлт олон нийтийн дунд тэднийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах явдал байгаа эсэхийг хэмждэг.

Дараах 4 асуултад зөвшөөрсөн хариулт өгч байвал ХДХВ, ДОХ-ын халдвартай хүмүүсийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах явдал бага байна гэсэн үг юм. Үүнд: 1) гэр бүлийн гишүүн нь ДОХ-оор өвчилсөн бол анхаарал, халамж тавих болно; 2) ХДХВ-ийн халдвар авсан хүнсний дэлгүүрийн худалдагчаас шинэ ногоо худалдан авч болно; 3) ХДХВ-ийн халдвар авсан багш сургуульдаа үргэлжлүүлэн багшилж болно гэж боддог; 4) гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь ХДХВ-ийн халдвар авсан тохиолдолд бусдаас нуухыг хүсэхгүй.

Хүснэгт НА.4 болон НА.4М-д 15-49 насны эмэгтэйчүүд болон 15-54 насны эрэгтэйчүүдийн ХДХВ, ДОХ-той хүмүүст хандах хандлагыг харууллаа. ДОХ-ын талаар сонссон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн 97 хувь нь дээрх 4 асуултын аль нэгэнд нь хүлээн зөвшөөрсөн хариулт өгчээ. Манай орны хувьд ХДХВ-ийн халдвартай худалдагчаас мах, ногоо худалдаж авахгүй (эрэгтэйчүүдийн 25 хувь, эмэгтэйчүүдийн 19 хувь) байх нь хамгийн нийтлэг ялгаварлан гадуурхалтын хэлбэр болдог байна. Монгол Улсын 15-49 насны эмэгтэйчүүдийн 4 хувь, 15-54 насны эрэгтэйчүүдийн 5 хувь нь л ХДХВ-ийн халдвартай хүнд эерэг хандлагатай буюу өмнө дурдсан 4 зүйлийг хүлээн зөвшөөрсөн хариулт өгсөн байна. ХДХВ-ийн халдвартай хүнд хандах эерэг хандлага хот, хөдөө, бүс, өрхийн аж байдал болон боловсролын түвшнээр төдийлөн ялгаагүй байгааг Хүснэгт НА.4-өөс харж болно.

### **ХДХВ-ийн шинжилгээ авдаг газрын талаарх мэдлэг, жирэмсэн үеийн хяналтын шинжилгээ, зөвлөгөө**

ХДХВ-ийн халдвар, тархалттай холбоотой өөр нэг чухал үзүүлэлт бол ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг хаана өгч болох талаарх мэдлэг юм. Хувь хүн өөрийгөө



ХДХВ-ийн халдвар авсан эсэхийг мэдэж байх нь халдвар авахаас сэргийлэх, бусдад халдаахаас сэргийлэх үүднээс ихээхэн чухал юм. Түүнчлэн, өөрийнхөө талаар мэдэж байх нь эмчилгээ хийлгэх шийдвэр гаргахад мөн хэрэгтэй.

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийдэг газрыг мэддэг эсэх, ер нь шинжилгээ өгч байсан эсэх талаарх үзүүлэлтүүдийг Хүснэгт НА.5, НА.5М-д харуулав. 15-49 насны эмэгтэйчүүдийн 70 хувь, 15-54 насны эрэгтэйчүүдийн 62 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг хаана хийлгэхийг мэддэг ажээ. Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд 5 эмэгтэй тутмын 1 нь, 8 эрэгтэй тутмын 1 нь шинжилгээ хийлгэжээ. Эмэгтэйчүүдийн 19 хувь, эрэгтэйчүүдийн 12 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд шинжилгээ өгч, хариугаа авсан байна. Энэ удаагийн судалгааны стандарт асуулгад ХДХВ-ийн талаарх зөвлөгөөтэй холбоотой асуулт нэмэгдсэн. Судалгааны үр дүнгээр 15-49 насны эмэгтэйчүүдийн 3 хувь, 15-54 насны эрэгтэйчүүдийн 4 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд шинжилгээ өгч хариугаа авахын зэрэгцээ зөвлөгөө авсан байна. Хүснэгтээс хөдөөгийн, Баруун болон Хангайн бүсийн, ахимаг насны, боловсрол болон өрхийн аж байдлын түвшин доогуур эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувьд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрыг мэдэх, шинжилгээ өгөх, хариугаа авахын зэрэгцээ зөвлөгөө авах нь хангалтгүй байна.

Хүснэгт НА.6, НА.6М-д бэлгийн идэвхтэй амьдралтай буюу судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон 15-24 насны залуучуудын ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрын мэдлэг болон шинжилгээ өгч, хариугаа авсан талаарх дээрхтэй адил үзүүлэлтийг гаргаж харуулав. ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгсөн, хариугаа авсан залуу эмэгтэйчүүдийн хувь нь залуу хүмүүсийн дунд ХДХВ-ийн зөвлөгөө авах, шинжилгээ хийлгэхийг дэмжих бодлого хэр зэрэг үр дүнтэй байгааг хэмжих нэг хэрэгсэл болдог. Учир нь залуу хүмүүс бэлгийн эрүүл мэнд гэсэн эмзэг асуудлаар үйлчилгээ авахад хүндрэлтэй гэж ойлгодог байж болох талтай юм.

Сүүлийн 12 сард 15-24 насны эрэгтэйчүүдийн 57 хувь, эмэгтэйчүүдийн 46 хувь нь бэлгийн хавьталд оржээ. Эдгээр залуу эмэгтэй (эрэгтэй)-н 81 (72) хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг хаана хийлгэхийг мэддэг, 33 (22) хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд шинжилгээ хийлгэсэн, 31 (21) хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд шинжилгээ өгч хариугаа авсан, 3 (9) нь шинжилгээний хариугаа авахын зэрэгцээ зөвлөгөө авсан байна.

Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдээс жирэмсний хяналтад байх үедээ ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн болон зөвлөгөө авсан эмэгтэйчүүдийн хувийг Хүснэгт НА.7-д харууллаа. Сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 40 хувь нь жирэмсний хяналтын үед ХДХВ-ийн талаар зөвлөгөө авч, 61 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан байна. Энэ үзүүлэлт хотын эмэгтэйчүүдийн дунд 71 хувь байхад хөдөөд 45 хувьтай байна. Жирэмсний хяналтад байхдаа ХДХВ-ийн талаарх зөвлөгөө авсан эмэгтэйчүүдийн хувь бүсээр болон өрхийн аж байдлын түвшнээр төдийлөн ялгаагүй байгаа боловч ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан эмэгтэйчүүдийн хувь ялгаатай байна. Тухайлбал, жирэмсний хяналтад байх үедээ ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан эмэгтэйчүүдийн хувь Баруун бүсэд хамгийн бага буюу 40 хувь байхад Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 76 хувь байлаа. Мөн судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, доогуур аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн 39 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан байхад бусад аж байдлын түвшинтэй өрхийн эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт нь 61-70 хувьтай байгаа юм. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин ахих тутам жирэмсний хяналтад байхдаа ХДХВ-ийн

халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авах нь нэмэгдэж байгааг Хүснэгт НА.7-оос харж болно.

### **ХДХВ халдварлахтай холбоотой бэлгийн зан үйл**

Бэлгийн аюулгүй зан үйлийг дэмжих нь ХДХВ-ийн тархалтыг бууруулахад чухал байдаг. Бэлгийн хавьталд ялангуяа, тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэх нь ХДХВ-ийн тархалтыг бууруулахад ихээхэн чухал юм. Хөгжиж буй ихэнх орнуудад ХДХВ-ийн халдвар авсан тохиолдлын талаас илүү хувь нь 15-24 насны залуучуудын дунд байгаа учраас энэ насны залуучуудын бэлгийн зан үйлийг өөрчлөх нь шинээр халдвар авахыг багасгахад чухал ач холбогдолтой.


15-24 насны залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс тэдний ХДХВ-ийн халдвар авах эрсдэл хэр зэрэг байгааг үнэлэх зорилгоор бэлгийн зан үйлтэй холбоотой бүлгийн асуултуудыг асуусан. ХДХВ-ийн эрсдэлт хүчин зүйлд эрт бэлгийн хавьталд орох, өөрөөсөө ах хүнтэй бэлгийн хавьталд орох, тохиолдлын бэлгийн хавьталд орох, бэлгэвч хэрэглэхгүй байх зэрэг ордог.

Хүснэгт НА.8, НА.8М-д залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дунд ХДХВ-ийн халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлдэг бэлгийн зан үйлийн талаарх мэдээллийг харууллаа. Судалгаанд хамрагдсан 15-24 насны эрэгтэйчүүдийн 3 хувь, эмэгтэйчүүдийн 1 хүрэхгүй хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд оржээ. Харин сүүлийн 12 сарын хугацаанд энэ насны залуу эмэгтэйчүүдийн 2 хувь (эрэгтэйчүүдийн хувьд маш бага) нь өөрөөсөө 10 ба түүнээс олон насаар ах хүнтэй бэлгийн хавьталд орсон байна. 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон эрэгтэйчүүд хот, хөдөө, насны бүлэг, боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшнээр төдийлөн ялгаагүй байна (15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон эмэгтэйчүүдийн хувь маш бага байгаа тул харьцуулах боломжгүй). Бүсээр авч үзвэл, Төвийн бүсийн залуу эрэгтэйчүүд 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орох нь бусад бүстэй харьцуулахад илүү өндөр (5 хувь) байв. Сүүлийн 12 сард өөрөөсөө 10 ба түүнээс олон насаар ах хүнтэй бэлгийн хавьталд орсон 15-24 насны эмэгтэйчүүдийн хувь Төвийн бүсийн (5 хувь), хөдөөгийн (3 хувь), боловсролгүй эсвэл техникийн болон тусгай мэргэжлийн дунд шатны боловсролтой (7 хувь), доогуур аж байдалтай өрхийн (4 хувь) эмэгтэйчүүдийн дунд өндөр байна.

15-49 насны эмэгтэйчүүд (15-54 насны эрэгтэйчүүд) болон 12-24 насны залуу эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн бэлгийн зан үйлтэй холбоотой, тухайлбал, бэлгийн хавьталд орж байсан, сүүлийн 12 сард бэлгийн хавьталд орсон, сүүлийн 12 сард олон хүнтэй бэлгийн хавьталд орсон, хамгийн сүүлийн бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн гэсэн үзүүлэлтүүдийг Хүснэгт НА.9 (НА.9М), НА.10 (НА.10М)-д харуулав. 15-49 насны эмэгтэйчүүд (15-54 насны эрэгтэйчүүд)-ийн 1 (8) хувь нь олон хүнтэй бэлгийн хавьталд орсон гэж хариулжээ. Тэдгээр эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн 44 (47) хувь нь хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна. Харин 15-24 насны эрэгтэйчүүдийн 13, эмэгтэйчүүдийн 1 хувь нь судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд олон хүнтэй бэлтгийн хавьталд оржээ. Сүүлийн 12 сарын хугацаанд олон хүнтэй бэлгийн хавьталд орсон залуу эрэгтэйчүүдийн 69 хувь (олон хүнтэй бэлгийн хавьталд орсон эмэгтэйчүүдийн тоо маш бага тул тэдгээрээс бэлгэвч хэрэглэсэн үзүүлэлт нь ач холбогдолгүй болно) нь хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна. Зураг НА.2-оос харахад хотын залуу эрэгтэйчүүдийг хөдөөгийнхэнтэй харьцуулахад бэлгийн хавьталд илүү их (61 ба 49 хувь) орохын зэрэгцээ бэлгийн эрсдэлтэй зан үйлтэй (14 ба 10 хувь) байх хандлагатай байгаа юм. Харин сүүлийн 12

сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон бөгөөд хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн залуу эрэгтэйчүүд хот, хөдөөгийн хувьд ижил түвшинд байна.

*Зураг НА.2: ХДХВ халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг бэлгийн зан үйл, Монгол Улс, 2010 он*



Хүснэгт НА.11 (НА.11М)-д бэлгийн хавьталд орж байсан, сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон, сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон, түүнчлэн, хамгийн сүүлд тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн гэсэн үзүүлэлтийг 15-24 насны залуу эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ээр үзүүлсэн.

Бэлгийн идэвхтэй амьдралтай 15-24 насны эрэгтэйчүүдийн 74 хувь, эмэгтэйчүүдийн 43 хувь нь тохиолдлын бэлгийн хавьталд орсон байна. Эдгээр эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн 54 (75) хувь нь хамгийн сүүлд тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн гэжээ. Хотын залуу эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн

51 (76) хувь нь тохиолдлын бэлгийн хавьталд орсон байхад энэ үзүүлэлт нь хөдөөд 24 (67) хувьтай байна. Өрхийн аж байдлын түвшин дээшлэх тутам тохиолдлын бэлгийн хавьталд орсон залуу эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэж байхад эрэгтэйчүүдийнх төдийлөн өөрлөлтгүй байгааг Хүснэгт НА.11 (НА11М)-ээс харж болно.

**Хүснэгт НА.1: Эмэгтэйчүүдийн ХДХВ/ДОХ-ын талаарх ташаа ойлголт болон ХДХВ-ийн халдварын талаарх цогц мэдлэг**

ХДХВ-ийн халдвараас сэргийлэх үндсэн аргыг мэддэг 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг эмэгтэйчүүдийн хувь, ташаа ойлголтыг үгүйсгэсэн эмэгтэйчүүдийн хувь, цогц мэдлэгийн хувь, Монгол Улс, 2010 он

|  | ДОХ-ын ташаа ойлголт               |  | Халдвараас сэргийлэх аргыг мэддэг |   | Хөёр аргыг хоёуланг нь мэддэг эмэгтэйчүүдийн хувь                 |                         | ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг |  | ХДХВ дараах замаар халдварлахгүй гэдгийг мэддэг |      | Нийтлэг байдга 2 ташаа ойлголтыг үгүйсгэсэн, мөн ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг |  | Цогц мэдлэгийн хувь <sup>1</sup> | 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо |
|--|------------------------------------|--|-----------------------------------|---|---|-------------------------|---|--|---|------|--|--|----------------------------------|--------------------------------|
|  | Дох-ын ташаа ойлголт сонсож байсан | Халдваргүй, бэлгэвчийг хэргэлэх хавьтагчтай байх | Бэлгэвчийг тогтмол хэрэглэх       | Хөёр аргыг хоёуланг нь мэддэг эмэгтэйчүүдийн хувь | ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг | Шуудуулаанд хаауулснаар | ДОХ-ын халдвартай хүнтэй хоол хүнсээ хувааж хэрэглэсэнээр         | Нийтлэг байдга 2 ташаа ойлголтыг үгүйсгэсэн, мөн ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг |   |      |  |  |                                  |                                |
| <b>Бүс</b>                                 |                                    |  |                                   |   |   |                         |   |  |   |      |  |  |                                  |                                |
| Баруун                                     | 79.8                               | 66.8   | 70.2                              | 62.8  | 64.8  | 35.3                    | 41.7  | 19.9   | 17.0  | 1158 |  |  |                                  |                                |
